



ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА



Үнэт цаас гаргагч:



Андеррайтер:





АГУУЛГА

НЭГ: ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ..... 7

1.1. Үнэт цаас гаргагчийн хуулийн этгээдийн болон тусгай зөвшөөрлийн мэдээлэл 7

1.2. Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгө болон өөрийн хөрөнгийн хэмжээ 8

1.3. Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүн 8

1.4. Үнэт цаас гаргагчийн холбоотой этгээдийн мэдээлэл 8

1.5. Үнэт цаас гаргагчийн танилцуулга 9

1.5.1. Үнэт цаас гаргагчийн эрхэм зорилго, зорилго, зорилтууд: 9

1.5.2. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа 11

1.5.3. Үнэт цаас гаргагчийн нийгмийн хариуцлага 22

1.6. Үнэт цаас гаргагчийн бүтэц, зохион байгуулалт, засаглал: 22

1.6.1. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны зохион байгуулалт 22

1.6.2. Хувьцаа эзэмшигчдийн хурал 23

1.6.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал, гишүүд 24

1.6.4. Эрх бүхий албан тушаалтан болон гүйцэтгэх удирдлага 26

1.7. Үнэт цаас гаргагчийн 2019-2023 оны санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд 27

1.7.1. Санхүү байдлын тайлангийн үзүүлэлтүүд 27

1.7.3. Санхүүгийн харьцаа үзүүлэлтүүд 30

1.7.4. Үнэт цаас гаргагчийн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл 30

ХОЁР: ХОНЖВОРТ СУГАЛААНЫ САЛБАРЫН НӨХЦӨЛ, БАЙДАЛ, БИЗНЕС ШИНЖИЛГЭЭ:..... 33

2.1. Макро эдийн засгийн нөхцөл байдал, олон улсын хандлага 33

2.2. Олон улсын болон Монгол улсын хэмжээнд дэх лоттерей буюу хонжворт сугалааны салбарын нөхцөл байдал 50

2.3. Үнэт цаас гаргагчийн дунд хугацааны бизнес төлөвлөгөөний талаар: 63

2.4. Эрсдэл, эрсдэлийн удирдлагын талаар 70

ГУРАВ: ОЛОН НИЙТЭД САНАЛ БОЛГОН ГАРГАХ ХУВЬЦАА, ТАТАН ТӨВЛӨРҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ 76

3.1. Олон нийтэд хувьцаа гаргаж, компанийн хэлбэрийг өөрчлөх шийдвэр: 76

3.2. Нийтэд санал болгох хувьцааны тоо ширхэг, санал болгох үнэ, үнэлгээний товч тайлан, хувьцаа эзэмшигчдийн бүтцийн өөрчлөлт: 77

3.3. Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалтын төлөвлөгөө, үр ашгийн тооцоолол: 79

3.4. Нийтэд санал болгож буй хувьцаагаар гэрчлэгдэх эрх үүрэг: 82

3.5. Хоёрдогч зах зээлд хувьцааны үнэ тогтворжуулах ажиллагаа: 83

3.6. Үнэт цаас гаргагчийн ногдол ашгийн бодлого 83

ДӨРӨВ: ШИНЭЭР САНАЛ БОЛГОН ГАРГАЖ БУЙ ХУВЬЦААГ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛД САНАЛ БОЛГОН ХУДАЛДАХ АЖИЛЛАГАА 86

ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУДЫН ТАНИЛЦУУЛГА 91

Хууль зүйн зөвлөх компани: 92

Аудитын компани: 93

Үнэлгээний компани: 95





МОНГОЛЫН ХӨРӨНГӨЙН БҮРТЭЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE

2023-09-04

БҮРТГЭВ-03

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

ХҮСНЭГТ

Хүснэгт 1. Гранд системс ХХК-ийн товч мэдээлэл.....	7
Хүснэгт 2. “Гранд системс” ХХК-ийн хувьцаа эзэшигчийн бүтэц.....	8
Хүснэгт 3. “Гранд системс” ХХК-ийн холбоотой этгээдийн мэдээлэл.....	8
Хүснэгт 4. “Гранд системс” ХХК-ийн эрхэм зорилго, алсын хараа.....	10
Хүснэгт 5. “Гранд системс” ХХК-ийн худалдаан гаргасан нийт сугалааны стикер,.....	12
Хүснэгт 6. “Гранд системс” ХХК-ийн эд мөнгөний хонжворт сугалааны үйл явц, зохицуулалт.....	13
Хүснэгт 7. “Гранд системс” ХХК-ийн эд мөнгөний хонжворт сугалааны програм.....	17
Хүснэгт 8. Системийн үйл ажиллагаа, боломж.....	19
Хүснэгт 9. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүдийн мэдээлэл.....	25
Хүснэгт 10. 2020-2023.06.30-ны өдрийн Орлого, үр дүнгийн тайлангийн үзүүлэлтүүд /төгрөг/.....	28
Хүснэгт 11. 2020-2023.06.30 санхүү байдлын тайлан тэнцэл /төгрөг/.....	28
Хүснэгт 12. Санхүүгийн харьцаа үзүүлэлт.....	30
Хүснэгт 13. Их хэмжээний хэлцлийн мэдээлэл.....	31
Хүснэгт 14. ТОП-20 индекс.....	48
Хүснэгт 15. АНУ-ийн томоохон хонжворт сугалаанууд.....	54
Хүснэгт 16. Эд мөнгөний хонжворт сугалааны тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгж.....	57
Хүснэгт 17. Монгол улсын томоохон хонжворт сугалаа.....	57
Хүснэгт 18. Хонжворт сугалааны хонжворын нэр, магадлал, шагнал.....	64
Хүснэгт 19. 5,000 төгрөгийн тасалбарын хонжворт сугалааны шагналын төлөвлөгөө /төгрөгөөр/.....	65
Хүснэгт 20. 2,500 төгрөгийн тасалбарын хонжворт сугалааны шагналын төлөвлөгөө /төгрөгөөр/.....	65
Хүснэгт 21. Сугалааны борлуулалт, жилээр, төгрөг.....	66
Хүснэгт 22. Сугалааны үнийн төлөвлөгөө.....	66
Хүснэгт 23. Тохирол таарах тохиолдол, жилээр, ширхэг.....	66
Хүснэгт 24. Тохирол таарсан нөхцөлд хонжворт олгох шагналын нийт дүн /төгрөгөөр/.....	67
Хүснэгт 25. Шагналын сан, төгрөг, тасалбар тус бүрээр.....	68
Хүснэгт 26. Шагналын сан, төгрөг, үлдэгдэлээр.....	68
Хүснэгт 27. Шагналын нөөц сан /төгрөгөөр/.....	68
Хүснэгт 28. Эерэг хандлага сугалааны зохион байгуулах үйл явц.....	68
Хүснэгт 29. Сугалааны стикер гаргах төлөвлөгөө.....	70
Хүснэгт 30. Хүний нөөц, цалингийн зардлын төлөвлөгөө.....	70
Хүснэгт 31. Эрсдэлийн удирдлагын хөтөлбөр.....	71
Хүснэгт 32. Эрсдэлийн үнэлгээ.....	71
Хүснэгт 33. Эрсдэлийн үнэлгээ.....	71
Хүснэгт 34. Эрсдэлийн төрөл.....	72
Хүснэгт 35. Үнэт цаасны товч танилцуулга.....	77
Хүснэгт 36. Олон нийтэд хувьцаа гаргасны дараах хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц:....	79





Хүснэгт 37. Олон нийтэд санал болгон гаргасны дараах хувьцаа эзэмшигчдийн бүтэц:....	79
Хүснэгт 38. Үнэт цаасаар татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт	79
Хүснэгт 39. Төлөвлөсөн орлогын тайлан, төгрөг	80
Хүснэгт 40. Төлөвлөсөн санхүүгийн тайлан, төгрөг	81
Хүснэгт 41. Анхдагч зах зээлийн арилжааны хуваарилалт	86
Хүснэгт 42. Хувьцаа гаргах үйл ажиллагааны хуваарь.....	87
Хүснэгт 43. Бусад үнэт цаасны компанийн харилцагчдын мөнгө байршуулах заавар.....	89

ЗУРАГЛАЛ

Зураглал 1. “Гранд системс” ХХК-ийн хамтран ажилладаг аж ахуй нэгжүүд	12
Зураглал 2. “Гранд системс” ХХК-ийн бүтэц зохион байгуулалт	22
Зураглал 3. Mega millions сугалааны загвар	51
Зураглал 4. Сугалааны зах зээлийн өсөлтөд нөлөөлөх хүчин зүйлс.....	53
Зураглал 5. Хувьцаа эзэмшигчдийн шийдвэр.	76
Зураглал 6. Анхдагч зах зээлийн арилжааны ерөнхий схем.....	87
Зураглал 7. Үнэт цаас гаргагчийн анхдагч зах зээлд оролцох заавар.....	89

ГРАФИК


График 1. Дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөлөл	34
График 2. Инфляцийн түвшин, төсөөлөл	35
График 3. Дэлхийн аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн, худалдааны хэмжээний өөрчлөлт... ..	35
График 4. Бодлогын хүүгийн динамик	36
График 5. Хөрөнгийн зах зээлийн голлогч индексүүд.....	37
График 6. Засгийн газрын урт хугацааны бондын өгөөжийн түвшин.....	37
График 7. Мөнгөний нийлүүлэлт	40
График 8. Улсын нэгдсэн төсвийн орлого, зарлага	41
График 9. Зээл, салбараар	42
График 10. Чанаргүй, анхаарал хандуулах зээлийн нийт зээлд эзлэх хувь	43
График 12. Даатгалын салбарын хөрөнгө, нөөц сан, нөхөн төлбөр (тэрбум төгрөг).....	44
График 13. ББСБ-ын нийт хөрөнгө ба зээл (тэрбум төгрөг).....	44
График 14. ББСБ-ын зээлийн чанар, эхний хагас жилийн байдлаар.....	44
График 15. ХЗХ-дын салбарын нийт хөрөнгө, Хадгаламж, зээлийн чанар (тэрбум төгрөг).....	45
График 16. ХЗХ-ийн чанаргүй зээлийн ангилал.....	46
График 17. Зах зээлийн үнэлгээний ДНБ-д эзлэх хувь хэмжээ.....	47
График 18. Хөрвөх чадвар /хувиар/	47
График 19. Хөрөнгийн зах зээлийн анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаа.....	49
График 20. Хөрөнгө оруулагчдын бүтэц /арилжаанд эзлэх хувиар/.....	50
График 21. Монгол улсын хүн ам, түүний бүтэц.....	59
График 22. Өрхийн орлого, зарлага	60





ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН АНХААРАЛД



Үнэт цаас гаргагч “Гранд системс” ХХК нь Монгол Улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хороо, “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн холбогдох журмуудын дагуу шинээр хувьцаа гарган олон нийтэд санал болгож байна.

Энэхүү Үнэт цаасны танилцуулга нь Хөрөнгө оруулагч таны хараат бус үнэлгээ гаргах, шинжилгээ хийхийг орлохгүй бөгөөд тэдгээрт тооцогдохгүй. Хөрөнгө оруулагч та Үнэт цаас гаргагч болоод түүний гаргаж буй үнэт цаас, холбогдох мэдээллийн талаар өөрийн хөндлөнгийн судалгаа шинжилгээг хийсний үндсэн дээр хөрөнгө оруулалт хийж буй бөгөөд санхүүгийн, хуулийн болон бусад зохих мэргэжлийн зөвлөгөөг авахыг зөвлөж байна.

Үнэт цаасыг Санхүүгийн зохицуулах хороо болон “Монголын хөрөнгийн бирж” ХК бүртгэсэн нь уг үнэт цаасны эрсдэлийн талаар аливаа баталгаа гаргаагүй болохыг анхаарах нь зүйтэй. Энэхүү үнэт цаасыг худалдан авах замаар хөрөнгө оруулалт хийх нь хөрөнгө оруулагч таны хувьд ЯМАГТ ЭРСДЭЛТЭЙ үйлдэл байдгийг онцгойлон анхаарч, үнэт цаасны танилцуулга, үнэт цаас гаргах ажиллагааг сайтар анхааран судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргахыг зөвлөж байна.

Тус үнэт цаасны танилцуулгад хөрөнгө оруулагч таны хувьцаа худалдан авах шийдвэр гаргалтад туслах, шаардлагатай гэсэн бүхий л мэдээллийг оруулахыг зорилоо. Хөрөнгө оруулагч таны шийдвэр гаргалтад танилцуулгад тусгагдсан мэдээллээс бусад дэлгэрэнгүй мэдээлэл шаардлагатай буюу лавлах тодруулах зүйлсийг үнэт цаас гаргагч “Гранд системс” ХХК, андеррайтер “Стандарт инвестмент ҮЦК” ХХК компанид хандана уу.





ҮНЭТ ЦААСНЫ ХУРААНГУЙ ТАНИЛЦУУЛГА:

Үнэт цаас гаргагч	“Гранд системс” ХХК
Үнэт цаасны төрөл	Энгийн хувьцаа
Нийт гаргасан хувьцааны тоо	3,000,000 ширхэг
Шинээр нийтэд санал болгон гаргаж буй хувьцааны тоо	750,000 ширхэг
Шинээр нийтэд санал болгон хувьцаа гаргасны дараах хувьцааны тоо ширхэг	3,750,000 ширхэг
Олон нийтэд санал болгож буй хувьцааны хувь	20 хувь
Нэгж хувьцааны үнэ	900 төгрөг
Татан төвлөрүүлэх хөрөнгийн дүн	675,000,000
Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт	Үйл ажиллагаагаа өргөжүүлэх, техникний шинэчлэл хийх, програм хангамж хөгжүүлэх
Компанийн зах зээлийн үнэлгээ	2,700,000,000 төгрөг
Хувьцааг олон нийтэд санал болгох хэлбэр	Арилжаа эрхлэх байгууллага
Хувьцааг олон нийтэд санал болгох арга	Тогтоосон үнийн арга





ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

1.2. Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгө болон өөрийн хөрөнгийн хэмжээ: “Гранд системс” ХХК-ийн хувьцаа эзэмшигчийн 2022 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 9/13 тоот шийдвэрээр компанийн үйл ажиллагааг өргөжүүлэх хүрээнд хувь нийлүүлсэн хөрөнгийг 299,990,000 төгрөгөөр нэмэгдүүлж, 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 3,000,000 ширхэг энгийн хувьцаатай, хувь нийлүүлсэн хөрөнгийг 300,000,000 төгрөг байхаар шийдвэрлэж, улсын бүртгэлд бүртгүүлж, дүрэмд өөрчлөлт оруулсан. Үнэт цаас гаргагчийн өөрийн хөрөнгө нь 2020 оны санхүүгийн тайланд 91,041,883 төгрөг, 2021 онд 110,270,538 төгрөг, 2022 оны аудитлагдсан санхүүгийн тайлангаар өөрийн хөрөнгө 423,465,135 төгрөг, 2023 оны 06 сарын 30-ны өдрийн байдлаар 457,800,324 төгрөг байсан бөгөөд үүний 65.5 хувь буюу 300,000,000 төгрөг нь хувьцаат капитал, 34.5 хувь буюу 157,800,324 төгрөг хуримтлагдсан ашгаас бүрдэж байна. Өөрийн хөрөнгийн хэмжээ сүүлийн 3 жилийн хугацаанд тогтмол нэмэгдэхэд компанийн хуримтлагдсан ашгийн хэмжээ тасралтгүй өсөж, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нэмэгдсэн нөлөөлжээ.

1.3. Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүн: Компанийн тухай хууль, Улсын бүртгэлийн хуулийн этгээдийн бүртгэлд бүртгэгдсэн дүрмээс үзэхэд хувьцаа эзэмшигчдийн бүтцэд 1 хуулийн этгээд, 2 иргэн бүртгэлтэй байгаа бөгөөд хувьцаа эзэмшигчдийн хувь хэмжээг хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 2. “Гранд системс” ХХК-ийн хувьцаа эзэмшигчийн бүтэц

№	Хувьцаа эзэмшигч	Хувьцааны тоо	Нэрлэсэн үнэ	Нийт үнэ	Хувь эзэмшил
1.	“Баялаг Хонд” ХХК	2,670,000	100	267,000,000	89.0%
2.	Нацагдоржийн Сүрэнхорлоо	300,000	100	30,000,000	10.0%
3.	Наваантаяагийн Лхамсүрэн	30,000		3,000,000	1.0%
	Нийт	3,000,000	100	300,000,000	100.0%

1.4. Үнэт цаас гаргагчийн холбоотой этгээдийн мэдээлэл: УИХ-аас 2013 онд баталсан Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.30 заалтад “холбогдох этгээдийг” тодорхойлж, мөн хуулийн 10.5.8 дугаар заалтад “үнэт цаасны танилцуулгад үнэт цаас гаргагчийн холбогдох этгээдийн тухай мэдээллийг тусгахаар” заасан бөгөөд үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчид болох “Баялаг Хонд” ХХК, Н.Сүрэнхорлоо, Н.Лхамсүрэн нарын холбоотой этгээдийн хяналтын багцыг эзэмшдэг хуулийн этгээдийн мэдээллийг хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 3. “Гранд системс” ХХК-ийн холбоотой этгээдийн мэдээлэл

Овог,нэр	Холбоо хамаарал бүхий хуулийн этгээдийн оноосон нэр	Үндсэн үйл ажиллагааны чиглэл	Холбоо хамаарал бүхий хуулийн этгээдэд эзэмшдэг хувьцааны хэмжээ





МОНГОЛЫН ХӨСӨН ДЭВЭЭ
MONGOLIAN STOCK EXCHANGE

2023-09-04

БҮРТГЭВ-03

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

“Баялаг Хонд” ХХК	Охин хараат компани байхгүй	Менежментийн зөвлөгөө	Байхгүй
Н.Сүрэнхорлоо	Холбоо хамаарал бүхий компанийн хувьцааг эзэмшдэггүй	-	Байхгүй
Н.Лхамсүрэн	Холбоо хамаарал бүхий компанийн хувьцааг эзэмшдэггүй	-	Байхгүй

1.5. Үнэт цаас гаргагчийн танилцуулга: “Гранд системс” ХХК нь 2018 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр програм хангамж, мэдээлэл технологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар үүсгэн байгуулагдаж, улсын бүртгэлд бүртгэгдсэн. Улмаар үнэт цаас гаргагч нь үйл ажиллагаагаа өргөжүүлж, өнгөрсөн хугацаанд хөгжүүлсэн програм хангамжийн шийдэл, боломж нөхцөлд тулгуурлан Сангийн сайдын 2020 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн 113 тоот тушаалаар “Эерэг хандлага” хонжворт сугалаа гаргах тусгай зөвшөөрөл авсан.

Тусгай зөвшөөрлийн хүрээнд өнгөрсөн хугацаанд үндэсний томоохон үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллаж, тэдгээр аж ахуйн нэгжүүдийн бүтээгдэхүүн, үйлчилгээний борлуулалтыг нэмэгдүүлж дэмжих зорилгоор сугалаат хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Үнэт цаас гаргагч нь одоогийн байдлаар 10 гаруй үндэсний аж ахуйн нэгжүүдтэй хамтран урамшууллын хөтөлбөрийг өөрсдийн хөгжүүлсэн програм хангамж, тоног төхөөрөмжийг ашиглан хэрэгжүүлж, 500 гаруй сая төгрөгийн урамшуулалт хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлж аж ахуйн нэгжүүдийн эцсийн хэрэглэгчдэд хүргэлээ.

Үнэт цаас гаргагч нь цаашид өөрсдийн хуримтлуулсан туршлага, програм хангамж дээрээ үндэслэн үйл ажиллагаагаа өргөжүүлж, нийт ард иргэдийн дунд эд мөнгөний хонжворт сугалаа явуулахаар зорьж байна. Ингэхдээ тоглогчдын сонирхолд тулгуурласан, өндөр шагналын сантай, цагийг хөгжилтэй өнгөрөөх мөнгөний хонжворт сугалааг Монгол улс даяар нээлттэй, шударга явуулахаар зорьж байна. Үнэт цаас гаргагч нь өргөжүүлэх боломжтой вэб технологитой сугалааны програмтай бөгөөд уг программаар дамжуулан сугалааг тогтвортой явуулж, ингэснээр уламжлалт сугалаа зохион байгуулах арга барилыг өөрчлөн орчин үеийн технологид суурилсан сонгодог лотто (эд мөнгөний хонжворт сугалаа)-г зах зээлд нэвтрүүлэн ажиллахаар төлөвлөж байна. 2022 оны 11 дүгээр сард “Гранд системс” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар компанийн хувьцааны тодорхой хувийг арилжаа эрхлэх байгууллагаар дамжуулан олон нийтэд санал болгон гаргаж, санхүүжилт татан үйл ажиллагаагаа өргөжүүлэх түүхэн шийдвэрийг гаргаад байна.

1.5.1. Үнэт цаас гаргагчийн эрхэм зорилго, зорилго, зорилтууд: Үнэт цаас гаргагч нь 2018 онд үүсгэн байгуулагдаж, үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш мэдээлэл технологийн дэвшилтэд шийдлийг үйл ажиллагаандаа ашиглаж, сугалаат хөтөлбөр явуулж эхэлсэн. Үнэт цаас гаргагч нь цаашид өөрсдийн хуримтлуулсан туршлага, програм хангамж дээрээ үндэслэн үйл ажиллагаагаа өргөжүүлж, нийт ард иргэдийн дунд эд мөнгөний хонжворт сугалаа явуулахаар зорьж байна. Үнэт цаас гаргагч нь эрхэм зорилго, үнэт зүйл, зорилгоо дараах байдлаар тодорхойлсон.






ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

харилцагчдынхаа эрэлт хэрэгцээнд тулгуурлан сугалааны шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд байнга нэвтрүүлж ажиллаж ирсэн. 2020 онд үндэсний үйлдвэрлэгч томоохон аж ахуйн нэгжүүдтэй хамтран сугалаат хөтөлбөрийг амжилттай зохион байгуулж эхэлсэн бөгөөд тус сугалаат хөтөлбөр нь хурдтай өсөн нэмэгдэж, одоогоор 10 гаруй аж ахуйн нэгжтэй хамтран урамшууллын хөтөлбөрийг Ecode-тэй хамтран хэрэгжүүлж, 500.0 гаруй сая төгрөгийн урамшууллыг хамтран ажилласан байгууллагуудын эцсийн хэрэглэгчдэд хүргэлээ.

- **Технологийн дэвшилтэй хөл нийлүүлэн алхдаг:** 2019 онд Ecode-тай хамтран үндэсний томоохон компаниудын сугалаат хөтөлбөрийг зохион байгуулж эхэлсэн бөгөөд 2022 оноос олон улсын жишгийн дагуу сонгодог төрлийн лотто сугалааг зохион байгуулахаар зорьж, вэбэд суурилсан програм хангамжтай болсон. Энэхүү сугалааны үндсэн програм нь тоглогчийг бүртгэх, сугалааны тасалбар авах, төлбөр төлөх, түүний арын бүртгэл, тооцоо зэрэг функцуудыг багтаасан цогц систем юм. Компани нь тоглогчдыг сугалаа тоглож оролцоход шаардлагатай цогц функц бүхий сугалааны үндсэн програмтай.
- **Засаглал, ил тод байдал** “Гранд системс” ХХК нь компанийн сайн засаглалын зарчмыг удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагаандаа нэвтрүүлж, Монгол улсын сугалааны зах зээлд жишиг аж ахуйн нэгж болохоор зорьж байгаа бөгөөд компанийн сайн засаглалын хамгийн чухал бүрэлдэхүүн нь чадварлаг мэргэшсэн хараат бус гишүүнтэй төлөөлөн удирдах зөвлөлийг байгуулж, хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчдын эрх ашиг, сонирхлын зөрчлөөс сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх явдал юм. Тиймээс үнэт цаас гаргагч нь 2022 онд ердийн 3, хараат бус 2 гишүүний бүрэлдэхүүнтэй төлөөлөн удирдах зөвлөлийг байгуулан ажиллаж байгаа бөгөөд төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд нь банк санхүү, эдийн засаг, бизнесийн удирдлага, хууль эрх зүй, математик, компьютерын чиглэлээр мэргэшсэн бүрэлдэхүүнтэй. Мөн ажиллагсад нь компанийн хамгийн чухал үнэт зүйл бөгөөд байгууллагаараа бахархдаг, байгууллагын ирээдүйг тодорхойлогч, чадварлаг, манлайлагч, сэтгэл ханамжтай баг хамт олныг бүрдүүлж ажиллахыг зорьж ирсэн.
- **Үүсгэн байгуулагдсан цагаасаа хойш тасралтгүй ашигтай ажиллаж байна.** Үнэт цаас гаргагч нь 2019 оноос үйл ажиллагаа явуулж эхэлсэн бөгөөд тус онд 117.4 сая төгрөгийн татварын дараах ашигтай ажиллаж байсан бол 2023 оны 06 дугаар сарын байдлаар 34.3 сая төгрөгийн ашигтай ажилласан байна. Энэ хугацаанд Ковид-19 цар тахалтай холбоотой эдийн засгийн хүнд хэцүү нөхцөлтэй тулгарч байсан ч удирдлагын багийн ур чадвар, мэдрэмж, туршлага зэргээс шалтгаалан тасралтгүй ашигтай ажилласан.

1.5.2. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа: Үнэт цаас гаргагч нь үндэсний томоохон аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллах гэрээгээр тэдгээр аж ахуйн нэгжүүдийн бүтээгдэхүүн, үйлчилгээний борлуулалтыг дэмжих зорилготой сугалаат худалдааны хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажилладаг. Урамшууллын хөтөлбөр нь үндэсний үйлдвэрлэгч, импортлогч аж ахуйн нэгжүүдийн үндсэн хэрэглэгчдийг урамшуулах, тэдгээрийн үйл хөдлөлийг судлах, нэмэгдүүлэх зорилготой бөгөөд үнэт цаас гаргагчтай хамтарснаар цаг хугацаа, програм





ҮНЭТ ЦААСНЫ ТАВИЛЦУУЛГА

хангамжийн хөгжүүлэлтийн зардлыг хэмнэж, богино хугацаанд үр дүнд хүрэх боломжийг олгодог.

Үнэт цаас гаргагч нь өнөөгийн байдлаар 10 гаруй аж ахуйн нэгжүүдтэй хамтран сугалаат урамшууллын хөтөлбөрийг Ecode-тай хамтран амжилттай зохион байгуулж байгаа бөгөөд 500.0 орчим сая төгрөгийн урамшууллыг хамтран ажилласан байгууллагуудын эцсийн хэрэглэгчдэд хүргэсэн. Үнэт цаас гаргагч нь сугалаат худалдааны хөтөлбөрийн хүрээнд хөтөлбөрийг эхлэхээс эцсийн тохирол шалгаруулах хүртэлх хугацаанд сугалаат хөтөлбөрийг холбогдох хууль тогтоомж, төрийн эрх бүхий байгууллагаас баталсан стандарт, нөхцөл шаардлагын хүрээнд зохион байгуулж, найдвартай байдлыг ханган ажилладаг.

Зураглал 1. “Гранд системс” ХХК-ийн хамтран ажилладаг аж ахуй нэгжүүд



Түмэн шувуут ХК
Үндэсний мөнлай өндөг
үйлдвэрлэгч

f t in



Сүү ХК
Үндэсний ууган сүү үйлдвэрлэгч

f t in



Дөрвөн өлзий ХХК
Үндэсний хүнс үйлдвэрлэгч

f t in



Анунгоо ХХК
Procter and Gamble компанийн
албан ёсны дистрибуитор

f t in



Бимэкс холдинг ХХК
Олон улсын худалдаа,
үйлдвэрлэл, үйлчилгээ үзүүлэгч

f t in



Женераль Инсайтс ХХК
Худалдаа үйлдвэрлэл үйлчилгээ

f t in

Үнэт цаас гаргагч нь 2022 оны байдлаар 10 компанитай хамтран ажиллаж, 500.0 сая төгрөгийн шагналын сантай сугалаат хөтөлбөрийг зохион байгуулж, 2020 онд 5.2 сая, 2021 онд 2.6 сая, 2022 онд 4.9 сая, 2023 оны хагас жилээр 2.8 сая ширхэг сугалааны стикер гаргаж, 2020 онд 126.9 сая, 2021 онд 63.8 сая, 2022 онд 120.7 сая, 2023 оны хагас жилээр 72.7 сая төгрөгийн орлого олсон.

Хүснэгт 5. “Гранд системс” ХХК-ийн худалдаан гаргасан нийт сугалааны стикер, түүний орлого

Үзүүлэлт	2020	2021	2022	2023-6-30
Сугалааны тоо	5,288,805	2,555,850	4,829,013	2,770,563
Орлого	126,931,322	63,896,260	120,725,326	72,727,272

Үнэт цаас гаргагч нь өөрсдийн хуримтлуулсан туршлага, програм хангамж дээрээ үндэслэн үйл ажиллагаагаа өргөжүүлж, нийт ард иргэдийн дунд “Эерэг хандлага” эд мөнгөний хонжворт сугалаа явуулахаар зорьж байна. Энэхүү эд мөнгөний хонжворт сугалаа нь тоглогчдын сонирхолд тулгуурласан, өндөр шагналын сантай, цагийг хөгжилтэй өнгөрөөх боломжтой байх юм. Үнэт цаас гаргагч нь өргөжүүлэх боломжтой вэб технологитой сугалааны програм хөгжүүлсэн бөгөөд уг программаар дамжуулан сугалааг тогтвортой явуулна. Ингэснээр удамжлалт сугалаа зохион байгуулах арга барилыг өөрчлөн орчин





үйийн технологид суурилсан сонгодог лотто (эд мөнгөний хонжворт сугалаа)-г зах зээлд нэвтрүүлж ажиллах юм.

Үнэт цаас гаргагч нь “Эерэг Хандлага” эд мөнгөний хонжворт сугалааг зохион байгуулах, тасалбар худалдан борлуулах болон хүчингүй болгох, сугалааны тохирлын хонжворыг олгох, хадгалах ажиллагааг өөрсдийн програм хангамжид түшиглэн зохион байгуулах бөгөөд цаашид үндэсний хэмжээний нээлттэй, ил тод, тогтвортой үйл ажиллагаа явуулдаг сонгодог лотто (эд мөнгөний хонжворт сугалаа)-г зах зээлд нэвтрүүлж ажиллахаар төлөвлөж байна.

Үнэт цаас гаргагч нь 2022 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 22/3 тоот тогтоолын 1 дүгээр хавсралтаар “Эд мөнгөний хонжворт сугалааны журам”-ыг баталж, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Эд мөнгөний хонжворт сугалааны үйл явц, зохицуулалтыг хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 6. “Гранд системс” ХХК-ийн эд мөнгөний хонжворт сугалааны үйл явц, зохицуулалт

Үзүүлэлтүүд	Зохицуулалт
Нэр томъёо:	“Тасалбар” сугалаа зохион байгуулагчийн нэгдсэн системээс цахим хуудас, аппликэйшин, утасны мессеж болон бусад борлуулалтын сувгаар дамжуулан борлуулагдах сугалааны тасалбар; “Тохирол” сугалааны тохирлыг зориулалтын тоног төхөөрөмж ашиглан телевиз эсвэл цахим хуудас зэрэг олон нийтэд хүртээмжтэй сувгаар шууд дамжуулан азтан шалгаруулах үйл ажиллагаа буюу сугалааны төхөөрөмжөөс сонгогдон гарч ирсэн тоо; “Хонжвор” сугалааны тохирлын үр дүнд тасалбарт бичигдсэн тоо, тохирлын үр дүнд сонгогдсон тоотой ижил байх үед оролцогчид олгох шагнал; “Аппликэйшн” гэж Сугалаа зохион байгуулагчтай байгуулсан гэрээний үндсэн дээр Сугалаа худалдан авах цэсийг дотор нь суулгаж, сугалаа худалдан авах боломжтой гар утас болон бусад ухаалаг төхөөрөмжид суурилсан аппликэйшн, тасалбар борлуулалтын цахим платформыг; “Цахим хуудас” гэж Сугалаа зохион байгуулагчийн удирдан ажиллуулдаг сугалаа худалдан авах боломжтой, сугалааны талаар албан ёсны мэдээлэл бүхий цахим хуудсыг “Сугалааны машин” гэж 1-43 хүртэлх дугаартай 43 ширхэг бөмбөлгөөс 6 ширхэг бөмбөлгийг нэг нэгээр нь санамсаргүй байдлаар үлээлгэн гаргах замаар сугалааны тохирол, хонжвор тодруулах зориулалттай, холбогдох стандарт, шаардлага хангасан тунгалаг хоргон бүтэцтэй зориулалтын тоног төхөөрөмж; “Дотоод хяналт ба аудит” компанийн борлуулсан тасалбарын орлогын санг удирдах, хянах эрх бүхий компанийн хяналтын нэгж;
Сугалааны тасалбарын загвар	Сугалааны тасалбар нь эхний хүснэгтэд байх 1-43 хүртэлх тооноос оролцогч 6 тоог сонгон хоёр дахь хүснэгтэд байх 6 ширхэг нүдэнд оруулах зориулалттай загвартай байна.





- 3. **3 дугаар байр:** Сугалааны дугаарын 4 тоо нь тохирлын 4 тоотой утгаараа таарч байвал 3 дугаар шатлалын хонжвор;
- 4. **4 дүгээр байр:** сугалааны дугаарын 3 тоо нь тохирлын 3 тоотой утгаараа таарч байвал 4 дүгээр шатлалын хонжвор;

Ингэхдээ тоглогчийн сонгосон дугаар нь хонжворт тохирлын дугаарын тоотой дараалал харгалзахгүй таарах нөхцөлтэй юм.

Сугалааны тохирол таарах магадлал:

	Шагнал	Магадлал	
		2,500 төгрөгийн тасалбар	5,000 төгрөгийн тасалбар
Супер	1-р байр	1:6,096,454	1:6,096,454
	2-р байр	1:27,462	1:27,462
Үндсэн	3-р байр	1:610	1:610
	4-р байр	1:39	1:39

Хонжвор олгох, төлөх үед тасалбар шалгах, магадлах дүрэм

Оролцогчийн нэгдсэн системд бүртгүүлж худалдан авсан, бөглөсөн бүх тасалбар оролцогчийн дансанд хадгалагдана. Оролцогч сугалааны нэгдсэн системд цахим хуудас, аппликэйшн эсвэл мессеж илгээж, эсвэл зохион байгуулагчаас зарласан бусад сувгаар бүртгүүлнэ.

Сугалаа зохион байгуулагч нь нэгдсэн системээс борлогдсон тасалбаруудыг тухайн долоо хоногийн ням гарагийн өглөө 11:30 цагаар тасалбар болгож тайлангийн системд бүртгэнэ.

Сугалааны тохирол нь явагдсанаас хойш ажлын 3 өдрийн дотор мэдэгдлийг тохирол таарсан оролцогчид илгээх бөгөөд сугалааны азтан нь сугалааны тохирлоор хожсон хонжвор авах тухай хүсэлтээ ажлын 20 хоногийн дотор нэгдсэн системд гаргаж, баталгаажуулна. Баталгаажуулалт хийгдсэнээс хойш ажлын 5 өдрийн дотор хонжворын мөнгийг оролцогчийн өөрийн нэр дээрх харилцах дансанд шилжүүлнэ.

Тохирлын хонжвор хожсон оролцогч хүссэн тохиолдолд өөрийн биеэр сугалаа зохион байгуулагчийн оффист иргэний үнэмлэх, баримт бичгээ авчран баталгаажуулсны үндсэн дээр шагналыг авч болох бөгөөд нэг шатлалын хонжворт хэд хэдэн ялагч тодорсон тохиолдолд тухайн шатлалын шагналын санг азтаны тоонд тэнцүү хувааж олгоно.

Сугалааны хонжвор олгохгүй байх нөхцөлийг сугалаа зохион байгуулагчийн нарийвчилсан журмаар зохицуулж, оролцогч нарт танилцуулах боломжоор хангана.

Борлуулагдсан болон борлуулагдаагүй

Сугалаа зохион байгуулагч нь хуанлийн 7 хоног тутамд энэ журамд заасан Тасалбарын давтагдахгүй дугаар бүхий 2,500 төгрөгийн тасалбар





сугалааны тасалбарыг бүртгэх, хураах, хадгалах журам	20,000 ширхэг, 5,000 төгрөгийн тасалбар 10,000 ширхэг, нийт 30,000 ширхгээс илүүгүй сугалааг худалдаанд гаргана. Борлуулалтад гаргах сугалааны тоог нэмэгдүүлэх, бууруулах шийдвэрийг жилд эсвэл, сар, 7 хоног тутам гүйцэтгэх удирдлагын шийдвэрээр өөрчлөлт оруулна. Тасалбар болгосон хугацаанаас хойш борлуулагдаагүй үлдсэн сугалааны тасалбарыг хүчингүй болсонд тооцно.																											
Тохирлын ялагчийн аваагүй хонжворыг хадгалах, хугацаа дууссаны дараа хүлээлгэн өгөх журам	Хонжворыг олгох хугацаанд азтан баталгаажуулалт хийгээгүй болон дансны мэдээллээ оруулж хүлээн аваагүй хонжворын 50 хувийг дараагийн тохирлын хонжворын шагналын санд шилжүүлнэ. Хонжворын ялагчийн шагналыг ажлын 20 хоногоос удаан хугацаагаар хадгалахгүй, оролцогч хүндэтгэн үзэх шалтгаанаар тохирлын мөнгөн шагнал авах хүсэлтийг заасан хугацаанд баталгаажуулаагүй бол холбогдох нотлох баримт, эрх бүхий байгууллагын тодорхойлолтыг ирүүлэн дахин хүсэлт гаргах эрхтэй.																											
Сугалааны хонжворын шагналын сан, орлого	<p>Сугалаа зохион байгуулагч нь тухайн жилд олгох сугалааны хонжворын хэмжээ, супер болон үндсэн сугалааны хонжворын хувь хэмжээг жил</p> <table border="1" data-bbox="482 1003 1428 1211"> <thead> <tr> <th rowspan="2">Таах тоо</th> <th rowspan="2">Магадлал</th> <th colspan="2">Шагнал</th> <th rowspan="2">Тухайн төрлийн тасалбарын борлуулалтын %</th> </tr> <tr> <th>2,500 тасалбар</th> <th>5,000 тасалбар</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>6</td> <td>1:6,096,454</td> <td>10,000,000</td> <td>100,000,000</td> <td>44.0%</td> </tr> <tr> <td>5</td> <td>1:27,462</td> <td>2,500,000</td> <td>5,000,000</td> <td>1.0%</td> </tr> <tr> <td>4</td> <td>1:610</td> <td>25,000</td> <td>50,000</td> <td>2.0%</td> </tr> <tr> <td>3</td> <td>1:39</td> <td>2,500</td> <td>5,000</td> <td>3.0%</td> </tr> </tbody> </table> <p>бүрийн эхний сард багтааж батална. Сугалаа зохион байгуулагч нь сугалааны тасалбарын орлогыг тохирлын шагналд хуваарилах 2 төрлийн шагналын сантай байх бөгөөд тухайн долоо хоногийн сугалааны борлуулалтын орлогын 50-аас багагүй хувийг тус санд төвлөрүүлнэ.</p> <ul style="list-style-type: none"> ✓ Супер шагналын сан: Супер шагнал буюу жэкупот хонжворын шагналын сан бөгөөд тус санд тухайн тохирлын борлуулалтын орлогын 44-өөс багагүй хувийг тус санд төвлөрүүлэх; ✓ Үндсэн шагналын сан: Супер буюу жэкупот хонжворын сангаас бусад буюу 2,3,4 дүгээр байрны хонжворын шагналын сан бөгөөд бусад шагналын сангийн мөнгөн хөрөнгийн доод үлдэгдэл тухайн тохирлын үед борлуулсан сугалааны тасалбарын борлуулалтын 6 хувиас багагүй байх; ✓ Шагналын нөөц сан: Тус сан нь хүчин төгөлдөр боловч системийн алдаа эсвэл бусад шалтгаан, урьдчилан тооцоолоогүй нөхцөл байдлын улмаас гарсан шагналын нэхэмжлэлийн төлбөрийг барагдуулахад ашиглах сан бөгөөд тус санд 7 хоногийн сугалааны борлуулалтын орлогын 5-аас багагүй хувийг төвлөрүүлнэ. 	Таах тоо	Магадлал	Шагнал		Тухайн төрлийн тасалбарын борлуулалтын %	2,500 тасалбар	5,000 тасалбар	6	1:6,096,454	10,000,000	100,000,000	44.0%	5	1:27,462	2,500,000	5,000,000	1.0%	4	1:610	25,000	50,000	2.0%	3	1:39	2,500	5,000	3.0%
Таах тоо	Магадлал			Шагнал			Тухайн төрлийн тасалбарын борлуулалтын %																					
		2,500 тасалбар	5,000 тасалбар																									
6	1:6,096,454	10,000,000	100,000,000	44.0%																								
5	1:27,462	2,500,000	5,000,000	1.0%																								
4	1:610	25,000	50,000	2.0%																								
3	1:39	2,500	5,000	3.0%																								





Сугалаанд оролцох давуу тал	<p>Тоглогчид “Эерэг хандлага” хонжворт сугалааг компьютер, гар утас ашиглан хүссэн үедээ тоглох боломжтой бөгөөд ингэснээр тоглогчид хялбар, тав тухтай байдлыг бий болгодог. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Хаанаас ч тоглох боломжтой; • Цаг хугацаанд баригдахгүй, 24 цагийн турш хүссэн үедээ тоглох • Өөрийн нэр дээр бүртгэл үүсгэх; • Сугалааг худалдан авахдаа хэтэвч эсвэл QR-код ашиглан төлбөр төлөх; • Хэтэвчиндээ орлого хүлээн авах боломжтой; • Бүртгэлтэй банкны дансандаа шагналаа авах; • Худалдан авсан сугалаа, хожсон хонжвор зэрэг өөрийн үүсгэсэн түүхийг хянах • Шударга, нээлттэй, ил тод.
-----------------------------	---

Үнэт цаас гаргагчийн эд хөрөнгийн хонжворт сугалаа зохион байгуулдаг програм хангамж талаар: Вэб технологид суурилсан хонжворт сугалаа нь Дэлхий даяар тоглогчдын таашаалыг хүртсэн хамгийн түгээмэл бооцоот тоглоомын нэг болж байгаа бөгөөд “Гранд системс” ХХК нь мэдээлэл технологийн дэвшлийг ашиглан хонжворт сугалааны үндсэн системийн дэд бүтцийг хөгжүүлж, хүн амын орлогын төвшин, газар зүйн байршил, цаг хугацаанаас үл хамааран найдвартай, түргэн шуурхай, хөгжилтэй хонжворт тоглоом тоглох боломжийг бий болгоод байна.


Сугалааны үндсэн систем нь тоглогчийн бүртгэл үүсгэх, сугалааны тоог таах, сугалаа худалдан авах, сугалааны мөнгийг төлөх, авсан сугалаагаа хянах, түүхээ харах, хожсон шагналыг дансандаа авах боломжийг тоглогчдод олгодог цогц систем юм. Тоглогч интернэт ашиглан компьютер, гар утсаараа өөрсдийн хувийн орон зайд хүссэн үедээ “Эерэг хандлага” хонжворт сугалааг тоглох боломжтой. Ингэснээр тоглогчид хялбар, тав тухтай байдлыг мэдрэх боломжтой бөгөөд компанийн хувьд зардал багатайгаар тоглогчдын тоог хязгааргүй нэмж, үйл ажиллагаагаа богино хугацаанд өргөжүүлэх боломжтой. Цаашлаад ухаалаг утасны хэрэглээ нэмэгдэхийн хирээр вэб технологи дээр суурилсан сугалаат тоглоомын зах зээл нэмэгдэнэ гэсэн хүлээлттэй байна.

Үнэт цаас гаргагчийн программ нь “Гранд системс” ХХК –ийн “Эерэг Хандлага” эд мөнгөний хонжворт сугалааны тасалбар худалдан борлуулах болон хүчингүй болгох, сугалааны тохирлын хонжворыг мэдэгдэх, хадгалах, түүнтэй холбоотой тайлан мэдээ гаргахад зориулагдсан систем юм.

Хүснэгт 7. “Гранд системс” ХХК-ийн эд мөнгөний хонжворт сугалааны програм

Үзүүлэлт	Тайлбар
Системийн ерөнхий мэдээлэл	<ul style="list-style-type: none"> • Грандлотто систем нь эд хөрөнгийн хонжворт сугалаа болон мөнгөн хөрөнгийн хонжворт сугалаа (лотто)-ны үйл ажиллагааг явуулах боломжтой цогц модулиудтай бөгөөд бусад системтэй харьцуулахад энэ нь томоохон давуу тал юм. Монгол улсад ашиглагдаж буй бусад сугалааны програм хангамж нь лотто явуулах эсвэл биет шагнал бүхий дан сугалаа явуулах байдлаар хийгдсэн байдаг бөгөөд энэхүү системийн






ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

	<p>давуу тал нь компанийг өргөн хүрээнд үйл ажиллагаа явуулах боломжтой болгож байгаа юм.</p> <ul style="list-style-type: none">• Систем нь сүүлийн үед эрчимтэй хөгжиж буй блокчэйн платформуудтай холбогдон ажиллаж, дата мэдээллийг найдвартай хадгалж, сугалаанд оролцогчдийн итгэлийг нэмэгдүүлэх боломжтой байдлаар хийгдсэн.• Өргөн ашиглагдаж буй төлбөр тооцооны шийдлүүд болох qPay, корпорэйт гэйтвэй холболтуудыг хийсэн бөгөөд сугалаа, лоттонд оролцогч дансаа удирдах бүрэн боломжоор хангагдсан.• Тусгай зөвшөөрлийн хүрээнд зохицуулах этгээдэд илгээх тайлан мэдээллийг админ хэсгээс бүрэн гаргах боломжтой бөгөөд удирдлагын зүгээс хяналт хийх боломжтой.
BACKEND	<ul style="list-style-type: none">• Орчин үеийн шинэ технологи /Node.js/ дээр суурилан хөгжүүлэлт хийгдсэн систем бөгөөд өнөө цагт тренд болж буй Micro-service архитектур ашиглаж системийн ерөнхий суурийг бүтээсэн.• Уг архитектур нь ачааллаас хамаарч системийг богино хугацаанд ачаалал даах чадвартай болгох түүнчлэн олон дэд сервисүүдээс бүрдсэн нь системийг шаардлагатай үед олон дахин хувилах, систем дээр сайжруулалт хийхэд хялбар болгох давуу талуудтай.
FRONTEND	<ul style="list-style-type: none">• Орчин үеийн шинэ технологи /Next.js/ дээр суурилан Front-end хэсгийн хөгжүүлэлт хийгдсэн бөгөөд хурдан ачаалах, хайлтын илэрц тохируулах, динамик болон статик хуудаснууд бүтээх, тооцоолол ихтэй хуудаснуудыг backend талаар гүйцэтгүүлэх гэх мэтчилэн сүүлийн үеийн вэб суурьтай системүүдийн хамгийн чухал шаардлагуудыг хангасан дэвшилтэт технологи юм.



**СИСТЕМИЙН
 ЕРӨНХИЙ
 АРХЕТИКТУР**



Хүснэгт 8. Системийн үйл ажиллагаа, боломж

• **Харагдах контентын агуулга <http://grandlotto.mn>**



Нүүр хэсэг

- Үндсэн цэсүүд**
- Нүүр хуудас
 - Лотто
 - Сугалаа
 - Тохирол
 - Нэвтрэх
 - Бүртгүүлэх
 - Мэдээ



Бүртгэл хэсэг	<p>Оролцогчийг вэбээр бүртгэнэ: Дараах мэдээллийг оруулснаар систем нь автоматаар бүртгэдэг байна. Утасны дугаар дээр үндэслэж 1 оролцогч 1 бүртгэл үүсгэх</p> <ul style="list-style-type: none"> • Утас • Нууц үг тохируулах /аюулгүй байдлыг сайжруулах зорилгоор том жижиг үсэг тоо холилдсон 8 тэмдэгтээс дээш байхыг шаарддаг/ • Нөхцөл/гэрээ-г зөвшөөрч, баталгаажуулах <p>Дээрх мэдээллийг ЗБ-аас оруулснаар, оролцогчийг бүртгэх боломжтой байх. Оролцогчийн данс 3 хэсгээс бүрдэнэ</p> <ul style="list-style-type: none"> • Оролцогчийн мэдээлэл • Түрүүвч • Сугалааны түүх 																																																																																																		
Оролцогчийн мэдээлэл	<p>Вэбэд Оролцогчийн мэдээлэл солих, өөрчлөх, нэмэлт мэдээлэл оруулах боломжтой. Сугалаа зохион байгуулагчид гаргасан хүсэлтийн дагуу дээрх мэдээллийг засах боломжтой. ЗБ-аас Тодорхой нэг оролцогчийн сугалаа авахыг зогсоох блок хийх боломжтой.</p>																																																																																																		
Хэтэвч	<ul style="list-style-type: none"> • Вэбэд оролцогч бүрт бүртгэлийн дагуу хэтэвч үүсгэж, • Дараах байдлын аль нэг хэлбэрээр хэтэвчээ цэнэглэдэг байх <ul style="list-style-type: none"> • QRay • Корпорэйт гэйтвэй • Хэтэвчний мэдээлэл харах 																																																																																																		
Сугалаа, лоттонд оролцсон түүх	<p>Сугалаанд оролцсон түүхээ харж болдог (сугалаанд оролцсон огноо, сонгосон цифрүүд, хожлын мөнгө)</p>																																																																																																		
Лоттонд оролцох	<p>Лоттонд оролцохдоо 1-43 хүртэл 43 тооноос 6 тоо сонгоно. Санамсаргүй байдлаар тоо үүсгэж, азтанг шалгаруулж, тохирол олгоно. 6 тоог 2 төрлөөр сонгох боломжтой</p> <ul style="list-style-type: none"> • Өөрөө сонгох • Автоматаар гарч ирэх <div data-bbox="482 1489 1419 1814" style="border: 1px solid #ccc; padding: 5px;"> <p>Алгоритт хууль</p> <table border="0"> <tr> <td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">1</td><td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">2</td><td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">3</td><td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">4</td><td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">5</td><td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">6</td><td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">7</td><td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">8</td><td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">9</td><td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">10</td> </tr> <tr> <td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">11</td><td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">12</td><td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">13</td><td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">14</td><td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">15</td><td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">16</td><td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">17</td><td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">18</td><td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">19</td><td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">20</td> </tr> <tr> <td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">21</td><td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">22</td><td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">23</td><td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">24</td><td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">25</td><td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">26</td><td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">27</td><td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">28</td><td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">29</td><td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">30</td> </tr> <tr> <td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">31</td><td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">32</td><td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">33</td><td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">34</td><td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">35</td><td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">36</td><td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">37</td><td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">38</td><td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">39</td><td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">40</td> </tr> <tr> <td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">41</td><td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">42</td><td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">43</td><td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">44</td><td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">45</td><td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">46</td><td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">47</td><td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">48</td><td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">49</td><td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">50</td> </tr> <tr> <td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">51</td><td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">52</td><td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">53</td><td colspan="7"></td><td></td><td></td> </tr> </table> <div style="margin-top: 10px;"> <table border="0"> <tr> <td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">A</td><td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">RANDOM</td><td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">45</td><td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">22</td><td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">46</td><td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">20</td><td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">28</td><td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">53</td><td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">×</td> </tr> <tr> <td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">B</td><td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">RANDOM</td><td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">53</td><td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">11</td><td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">22</td><td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">41</td><td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">3</td><td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">24</td><td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">×</td> </tr> <tr> <td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">C</td><td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">RANDOM</td><td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">31</td><td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">17</td><td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">24</td><td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">44</td><td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">38</td><td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">34</td><td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">×</td> </tr> <tr> <td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">D</td><td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">RANDOM</td><td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">12</td><td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">31</td><td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">36</td><td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">18</td><td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">21</td><td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">1</td><td style="border: 1px solid #ccc; padding: 2px;">×</td> </tr> </table> <p style="text-align: right; margin-top: 5px;">+ Нэмж</p> <p style="font-size: small;">Лоттоны нэгж үнэ: ₮ 5000 Нийт дүн: ₮ 15000</p> <p style="text-align: right; margin-top: 5px;">ТОГЛОХ</p> <p style="font-size: x-small; text-align: center;">БҮХ СОНГОСНЫГ ЦУЦЛАХ ДАХИН ЭХЛЭХ</p> </div> </div> <ul style="list-style-type: none"> • 6 цифр сонгоод Хэтэвчнээс нэгж сугалааны үнийн гүйлгээ хийснээр Лоттоны тоо баталгаажна. 	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	25	26	27	28	29	30	31	32	33	34	35	36	37	38	39	40	41	42	43	44	45	46	47	48	49	50	51	52	53										A	RANDOM	45	22	46	20	28	53	×	B	RANDOM	53	11	22	41	3	24	×	C	RANDOM	31	17	24	44	38	34	×	D	RANDOM	12	31	36	18	21	1	×
1	2	3	4	5	6	7	8	9	10																																																																																										
11	12	13	14	15	16	17	18	19	20																																																																																										
21	22	23	24	25	26	27	28	29	30																																																																																										
31	32	33	34	35	36	37	38	39	40																																																																																										
41	42	43	44	45	46	47	48	49	50																																																																																										
51	52	53																																																																																																	
A	RANDOM	45	22	46	20	28	53	×																																																																																											
B	RANDOM	53	11	22	41	3	24	×																																																																																											
C	RANDOM	31	17	24	44	38	34	×																																																																																											
D	RANDOM	12	31	36	18	21	1	×																																																																																											





- Лотто, сугалаа худалдан авсан тухай бүр хэрэглэгчийн системд бүртгэж нэгдсэн системээс олгогдсон дугааруудыг оролцогчид олгох;
- Харилцагчийн түрүүвч дээрх мөнгөн дүнгээс авсан үнийн дүн хасагдана.
- Лоттоны төлбөрийг хэтэвчээ цэнэглэх эсвэл шууд qPay ашиглан төлбөх боломжтой.
- Лоттонд оролцох 6 цифрийг хэдэн ч удаа сонгож, төлбөр төлж баталгаажуулж болно.
- Лоттоны тохирол явагдах давтамжийг системд гараас оруулж, тохируулах боломжтой.
- ЗБ нь тодорхой эрсдэлээс сэргийлэх зорилгоор Оролцогчийн сугалааны тасалбар авах үйлдлийг хаах боломжтой.

Сугалаанд оролцох

Сугалаанд оролцохдоо зарлагдсан сугалааны жагсаалтаас сонгон оролцох боломжтой.

ЭРЭГ ХАНДЛАГА СУГАЛАА

№	Сугалааны дугаар	Дугаар	Огноо	Төлөв
1	LT02229109	109	2023-11-29 17:26	Аас
2	LT02229108	108	2023-11-29 17:26	Аас
3	LT02229107	107	2023-11-29 17:26	Аас
4	LT02229106	106	2023-11-29 17:26	Аас
5	LT02229105	105	2023-11-29 17:26	Аас
6	LT02229104	104	2023-11-29 17:26	Аас
7	LT02229103	103	2023-11-29 17:26	Аас
8	LT02229102	102	2023-11-29 17:26	Аас

- Сугалааны дугаараа сонгоод Хэтэвчнээс нэгж сугалааны үнийн гүйлгээ хийснээр сугалаа баталгаажна.
- Сугалааны явцыг оролцогч харах боломжтой.
- Сугалааны төлбөрийг хэтэвчээ цэнэглэх эсвэл шууд qPay ашиглан төлөх боломжтой.
- Лотто, сугалаа худалдан авсан тухай бүр хэрэглэгчийн системд бүртгэж нэгдсэн системээс олгогдсон дугааруудыг сугалаанд оролцогчид олгох;
- Харилцагчийн түрүүвч дээрх мөнгөн дүнгээс авсан үнийн дүн хасагдана.
- Сугалаанд оролцогч хэдэн ч удаа сонгож, төлбөр төлж сугалаанд оролцож болно.
- Тохирол явагдах огноог системд гараас оруулдаг.
- ЗБ нь тодорхой эрсдэлээс сэргийлэх зорилгоор Оролцогчийн сугалааны тасалбар авах үйлдлийг хаах боломжтой.

Сугалаа, ЛОТТОНЫ ХОЖИЛ ОЛГОХ

- Системээс тохируулсан огнооны дараа сугалааны тохирлын орлогоос татвар суутгаж хэтэвчийг цэнэглэдэг.





МОНГОЛЫН ХӨРӨНГӨНИЙ ХОНЖВОРТ
MONGOLIAN STOCK EXCHANGE

2023-09-04

БҮРТГЭВ-03

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

	<ul style="list-style-type: none">Сугалааны хонжвор таарсан азтануудын тоо, хожсон мөнгийг харуулж, ил тод байдлыг хангах боломжтой
Тайлан	<p>Удирдлага болон хяналт тавих эрх бүхий байгууллагад гарган өгөх сугалааны мэдээлэл, тайланг гаргах боломжтой, аль мэдээллийг оруулахаа сонгох боломжтой.</p> <ul style="list-style-type: none">Борлуулсан сугалааны тасалбарын бүртгэл.Борлогдоогүй сугалааны тайлан.Оролцогчийн бүртгэлийг нэгтгэх тайлан.

1.5.3. Үнэт цаас гаргагчийн нийгмийн хариуцлага: Хөгжиж буй, хөгжингүй орнуудын туршлагаас харахад эд мөнгөний хонжворт сугалааны зах зээл нь төрийн хатуу зохицуулалттай салбар бөгөөд сугалааны үйл ажиллагаа явуулахын тулд тухайн улс орны төрийн зохицуулагч байгууллагаас тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл авах шаардлагатай байдаг.

“Гранд системс” ХХК-ийн хувьд 2020 онд Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болох Сангийн яамнаас эд мөнгөний хонжворт сугалаа явуулах тусгай зөвшөөрөл авсан. Мөн Үнэт цаас гаргагч нь 2023 онд эд мөнгөний хонжворт сугалаа явуулах тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар сунгуулсан бөгөөд нийгмийн өмнө хүлээсэн хариуцлагаа ухамсарлан хонжворт сугалаанаас олсон орлогыг тодорхой хувийг нийгэмд тулгамдаад буй асуудлуудыг шийдвэрлэх, санхүүжүүлэхэд зарцуулах зорилго, зорилтыг тавин ажиллаж байна. Энэхүү зорилгын хүрээнд Эерэг хандлага сугалааны тасалбарын борлуулалтын орлогоос 5 хүртэл хувийг өвчтэй хүмүүсийн эмчилгээ, боловсрол, ахмад настнуудад хандивлах, нийгмийн сайн сайхны төлөө зарцуулахаар төлөвлөж байна.

Эд мөнгөний хонжворт сугалаа зохион байгуулах нь зохион байгуулагчаас санхүүгийн хяналт, дэглэм өндөр байхыг шаардахаас гадна бизнесийн онцлогтой холбоотойгоор үйл ажиллагааны болон санхүүгийн мэдээллийн ил тод байдал мөн чухлаар тавигдана. Тиймээс үнэт цаас гаргагчийн зүгээс компанийн засаглал, хяналтын чиг үүргүүдийг бүтээмжтэй, мэргэжлийн байх нөхцөл бололцоог хангасан компанийн засаглалын сайн зарчмыг хэрэгжүүлэн ажилладаг.

1.6. Үнэт цаас гаргагчийн бүтэц, зохион байгуулалт, засаглал:

1.6.1. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны зохион байгуулалт: “Гранд системс” ХХК нь үйл ажиллагааны бүтцийн хувьд чадварлаг, цомхон бүрэлдэхүүнтэй ажиллахыг зорьж байгаа бөгөөд 4 албатай үйл ажиллагаа явуулж байна:

Зураглал 2. “Гранд системс” ХХК-ийн бүтэц зохион байгуулалт.






Үнэт цаас гаргагчийн бүтцээс харахад компанийн эрх барих байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байх, хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөө цагт компанийн эрх барих дээд байгууллага нь төлөөлөн удирдах зөвлөл байх, компанийн өдөр тутмын үйл ажиллагааг гүйцэтгэх захирал, түүнээс томилогдсон 4 алба хэрэгжүүлэхээр компанийн дүрэм, холбогдох бичиг баримтаар тодорхойлсон.

Үнэт цаас гаргагч нь өнөөгийн байдлаар 5 ажилтны бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулж байна. Эерэг хандлага хонжворт сугалаа явуулахаар төлөвлөж байна. Гүйцэтгэх захирал, ерөнхий нягтлан, мартентинг болон борлуулалтын ажилтан, сугалаа болон хонжвор хариуцсан ажилтан, програм хангамжийн ажилтан гэсэн бүрэлдэхүүнтэй бөгөөд цаашид сугалааны борлуулалтыг нэмэгдүүлэх үүднээс борлуулалтын менежерийн тоог нэмэх төлөвлөгөөтэй байна.

1.6.2. Хувьцаа эзэмшигчдийн хурал: “Гранд системс” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 11 дүгээр сард хуралдсан ээлжит бус хурлаар баталж, улсын бүртгэлд 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдөр бүртгүүлсэн компанийн дүрмийн 5 дугаар бүлгээр хувьцаа эзэмшигчдийн хуралтай холбоотой харилцааг зохицуулсан бөгөөд дүрмээр хувьцаа эзэмшигчдийн хурлыг ээлжит ба ээлжит бус гэсэн төрөлтэй байх, бүрэн эрхийг дараах байдлаар тодорхойлсон.

- ✓ Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг санхүүгийн жил дууссанаас хойш дөрвөн сарын дотор ТУЗ-өөс зарлаж хуралдуулах, хууль заасны дагуу шийдвэр гаргаж хуралдуулах;
- ✓ Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг Компанийн тухай хуульд заасны дагуу ТУЗ-өөс шийдвэрлэж хуралдуулах;
- ✓ Хувьцаа эзэмшигчдийн хурлаар энэ дүрэмд өөрөөр заагаагүй бол Компанийн тухай хуульд заасан асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ. Хурлын дарга хүндэтгэн үзэх шалтгааны улмаас ХЗХ-ыг даргалах боломжгүй болсон тохиолдолд компанийн ТУЗ-ийн дарга нь хувьцаа эзэмшигчдийн хурлыг удирдах;





- ✓ ХЭХ-д нэг энгийн хувьцаа нэг саналын эрхтэй байна. ТУЗ-ийн гишүүнийг сонгоход **энгийн** санал хураалт явуулах;
- ✓ Компанийн тухай хуульд зааснаар дийлэнх олонхоор шийдэх асуудлаас бусад тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцсэн асуудлыг ердийн олонхын саналаар шийдвэрлэх;
- ✓ Хурлын тухай мэдээллийг хувьцаа эзэмшигчдэд хүргэх, санал авах ажиллагааг Компанийн тухай хууль, Компаниас баталсан журмын дагуу явуулна. Хувьцаа эзэмшигч нь Компанийн тухай хуульд заасан журмын дагуу ХЭХ-д өөрийн биеэр буюу бичгээр олгосон хуулийн хүчин төгөлдөр итгэмжлэлийг **үндэслэн** өөр этгээдээр төлөөлүүлэн оролцуулах;
- ✓ Хувьцаа эзэмшигч хурлаас гарах шийдвэрийн төсөлд бичгээр санал ирүүлсэн тохиолдолд түүнийг хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсон гэж үзнэ. Уг санал нь Компанийн тухай хуулийн холбогдох шаардлагыг хангасан байх;
- ✓ Компанийн саналын эрхтэй хувьцааны энгийн олонх хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хуралд оролцсоноор хурал **хүчин** төгөлдөр болно. Хурлын ирцэд заасан хувь хүрээгүй бол хурлыг хүчин төгөлдөр бус гэж үзэж хурлыг дахин хуралдуулах өдрийг товлож энэ тухай тэмдэглэл үйлдэж ТУЗ-ийн дарга, тэмдэглэл хөтлөгч гарын үсэг зурна. Хойшлогдсон хурлаас хэлэлцэх асуудлыг өөрчлөхгүй байх;
- ✓ Хойшлогдсон хурлыг Компанийн тухай хуулийн дагуу ажлын 20 хоногийн дотор хуралдуулна. Өмнөх хуралд ирүүлсэн саналыг хойшлогдсон хурлын ирц, санал хураалтын дунд тооцох;
- ✓ Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэх асуудлыг эчнээ санал хураах замаар шийдвэрлэж болно. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг эчнээ санал хураалтаар орлуулж болохгүй;
- ✓ Эчнээ санал хураалт явуулах шийдвэрийг ТУЗ гаргах бөгөөд энэхүү шийдвэрт компанийн тухай хуулийн 73.3-т заасан асуудлыг тусгасан байх;
- ✓ Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл, тогтоолыг Компанийн тухай хуулийн 74 дүгээр зүйлд заасан журмын дагуу хотолж, Хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга баталгаажуулан гарын үсэг зурна. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын санал хураалтын дүн, гаргасан шийдвэрийг тухайн хурал дээр зарлан мэдэгдэнэ.

1.6.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал, гишүүд: Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлагдсан компанийн дүрмийн 6 дугаар бүлгээр хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих дээд байгууллага нь төлөөлөн удирдах зөвлөл байх, төлөөлөн удирдах зөвлөл нь 5-аас доошгүй хараат болон хараат бус гишүүнтэй байх, гишүүдийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар сонгохоор тус тус зохицуулсан.

Хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 9/22 дугаар шийдвэрээр төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүн, хараат бус гишүүдийг томилсон. Шинээр томилогдсон төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 22/4 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”, 2 дугаар хавсралтаар “Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны





ҮНӨТ ЦААСНЫ ТАНИЛШУУЛГА

журам”, 3 дугаар хавсралтаар “Дотоод аудитын бодлого”, 4 дүгээр хавсралтаар “Төлөөлөн удирдах зөвлөлийн засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны журам”, 5 дугаар хавсралтаар “Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх журам, залгамж халааны бодлого, журам”, 6 дугаар хавсралтаар “Цалин урамшууллын бодлого”, 7 дугаар хавсралтаар “Төлөөлөн удирдах зөвлөлийн хөрөнгө оруулалт, санхүү, эрсдэлийн хорооны журам”-ыг тус тус баталсан.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүдийн мэдээллийг хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 9. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүдийн мэдээлэл

Нэр	ТУЗ-ийн гишүүн	Эрхэлж буй албан тушаал
1 Б.Баттулга	Хараат бус гишүүн, ТУЗ-ийн дарга	“БД Гидрогеофизик” ХХК – Гүйцэтгэх захирал
2 Д.Нармандах	Ердийн гишүүн	“Гранд системс” ХХК - Гүйцэтгэх захирал
3 Р.Тогтохбаатар	Ердийн гишүүн	“Хуягтбаатар” ХХК – Хуулийн зөвлөх
4 С.Гансүх	Ердийн гишүүн	“АйСиТи групп” ХХК-д Хөрөнгө оруулалтын шинжээч
5 Н.Цэлмэгсайхан	Хараат бус гишүүн	“Амар даатгал” ХХК-д Ахлан нягтлан бодогч

- **ТУЗ-ийн дарга: Баатар овогтой Баттулга**

Б.Баттулга 2002 онд Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Ашигт малтмалын эрэл хайгуулын геофизикч мэргэжлээр бакалаврын зэрэг хамгаалсан. Тэрээр “БД Гидрогеофизик” ХХК-д гүйцэтгэх захирлын алба хашдаг. 2008-2018 онд “Магнетиксурвей” ХХК-д Ерөнхий инженер, 2006-2008 онуудад “Мэйжиксигналс” ХХК-д Ерөнхий инженер, 2002-2008 оны хооронд “Геомастер Инженеринг” ХХК болон Insight Geophysics Inc-д тус тус Геофизикчээр ажиллаж байсан туршлагатай.

- **ТУЗ-ийн ердийн гишүүн: Дашдорж овогтой Нармандах**

Д.Нармандах нь 2020 оноос “Их засаг” ОУИС-д докторын зэргээр суралцаж байна. Харин 2020 онд “Их засаг” ОУИС-ийн хууль зүйн ухааны магистер, 2000 онд “Гурван Эрдэнэ” БДС-д бакалаврын зэрэг тус тус хамгаалсан. **Ажил эрхлэлтийн байдал:** 2021-2022 онд “Тен Инвестмент ҮЦК” ХХК-д гүйцэтгэх захирлын албан тушаал хашиж байсан. 2012-2014 онуудад “Азиа пасифик секьюритиз ҮЦК” ХХК-д Ахлах дилер, 2007-2012 онд “Нортенсек ҮЦК” ХХК-д дилер, 2006-2007 онд “Аргай ҮЦК” ХХК-д брокер, 1994-1996 “Монгол Шуудан” ХК-д мэргэжилтнээр тус тус ажиллаж байсан, хөрөнгийн зах зээлд ажиллаж байсан туршлагатай.

- **ТУЗ-ийн ердийн гишүүн: Рагчаа овогтой Тогтохбаатар**

Р.Тогтохбаатар нь “Хуягт Баатар” ХХК-д хуулийн зөвлөхийн албан тушаал хашиж байна. Тэрээр ажлын гараагаа “Волтэйж” ХХК-д хуулийн зөвлөхөөр эхэлж байсан. Үүнээс хойш “Монтерео” ХХК-д хуулийн зөвлөхийн албан тушаал мөн хашиж байсан туршлагатай. Тэрээр 2004 онд “Хасагт Хайрхан”





Эрхзүй нийгмийн ухааны дээд сургуулийг Эрхзүйч мэргэжлээр төгсөж бакалаврын зэрэг хамгаалсан. Эзэмшсэн мэргэжлээрээ 18 гаруй жил ажиллаж байна.

- **ГУЗ-ийн ердийн гишүүн: Самбуу овогтой Гансүх**
С.Гансүх нь 2012-2017 онд “Лаудиус академи”-д бизнесийн удирдлагын магистр зэрэг хамгаалсан. 2006-2010 онд Монгол улсын их сургуулийн Эдийн засгийн сургуулийг Эдийн засагч мэргэжлээр бакалаврын зэрэгтэй төгссөн. Тэрээр 2017-2019 онд “Худалдаа хөгжлийн банк” ХХК-д банкираар ажлын гараагаа эхэлж, 2019-2021 онд “Төмөржин Трейд” ХХК-д Санхүүгийн албанд санхүүгийн шинжээч, 2021 оноос “Ай Си Ти групп” ХК-д хөрөнгө оруулалтын шинжээчээр ажиллаж байна.
- **ГУЗ-ийн хараат бус гишүүн: Наранбат овогтой Цэлмэгсайхан**
Н.Цэлмэгсайхан нь 2022 онд Нанкай их сургуульд магистрын зэрэг хамгаалсан. 2003-2007 онд Монгол улсын их сургуулийн Математик компьютерын их сургуулийг Бакалавр зэрэгтэйгээр төгссөн. 2007 оноос “Амар даатгал” ХХК-д туслах нягтлан бодогч, ахлах нягтлан бодогчийн албан тушаалыг хашиж байна. Ажиллах хугацаандаа өөрийн мэргэжлийг дээшлүүлэн магистр зэрэг горилон суралцсан болно.

1.6.4. Эрх бүхий албан тушаалтан болон гүйцэтгэх удирдлага: Компанийн дүрмээр гүйцэтгэх удирдлага нь дүрэм болон төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна гэж заасан бөгөөд хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 9/21 тоот шийдвэрээр Дашдорж овогтой Нармандахыг гүйцэтгэх захирлаар томилсон.

Мөн төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 22/4 тоот тогтоолын 10 дугаар хавсралтаар “Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны журам”-ыг баталж, мөн тогтоолын 13 дугаар хавсралтаар “Ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах журам”-ыг тус тус баталж, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын хоорондын харилцааг зохицуулсан.

Гүйцэтгэх захирлаар томилогдсон Д.Нармандах нь 2020 оноос “Их засаг” ОУИС-д докторантаар суралцаж байна. 2020 онд “Их засаг” ОУИС-ийн хууль зүйн ухааны магистер, 2000 онд “Гурван Эрдэнэ” БДС-д бакалаврын зэрэг тус тус хамгаалсан. 2021-2022 онд “Тен Инвестмент ҮЦК” ХХК-д гүйцэтгэх захирал, 2012-2014 онуудад “Азиа пасифик секьюритиз ҮЦК” ХХК-д Ахлах дилер, 2007-2012 онд “Нортенсек ҮЦК” ХХК-д дилер, 2006-2007 онд “Аргай ҮЦК” ХХК-д брокер, 1994-1996 онд “Монгол Шуудан” ХК-д тус тус ажиллаж байсан. Тэрээр санхүү, хөрөнгө оруулалт, брокер, бизнесийн чиглэлээр ажиллаж байсан арвин туршлагатай нэгэн юм.

Санхүү, хүнийн нөөцийн албаны дарга Энхтөр овогтой Баярцэцэг: Э.Баярцэцэг нь 2012-2013 онд “Бүрэн Инвест” ХХК-ийн нягтлан бодогч, 2013-2018 онд “Нимм проперти” ХХК-д нягтлан бодогч, 2018 оноос “Цолмон сүндэр” ХХК-д нягтлан бодогч, 2022 оноос “Гранд системс” ХХК-д нягтлан бодогчоор тус тус ажиллаж байна. Э.Баярцэцэг нь 2012 онд





МҮДС-ийг нягтлан бодох бүртгэл мэргэжлээр төгссөн бөгөөд санхүү, нягтлан бодох бүртгэл чиглэлээр 10 жил ажилласан туршлагатай.

Сугалаа, хонжвор хариуцсан албаны дарга Дашидорж овогтой Эрдэнэцогт: Д.Эрдэнэцогт нь ажлын гараагаа 2005 оноос “Мегабоард” ХХК-г үүсгэн байгуулсан бөгөөд 2011 онд “Найдвар Наяд” ХХК-г үүсгэн байгуулж, удирдаж байна. 2020 онд “ЮБИ” ХХК-д худалдааны төлөөлөгчийн албан тушаалыг давхар хашиж байсан ажлын арвин туршлагатай. 2022 оноос “Гранд системс” ХХК-ийн сугалаа, хонжвор хариуцсан албаны даргаар ажиллаж байна. Боловсролын хувьд 2004 онд Евро Ази дээд сургуулийг эдийн засаг, бизнесийн чиглэлээр төгсөж одоог хүртэл мэргэжлийн дагуу ажиллаж байгаа туршлага чадвартай боловсон хүчин юм.

Маркетинг борлуулалт хариуцсан захирал Энхбаяр овогтой Пүрэвсүрэн: Э.Пүрэвсүрэн нь 2005 онд Монголын Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуульд суралцаж байгаад 2006 онд Чех улсын Прага хотын Карлын их сургуулийн Анагаах ухааны 1-р факультетийн Анагаах ухааны оюутнаар суралцаж төгссөн. Мөн Чех улсын Карлын их сургуулийг Нийгмийн эрүүл мэндийн бакалавр зэргийг 2011 онд хамгаалсан. Э.Пүрэвсүрэн нь 2018-2022 оны хооронд Монгол Улсын Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэгт Эмнэлгийн төлөвлөлт, хөгжлийн албаны боловсон хүчний төлөвлөлт хариуцсан менежерээр, 2016-2018 онд Геронтологийн үндэсний төвд Стратеги төлөвлөлт, гадаад харилцаа хариуцсан ахлах ажилтан, 2012-2016 онуудад Эрүүл мэндийн яамны харьяа Геронтологийн үндэсний төвд Судалгаа, сургалтын хэлтсийн эрүүл мэндийн статистикчийн албан тушаалыг тус тус хашиж байсан арвин их туршлага мэдлэгтэй боловсон хүчин юм.


1.7. Үнэт цаас гаргагчийн 2020-2023 оны санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд: Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 22/4 тоот тогтоолын 15 дугаар хавсралтаар “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг баталсан.

1.7.1. Санхүү байдлын тайлангийн үзүүлэлтүүд: Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 225 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 3.1.4 дэх заалтад “үнэт цаас гаргагч нь нийтэд санал болгон анх удаа болон нэмж гаргах хувьцаагаа бүртгүүлэх хүсэлтийг Хороонд гаргахдаа сүүлийн 6 сарын доторх хугацааны аудитын компаниар баталгаажуулсан санхүүгийн тайлан болон аудитын байгууллагын тодорхойлох захидал”-ыг ирүүлэхээр зохицуулсан.

Тиймээс “Гранд системс” ХХК нь олон нийтэд санал болгон анх удаа хувьцаа гаргахтай холбоотойгоор санхүүгийн тайланг 2021 оны 12 дугаар сарын 31, 2022 оны 09 дүгээр сарын 30, 2022 оны 12 дугаар сарын 31, 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөр тус тус тасалбар болгон Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 294 дүгээр тогтоолоор үнэт цаасны зах зээлд аудитын үйлчилгээ эрхлэхээр бүртгүүлсэн “ЦЭСБ-АУДИТ” ХХК-аар аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээг байгуулж, дүгнэлт гаргуулсан.

Үнэт цаас гаргагч нь 2022 онд 120.8 сая төгрөгийн орлоготой ажилласан нь өмнөх оноос 89.1% өссөн үзүүлэлт юм. Энэ нь ковид-19 цар тахлын нөлөө буурч, компани үйл ажиллагаагаа хэвийн явуулж эхэлсэнтэй холбоотой. 2023 оны 06 дугаар сарын 30-ны





ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

өдрийн тасалбар болгосон санхүүгийн тайлангаар Үнэт цаас гаргагч нь 72.7 сая төгрөгийн орлоготой, 34.3 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Хүснэгт 10. 2020-2023.06.30-ны өдрийн Орлого, үр дүнгийн тайлангийн үзүүлэлтүүд /төгрөг/

	2020	2021	2022	2023.06.30
Үйл ажиллагааны орлого	126,931,322	63,896,260	120,845,790	72,727,273
Орлого	126,365,000	63,896,260	120,845,790	72,727,273
Бусад	566,322			
Үйл ажиллагааны зардал	35,098,518	44,393,322	106,641,560	38,042,284
Ерөнхий ба удирдлагын зардал	35,098,518	8,171,678	10,882,486	37,747,354
Бусад	-	36,221,644	95,759,074	294,930
Татвар төлөхийн өмнөх ашиг	91,832,804	19,502,938	14,204,230	34,684,989
Татварын зардал	918,328	557,246	1,099,633	349,799
Татварын дараах ашиг	90,914,476	18,945,692	13,104,597	34,335,189

Үнэт цаас гаргагч нь 2022 оны жилийн эцсээр 440.0 сая төгрөгийн хөрөнгөтэй, энэ нь өмнөх оноос 166.8%-иар өссөн үзүүлэлт юм. Хөрөнгийн хэмжээ нэмэгдэхэд үнэт цаас гаргагч нь үйл ажиллагаандаа ашигладаг програм хангамжийг 299.0 сая төгрөгөөр худалдан авч, өөрийн нэр дээр бүртгэж, биет бус хөрөнгөтэй болсонтой холбоотой юм. Тайлант хугацаанд нийт хөрөнгийн 27.3% буюу 120.3 сая төгрөг нь эргэлтийн хөрөнгө, 68.2% буюу 299.0 сая төгрөг эргэлтийн бус хөрөнгө буюу биет бус хөрөнгөөс бүрдэж байна. 2022 онд компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ 423.5 сая төгрөг байсан бөгөөд үүний 70.8% буюу 300.0 сая төгрөг нь хувьцаат капитал, 29.2% буюу 123.5 сая төгрөг хуримтлагдсан ашиг байна. 2023 оны хагас жилийн байдлаар Үнэт цаас гаргагчийн нийт хөрөнгө 479.8 сая төгрөгт хүрсэн бөгөөд энэ нь оны эхнээс 9%-иар өссөн үзүүлэлт юм. Хуримтлагдсан ашиг нэмэгдсэнтэй холбоотой үнэт цаас гаргагчийн өөрийн хөрөнгө 8.1%-иар нэмэгдэж, 457.8 сая төгрөгт хүрсэн байна.

Хүснэгт 11. 2020-2023.06.30 санхүү байдлын тайлан тэнцэл /төгрөг/

	2020	2021	2022	2023.06.30
Хөрөнгө	91,506,935	164,919,038	440,007,231	479,774,023
Мөнгө	91,506,935	164,919,038	120,217,231	149,014,023
Биет бус хөрөнгө			299,990,000	299,990,000
Урьдчилж төлсөн зардал			19,800,000	15,770,000
Бусад				15,000,000
Өр төлбөр	465,052	54,648,500	16,542,096	21,973,699
Татварын өр	465,052	4,378,500	16,542,096	21,973,699
Урьдчилж орсон орлого		50,270,000		
Эздийн өмч	91,041,883	110,270,538	423,465,135	457,800,324
Хувьцаат капитал	10,000	10,000	300,000,000	300,000,000
Хуримтлагдсан ашиг	91,031,883	110,260,538	123,465,135	157,800,324





ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЦУУЛГА

1.7.2. Аудитын компанийн дүгнэлт, тодорхойлох захидал: “ЦЭСБ-АУДИТ” ХХК нь “Гранд системс” ХХК-ийн 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөр дуусгавар болгосон санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэсэн болно.

“ЦЭСБ-АУДИТ” ХХК-аас “Гранд системс” ХХК-ийн санхүүгийн тайлангийн 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөр дуусгавар болгосон санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлангууд, нэмэлт тодруулгыг багтаасан санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэсэн бөгөөд үнэт цаас гаргагчийн санхүүгийн тайлангууд нь материаллаг асуудлаар Монгол Улсын холбогдох хууль, дүрэм, журам, Олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу үнэн зөв толилуулагдсан талаар дүгнэсэн.

“ЦЭСБ-АУДИТ” ХХК-ийн гаргасан аудитын тодорхойлох захидалд:

“ЦЭСБ-АУДИТ” ХХК нь Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 294 дүгээр тогтоолоор үнэт цаасны зах зээлд оролцогчид аудитын үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдээр бүртгүүлж, үнэт цаас гаргагч, зохицуулалттай этгээдийн санхүүгийн тайланд аудитын хийх эрхтэй. Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 225 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-аар үнэт цаас гаргагчийн анх удаа болон нэмж гаргаж буй үнэт цаасанд аудитын үйлчилгээ үзүүлэгч нь дүгнэлтээс гадна, тодорхойлох захидлыг гаргахаар зохицуулагдсан.

- Аудитын компанийн зүгээс “Гранд системс” ХХК-ийн 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөр дуусгавар болгосон санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлангууд, нэмэлт тодруулгыг багтаасан санхүүгийн тайланд аудитын үйлчилгээг үзүүлж гүйцэтгэлээ.
- Аудитын дүгнэлтээр үнэт цаас гаргагчийн дээрх санхүүгийн тайлангууд нь материаллаг асуудлаар Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, төрийн эрх бүхий байгууллагаас баталсан дүрэм, журам, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв, бодитой толилуулагдсан гэж дүгнэж байна.
- Аудитын компанийн зүгээс аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэсэн бөгөөд уг стандартын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа “Аудиторын үүрэг хариуцлага” гэсэн хэсэгт харуулсан. Бид энэхүү аудитын ажилд хамаарах ёс зүйн шаардлагуудын дагуу үнэт цаас гаргагч, андеррайтерын компаниас хараат бус, бие даасан байдлаар ажиллаж, бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн бөгөөд бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргахад хангалттай, зохистой үндэслэл болно гэж бид үзэж байна.

- Үнэт цаас гаргагчийн татварын тайлан ба бусад тусгай зориулалтын тайлан мэдээлэл нь аудитын дүгнэлтэд хамааралгүй бөгөөд үнэт цаас гаргагчийн





ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

Үнэт цаасны танилцуулгад аудитын компанийн гаргасан дүгнэлт, тусгагдсан санхүүгийн үзүүлэлтүүд нь аудитын компаниас гаргасан санхүүгийн мэдээлэлтэй нийцсэн болно гэж тодорхойлсон.

1.7.3. Санхүүгийн харьцаа үзүүлэлтүүд: Үнэт цаас гаргагчийн 2020-2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаарх санхүү байдлын тайланд санхүүгийн тайлан, тэнцэлд хөрөнгийн эргэц, өрийн харьцаа, ахиуц цэвэр ашгийн санхүүгийн шинжилгээг хийж үзвэл дараах байдалтай байна.

Хүснэгт 12. Санхүүгийн харьцаа үзүүлэлт

	2020	2021	2022	2023.06.30
Хөрөнгийн эргэц	263.8%	49.8%	40.0%	15.8%
Өрийн харьцаа	0.5%	33.1%	3.8%	4.6%
Ахиуц цэвэр ашиг	71.6%	29.7%	10.8%	47.2%
Өөрийн хөрөнгийн өгөөж	99.9%	17.2%	3.1%	7.5%

Хөрөнгийн эргэц: Үнэт цаас гаргагч нь 2020 онд нийт хөрөнгийн эргэцийн харьцаа 263.8% байсан бол 2022 онд 40% болсон байна. Цар тахал, зах зээлийн хүндрэл, хязгаарлагдмал хүрээнд хонжворт сугалаа явуулж байгаа зэрэг нь хөрөнгийн эргэцийг сүүлийн жилүүдэд сулруулахад нөлөөлсөн байна. 2023 оны хагас жилээр хөрөнгийн эргэц 15.8%-д хүрсэн байна.

Өрийн харьцаа: 2020 онд үнэт цаас гаргагчийн өрийн харьцаа нь 0.5% байсан бөгөөд энэ нь компанийн нийт хөрөнгийн 0.5% нь өр төлбөрөөр санхүүжигдсэн байгааг харуулж байна. Энэхүү харьцаа 2022 онд 3.8%-д хүрч нэмэгдсэн боловч харьцангуй өр төлбөр багатай хэвээр байгааг харуулж байна. 2023 оны эхний хагас жилийн байдлаар өрийн харьцаа 4.6%-д хүрсэн байна.

Ахиуц цэвэр ашиг: 2020 онд Үнэт цаас гаргагчийн ахиуц цэвэр ашиг 71.6% байсан бөгөөд энэ нь компанийн нийт орлогын 71.6% нь цэвэр ашиг байсныг харуулж байгаа бөгөөд энэхүү харьцаа 2022 онд 3.1%-д хүрсэн байна. Компани нь цаашид үйл ажиллагааны цар хүрээгээ нэмэгдүүлснээр энэхүү харьцаагаа өсгөж, хувьцаа эзэмшигчдэд очих өгөөжийг нэмэгдүүлж ажиллах боломжтой юм. 2023 оны эхний хагас жилийн байдлаар ахиуц ашиг 47.2% байна.

1.7.4. Үнэт цаас гаргагчийн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл: Компанийн тухай хуулийн 87 дугаар зүйлээр “их хэмжээний хэлцэл”-ийг дараах байдлаар тодорхойлсон.

- Хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25.0 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн хэлцэл (компанийн өдөр тутмын үйл ажиллагаатай холбогдсон хэлцэл үүнд хамаарахгүй);





ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

- Компанийн өмнө гаргасан энгийн хувьцааны 25.0 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа авах эрхийн бичиг буюу энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргах, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн гаргалт гэх ойлголтууд хамаарна.

Үнэт цаас гаргагчид хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч “Өмгөөллийн Легал полиси” ХХН-өөс 2019 оны 11 дүгээр сараас 2022 оны 10 дугаар сарын хугацаа буюу 3 жилийн хугацаанд хийгдсэн үнэт цаас гаргагчийн их хэмжээний хэлцэлтэй холбоотой гэрээ, хэлцлийг хянан үзэхэд их хэмжээний хэлцлийг Компанийн тухай хуулийн 88.1-д заасны дагуу хувьцаа эзэмшигчийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэж ирсэн бөгөөд хуулийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч нөхөрлөлд ирүүлсэн гэрээ, хэлцлүүдийн үнийн дүнг компанийн санхүүгийн тайланд тусгагдсан активын дүнтэй харьцуулж үзэхэд сүүлийн 3 жилийн хугацаанд 10 их хэмжээний хэлцэл хийсэн байна. Дээрх их хэмжээний хэлцэл нь Компанийн тухай хууль, компанийн дүрэм, бусад хууль тогтоомжийн нөхцөл шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянаж үзэхэд холбогдох хууль тогтоомжид нийцсэн байгаа талаар дүгнэсэн.

Хүснэгт 13. Их хэмжээний хэлцлийн мэдээлэл

Огноо	Гэрээний нөгөө тал	Гэрээний нэр
2019.11.01	Сүү ХК	Ажил гүйцэтгэх
2019.12.25	Дөрвөн Өлзий	Ажил гүйцэтгэх
2020.02.10	Сүү ХК	Нэмэлт
2020.03.25	Бимэкс Холдинг ХХК	Ажил гүйцэтгэх
2020.05.04	Үндэсний Аудит Газар	Програм хангамж нийлүүлэх, нэвтрүүлэх
2020.09.14	Женерал Инсайтс ХХК	Ажил гүйцэтгэх
2021.01.20	Ворлд Органик Фүүдс ХХК	Үйлчилгээ үзүүлэх
2021.04.20	Сүү ХК	Ажил гүйцэтгэх мастер
2021.10.21	Түмэн Шувуут ХК	Ажил гүйцэтгэх
2022.09.13	Асар Лот ХХК	Програм хангамж нийлүүлэх

Сонирхлын зөрчилтэй хэлцлийн мэдээлэл: Компанийн тухай хуулийн 89 дүгээр зүйлд зааснаар “Компанийн энгийн хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч, компанийн эрх бүхий албан тушаалтан, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд нь өөрийн ажиллаж байгаа болон хувьцааг нь эзэмшиж байгаа компанитай дор дурдсан харилцаанд орсон бол компанитай эсхүл түүний хараат болон охин компанитай сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээдэд тооцогддог.

- Хэлцлийн нөгөө тал, эсхүл хэлцэлд төлөөлөгч эсхүл зуучлагчаар оролцож байгаа;
- Хэлцлийн нөгөө тал болон оролцож байгаа, эсхүл уг хэлцэлд төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан, эсхүл





ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

энгийн хувьцааны 20-оос дээш хувийг дангаараа буюу түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа;

- Хэлцлийн нөгөө тал болон оролцож байгаа, эсхүл төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа хуулийн этгээдийн толгой компанийн эрх бүхий албан тушаалтан, эсхүл уг компанийн энгийн хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа;
- Хэлцлийн үр дүнд шууд болон шууд бусаар үүсэх орлогоос хувь хүртэж байгаа;

Компанийн тухай хуулийн 92 дугаар зүйлийн 92.1-т сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай шийдвэрийг уг хэлцэл хийх талаар сонирхлын зөрчилгүй төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/-ийн гишүүдийн олонхын саналаар гаргахаар заасан байна. Үнэт цаас гаргагчийн үнэт цаас гаргах ажиллагаанд хууль зүйн зөвлөгөө үзүүлэгч хуулийн нөхөрлөлийн холбогдох бичиг баримт, гэрээг нягтлан үзэхэд сүүлийн гурван жилийн хугацаанд 1 сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгдсэн байна. Энэ нь үнэт цаас гаргагч нь “Асар Лог” ХХК-тай 2022 оны 09 дүгээр сарын 13-ны өдөр байгуулсан “Програм хангамж нийлүүлэх” гэрээг байгуулсан бөгөөд тус гэрээг Компанийн тухай хуульд заасан журмын дагуу байгуулсан талаар хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч этгээд өөрийн дүгнэлтэд дүгнэсэн байна.



ХОЁР: ХОНЖВОРТ СУГАЛААНЫ САЛБАРЫН НӨХЦӨЛ, БАЙДАЛ, БИЗНЕС ШИНЖИЛГЭЭ:

2.1. Макро эдийн засгийн нөхцөл байдал, олон улсын хандлага:

Орос-Украины дайн, үүнээс үүдэлтэй худалдааны хориг арга хэмжээнүүд нь дэлхийн эрчим хүч, хүнс болон түүхий эдийн зах зээлд сөрөг шокууд бий болгон, улмаар дэлхийн улс орнуудад инфляцын түвшинг нэмэгдүүлэх, эдийн засгийн идэвхжилийг сааруулах зэргээр сөрөг нөлөөлөл үзүүлж байна. Цаашид Орос-Украины дайн болон Ковид-19 цар тахлаас үүдэлтэй нийлүүлэлтийн сүлжээний тасалдал үргэлжилсэн тохиолдолд дэлхийн улс орнуудад инфляцын өндөр түвшин илүү урт хугацаанд хадгалагдах, эдийн засгийн хүндрэл үүсгэх зэрэг эрсдэлийг дагуулж байна.

Ийнхүү эдийн засаг, геополитикийн тодорхой бус байдал нэмэгдсэнтэй холбогдуулан 2022 оны 7 дугаар сард Олон улсын валютын сангийн шинжээчид энэ оны дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөллийг өмнөх төсөөллөөс 1.2 нэгж хувиар бууруулж, 3.2 хувь байхаар шинэчлэн тооцлоо.

Дэлхийн зах зээл дээрх эрчим хүчний түлш болох байгалийн хий, газрын тос, нүүрс болон эрчим хүчний хэрэглээний үнэ 2021 оноос эрчимтэй өссөн бөгөөд үүнд нэг талаас дэлхийн эдийн засаг идэвхжилийг дагаж эрчим хүчний түлшний эрэлт хурдацтай нэмэгдсэн нь нөлөөлөв. Нөгөө талаас нефть экспортлогч орнуудын байгууллага (ОПЕК)-ын гишүүн орнуудын үйлдвэрлэлийн хязгаарлалт болон Орос-Украины дайн, үүнээс үүдэлтэй хориг арга хэмжээнүүдээс шалтгаалан нийлүүлэлтийн хомсдол үүссэн нь нөлөөллөө.

Цаашид эрчим хүчний үнийн дарамт богино, дунд хугацаанд хадгалагдах төлөвтэй байгаа бөгөөд дэлхийн санхүүгийн нөхцөл сүүлийн жил гаруй хугацаанд тасралтгүй чангарсаар байна. Үүнд хөрөнгийн зах зээл дээрх хувьцааны үнэ буурч, хөгжингүй болон хөгжиж буй орнуудад инфляцыг бууруулах зорилгоор бодлогын хүүгээ нэмэгдүүлж, Засгийн газрын бондуудын өгөөж өссөн зэрэг нь голлон нөлөөлөв.

Хөгжингүй орнуудын төв банкнууд мөнгөний бодлогын төлөвөө үргэлжлүүлэн чангаруулбал Засгийн газрын бондуудын өгөөж өсөж санхүүгийн нөхцөл улам чангарах, цаашлаад хөгжиж буй орнуудаас гадагшлах хөрөнгийн урсгал тэлж, ханш сулрах дарамтыг нэмэгдүүлж болзошгүй байна. Ялангуяа санхүүгийн нөхцөл глобал орчинд ийнхүү чангарах нь хөгжиж буй орнуудын эдийн засагт томоохон сөрөг нөлөөллийг үзүүлэх эрсдэлтэй байна.


Эрдэс бүтээгдэхүүний экспортод суурилсан жижиг нээлттэй эдийн засагтай, түүнчлэн гадаад өр, зээлийн дахин санхүүжилт хийх хэрэгцээ, шаардлага өндөр Монгол Улсын хувьд дэлхийн эдийн засаг, санхүүгийн зах зээлийн орчинд гарч буй эдгээр өөрчлөлтүүд нь дотоодын эдийн засагт бодит эрсдэлүүдийг учруулж байна. Тухайлбал,



- ОХУ-Украины дайны нөхцөл байдал, хориг арга хэмжээнүүдээс шалтгаалан Монгол Улсын гадаад худалдаа, нефтийн бүтээгдэхүүний импортод сөргөөр нөлөөлөх,
- Дэлхийн эдийн засаг, аж үйлдвэрийн салбарын идэвхжилийн сааралтыг даган эрдэс бүтээгдэхүүний үнэ буурах,
- Санхүүгийн нөхцөлийн чангаралтын улмаас хөрөнгийн гадагшлах урсгал нэмэгдэх, улмаар зах зээлийн хүлээлтэд сөргөөр нөлөөлж, гадаад санхүүжилтийн өртгийг нэмэгдүүлэх зэрэг гадаад орчны эрсдэлүүд өндөр байна.

Ковид-19 цар тахлын хязгаарлалтууд суларч, эдийн засгийн идэвхжил нэмэгдсэнээс шалтгаалан 2021 онд дэлхийн эдийн засаг огцом сэргэж, 6.1 хувиар өссөн боловч Украин дахь дайн эхэлснээс хойш буюу 2022 оны 7 дугаар сард ОУВС-гийн шинжээчид 2022 оны дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөллийг 2022 оны 1 дүгээр сарын төсөөллөөс 1.2 нэгж хувиар бууруулж, 3.2 хувь байхаар тооцсон бол Евро бүс, АНУ, БНХАУ-ын өсөлтийн төсөөллийг 1.3, 1.7, 1.5 нэгж хувиар тус тус бууруулж, 2.6, 2.3, 3.3 хувь болгон шинэчлэн тооцсон. Түүнчлэн энэхүү хурцадмал байдал бий болохоос өмнө буюу 2021 онд хөгжингүй болон хөгжиж буй орнуудын инфляцын түвшин эрчимтэй өсөж, улмаар Төв банкнууд мөнгөний бодлогоо чангаруулаад байсан нь санхүүжилтийн зардлыг нэмэгдүүлж, дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөлөлд сөргөөр нөлөөлөд байна.


График 1. Дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөлөл



Эх сурвалж: ОУВС-гийн төсөөлөл

Дэлхийн нийлүүлэлтийн сүлжээний дарамтын индекс (GSCPI) цар тахлын нөлөөгөөр 2020-21 онд, Украин дахь дайны нөлөөгөөр 2022 оны эхээр огцом өссөн ба өндөр хэвээр байна. Түүнчлэн дэлхийн томоохон аж үйлдвэрүүд ОХУ, Украины түүхий эдээс өндөр хамааралтай учир дэлхийн нийлүүлэлтийн сүлжээнд цаашид тасалдал үүсэх эрсдэлтэй байна. ОХУ-д тавьсан хориг арга хэмжээнүүдтэй холбоотойгоор байгалийн хий, нефтийн бүтээгдэхүүний үнэ өсөж улс орнуудад эрчим хүчний инфляцыг өдөөсөн бол Украины үр тариа, хүнсний экспортын бэрхшээлээс шалтгаалан бага орлоготой импортлогч орнуудад хүнсний хомсдол, инфляцын дарамт ихээхэн нэмэгдэв.


График 2. Инфляцын түвшин, төсөөлөл



Эх сурвалж: ОУВС-гийн төсөөлөл

Дэлхийн аж үйлдвэрлэлийн хэмжээ 2021 онд огцом сэргэж 4 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 17.9 хувиар өсөж байсан бол үүнээс хойш өсөлт эрчимтэй буурч 2022 оны 4 дүгээр сарын байдлаар 1.2 хувьд хүрээд байна. ОУВС-гийн дүгнэлтээр Украин дахь дайн, Төв банкнуудаас инфляцын эсрэг авч хэрэгжүүлж буй мөнгөний хатуу бодлого, Ковид-19 цар тахлын хязгаарлалтын үр дагавар, БНХАУ-ын эдийн засгийн өсөлтийн төлөв муудаж, улс орнуудын төсвийн бодлогын орон зай хумигдсан зэрэг нь дэлхийн аж үйлдвэрлэл, эдийн засгийн идэвхжил буурах үндсэн шалтгаан болж байна.

График 3. Дэлхийн аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн, худалдааны хэмжээний өөрчлөлт



Эх сурвалж: CPB Недедланд улсын эдийн засгийн бодлогын шинжилгээний товчоо, 2022 оны 4 дүгээр сарын байдлаар.


Аж үйлдвэрлэлийн үзүүлэлтийн адилаар дэлхийн худалдааны хэмжээ 2020 оны дунд үеэс идэвхжиж, 2021 оны 4 дүгээр сард түүхэн дээд түвшинд буюу өмнөх оны мөн үеэс 24.6 хувиар өссөн бол үүнээс хойш өсөлт удааширч, 2022 оны 4 дүгээр сарын байдлаар 3.1 хувьд хүрч буураад байна. Үүнд Азийн бүс нутаг дахь Ковид-19 цар тахлын хязгаарлалтаас шалтгаалсан нийлүүлэлтийн сүлжээний тасалдал, цар тахлын үеийн эдийн засгийн



дэмжлэгүүд дуусгавар болсон, геополитикийн хурцадмал байдал үүнээс шалтгаалсан худалдааны хориг арга хэмжээнүүд зэрэг хүчин зүйлс голлон нөлөөлж байна. Дэлхийн банк, ОУВС-гийн төсөөллөөр эдийн засгийн идэвхжил суларч байгаагаас үүдэн дэлхийн худалдааны өсөлт 2022 онд 4.0-5.0 хувь, 2023 онд 4.1-4.4 хувь байхаар байна.

Цар тахлын дараах дэлхийн эдийн засгийн идэвхжил, тэнцвэрт бус байдлаас шалтгаалсан инфляцын өндөр түвшин нь улс орнуудын Төв банкнууд мөнгөний бодлогоо эрчимтэй чангаруулах нөхцөлийг бүрдүүлэв. Нөгөө талдаа геополитикийн асуудлаас үүдэн тодорхойгүй байдал, макро эрсдэл нэмэгдэж байгаа нь зохицуулагч байгууллагуудад бодлогын сорилтыг бий болгож байна. Иймд цар тахал болон хөнгөлөлттэй зохицуулалтууд дуусаж байгаатай холбоотой хуримтлагдсан эрсдэлийг үнэлж, геополитикийн хурцадмал байдал болон хориг арга хэмжээнүүдийн цаашдын сөрөг нөлөөг харгалзан үзэж, макро эдийн засгийн бодлогоо тохируулан хэрэгжүүлэх нь чухал болж байна.

График 4. Бодлогын хүүгийн динамик




Хөрөнгийн зах зээлийн хувьд томоохон технологийн компаниудын үнэлгээ өссөнтэй холбоотойгоор хөрөнгийн зах зээл дээрх компаниудын хувьцааны үнийг илэрхийлэгч Nasdaq, S&P 500, MSCI World индексүүд 2021 оны эцэст түүхэн дээд түвшиндээ хүрэв. Мөн олон улсын засгийн газруудаас Ковид-19 цар тахлын дараа эдийн засгийг сэргээх бодлогууд хэрэгжүүлсэн нь хөрөнгө оруулагчдыг хувьцааны захад оролцох идэвхжилийг нэмэгдүүлсэн. Гэсэн хэдий ч Орос-Украины дайны нөхцөл байдал бий болсноор Европын бүсээс эхлээд дэлхий даяарх хөрөнгийн захууд дээрх хувьцааны үнийг 2021 оны эцсээс 2022 оны эхний хагас хүртэл унагах нөлөөг үзүүлж байна.

Хувьцаат компаниудын цаашдын орлогын төлөвийг Орос-Украины дайны нөхцөл байдал улам бүрхэг болгов. Ялангуяа, санхүүгийн эрсдэлд орсон компаниудын дийлэнх нь ОХУ-д байгаа бөгөөд тэдгээр компаниуд бусад улсын худалдааны хориг арга хэмжээнд өртөж, түүхий эдийн дутагдалд орсноор орлого нь буурахад нөлөөллөө.

Үүнтэй зэрэгцэн ОХУ-ын нийт гадаад өрийн 60 гаруй хувийг санхүүгийн бус бизнесийн компаниуд нь эзэлдэг учраас цаашид зээлийн эргэн төлөлтөө гүйцэтгэж чадахгүй болох эрсдэл нэмэгдэж байна. Улмаар ОХУ дахь хориг арга хэмжээ, эдийн засгийн удааширал, санхүүгийн эрсдэлтэй байдал нь тус улстай худалдаа, хөрөнгө оруулалтын харилцаатай европын бусад улсуудын эрчим хүчний компаниуд, томоохон төслүүдэд нөлөөлж байгаа нь ажиглагдаж байна.



График 5. Хөрөнгийн зах зээлийн голлогч индексүүд




Эх сурвалж: Блүүмберг

Цар тахлаас шалтгаалан эдийн засгийн үйл ажиллагаа буурах үед дэлхийн улс орнуудаас компани, өрхүүдэд урьд өмнө нь байгаагүй илүү их хөрвөх чадвартай санхүүгийн дэмжлэг үзүүлээ. Ялангуяа, мөнгөний болон сангийн зөөлөн бодлогыг уялдуулж, бэлэн мөнгөний шилжүүлэг, дахин санхүүжилтийн тусламж, зээл, баталгааны хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэв.

Хөгжиж буй орнуудын дотоодын бондын зах дээрх гадаад болон дотоодын хөрөнгө оруулагчдын хязгаарлагдмал байдлаас шалтгаалан засгийн газрын хэрэгцээт нэмэлт санхүүжилтийн өсөлтийн дийлэнхийг дотоодын банкнууд хангав. Үр дүнд нь засгийн газар болон дотоодын банкнуудын хоорондын санхүүгийн харилцаа холбоо эдгээр улсуудад нэлээд идэвхжив. Тухайлбал, цар тахлын өмнө хөгжиж буй орнуудын засгийн газрын нийт өр ба ДНБ-ний харьцаа дунджаар 52% байсан бол 2021 онд 67% хүртэл өссөн байна.

График 6. Засгийн газрын урт хугацааны бондын өгөөжийн түвшин



Эх сурвалж: Блүүмберг

Тайлбар: 10 жилийн хугацаатай бондын өгөөж

Эх сурвалж: ОУВС

Дотоодын эдийн засгийн нөхцөл байдал:
Монгол Улсын эдийн засгийн хувьд хамгийн таатай үе нь олон улсад түүхий эдийн супер





ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

цикл болсон 2010-2013 онуудад байсан бөгөөд бизнесийн мөчлөгийн хувьд эдийн засаг нь төрөлжсөн бусад улс орнуудтай харьцуулахад богино, түүхий эдийн үнийн мөчлөгийг дагадаг шинж ажиглагддаг. 2017 оноос хойш улсын төсвийн гүйцэтгэлд эерэг өөрчлөлтүүд гарч, макро эдийн засгийн бодлогын уялдаа сайжирч, түүхий эдийн үнэ харьцангуй өндөр түвшинд хадгалагдсаны зэрэгцээ хувийн хөрөнгө оруулалт огцом нэмэгдсэн нь 2020 оныг хүртэл эдийн засгийн хувьд таатай байх нөхцөл бүрдсэн.

Гэвч 2020 оноос дэлхий нийтийг хамарсан сорилт болсон Ковид-19 цар тахлын нөлөөгөөр дэлхий дахинд түүхий эдийн эрэлт эрс буурч үнэ нь огцом унаж, улс орны хэмжээнд тогтоосон ээлжит хөл хорио, ялангуяа БНХАУ-аас хилээ хаасан нь эдийн засгийн өсөлт 1990 оноос хойш ёроолдоо хүрч 4.6%-аар унахад нөлөөлсөн. Улмаар 2021 оны эхэнд эдийн засаг эрчимтэй сэргэж байсан боловч гадаад худалдааны салбарт учирсан хүндрэл бэрхшээлээс шалтгаалан эдийн засгийн өсөлт зогсонги байдалд орж ердөө 1.4 хувиар л өсжээ. Гадаад худалдааны саатал эхлэхээс өмнө 2021 оны эхний улиралд нүүрсний олборлолт эрчимжиж, зэсийн хүдрийн агууламж сайжирч, үйлчилгээний салбар сэргэсэн нь эдийн засгийн өсөлтийг голлон дэмжсэн.

Үйлчилгээний салбар (эрүүл мэнд, мэдээлэл харилцааны технологи, худалдаа, зочид буудал болон ресторан, түүнчлэн санхүүгийн үйлчилгээ) 2021 оны ДНБ-ий 1.8 нэгж хувийг бүрдүүлсэн нь 2021 оны 2 дугаар хагасаас Ковид-19-тэй холбоотой дотоод хязгаарлалтуудыг сулруулсны үр дүн бөгөөд эсрэгээрээ аж үйлдвэрийн салбар зогсонги байдалд орсон бол хилийн боомтуудын доголдоос шалтгаалан барилгын материалын нийлүүлэлт тасалдаж барилгын салбар уналтад орсон.

Азийн хөгжлийн банкнаас гаргасан тайлангаас үзвэл 2022 онд инфляц өсч өндөр түвшинд хүрсэн, гадаад худалдааны тасалдал үргэлжилсээр байгаа, гадаад санхүүжилтийн нөхцөлүүд урьд өмнөхөөс илүү чангарах хүлээлттэй болсон, мөн геополитикийн нарийн төвөгтэй асуудал шинээр бий болж эрсдэл нэмэгдсэн зэрэг нь Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг үлэмж хязгаарлагдахаар байна. Харин 2023 онд коронавируст цар тахал (КОВИД-19)-ын сөрөг нөлөөлөл буурах, гадаад худалдааны тасалдал арилах боломжтой зэрэг эерэг хүлээлтэд тулгуурлан эдийн засгийн өсөлт нэмэгдэх төсөөлөлтэй байна

Эдийн засгийн өсөлт 2022 оны 2 дугаар улиралд төсөөллөөс 3.1 нэгж хувиар өндөр гарсан бөгөөд үүнд нүүрс, зэсийн баяжмалын олборлолт хүлээлтээс бага гарч, уул уурхайн салбарын үйлдвэрлэл төсөөллөөс бага зэрэг муудсан ч эрчим хүчнээс бусад уул уурхайн бус салбаруудын үйлдвэрлэл хүлээлтээс давж, эдийн засгийн өсөлтийг дэмжлээ. Эдийн засгийн өсөлт ийнхүү хүлээлтээс өндөр гарсантай уялдуулан энэ оны өсөлтийн төсөөллийг 3 хувьд хүргэж нэмэгдүүлэв. Уул уурхайн бус салбарт эрчим хүч, боловсруулах, үйлчилгээний салбаруудаас бусад салбаруудын үйлдвэрлэл өмнөх төсөөллөөс нэмэгдэхээр байна.

Тодруулбал, цаг агаарын таатай нөхцөл байдал нь хөдөө аж ахуйн салбарыг дэмжиж, хөл хорионы дэглэм суларч, дотоод эрэлт сэргэж байгаатай холбоотойгоор худалдаа, үйлчилгээний зарим салбаруудын идэвхжил үргэлжилж, үүнээс улбаалан татварын орлого бүрдүүлэлт нэмэгдэнэ гэж үзлээ. Хилийн боомтууд дээрх хязгаарлалтууд суларч, экспорт сэргэж байгаатай холбоотойгоор уул уурхайн салбарын өсөлтийг өмнөх төсөөллөөс сайжрууллаа.





Харин зээл олголт хумигдсантай холбоотойгоор санхүү, даатгалын үйлчилгээ буурч, үйлчилгээний салбар оны сүүлийн хагаст удаашрахаар байна. Дунд хугацаанд Оюу толгойн үйлдвэрлэл нэмэгдэх, нүүрсний экспорт хэвийн түвшинд хүрэх, газрын тосны олборлолт сайжрахаар байгаа нь уул уурхайн салбарын өсөлтийг тэтгэх бол гадаад эрэлт саарах, худалдааны нөхцөл муудах, төсвийн төлөв чангарах нь уул уурхайн бус салбарын өсөлтийг сааруулахаар байна.

Мөн олон улсын байгууллага, шинжээчдийн сүүлийн үеийн таамаглалаар Монгол Улсын эдийн засаг 2022 онд дунджаар 5.9%-иар өсөх хүлээлттэй байна.

- Олон улсын валютын сангийн зүгээс нүүрсний экспорт эргэж сэргэх, Оюу толгой зэсийн уурхайн хоёр дахь шатны бүтээн байгуулалт ашиглалтад орсноор зэсийн экспорт нэмэгдэх, Оюу толгой төслийн бүтээн байгуулалт бүрэн дууссанаар импортын орчин сайжрах зэрэгт үндэслэн 2022-2023 онд Монгол Улсын эдийн засгийн өсөлтийн хурд нэмэгдэх таамаглалыг гаргасан.
- Азийн хөгжлийн банкны зүгээс вакцинжуулалтын хөтөлбөрийн үр нөлөөгөөр цар тахлын нөхцөл байдал сайжрах, экспортод хүндрэл учруулж буй тээвэр логистикийн асуудал шийдэгдэх, дотоод эрэлтийн хэмжээ өсөн нэмэгдэх таамаглалд үндэслэн Монгол Улсын 2022 оны эдийн засгийн өсөлт өмнөх оны үзүүлэлтээс нэмэгдэхээр тооцсон.
- Дэлхийн банкны зүгээс дотоодын эдийн засгийг дэмжих бодлогын арга хэмжээнүүд, дэлхийн эдийн засгийн эерэг төлөв, үр дүнтэй вакцинжуулалт зэрэг хүчин зүйлд үндэслэн Монгол Улсын эдийн засаг 2022 онд 5.1%-иар өсөх таамаглал дэвшүүлсэн байна.

Монгол Улсын экспортын голлох эрдэс бүтээгдэхүүний үнэ өсөж, худалдааны нөхцөл эрс сайжирсан боловч БНХАУ-ын “Тэг Ковид” бодлогоос шалтгаалан хилийн боомтууд хэсэгчлэн болон бүрэн хаагдсанаар экспортын биет хэмжээний өсөлт удааширч, барааны импортын зардал огцом өсөж, улмаар урсгал тэнцлийн алдагдал ихээхэн тэлэв. Хэдийгээр хөрөнгийн дотогшлох урсгал сайжирч, гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдсэн ч урсгал тэнцлийн томоохон алдагдлыг санхүүжүүлэхэд хангалтгүй байсан тул төлбөрийн тэнцэл 2022 оны эхний хагаст 1058.0 сая ам.долларын алдагдалтай гарав.

Ийнхүү төлбөрийн тэнцлийн алдагдал нэмэгдсэн нь төгрөгийн ханш сулрах дарамтыг нэмэгдүүлж, улмаар ханшийн огцом хэлбэлзлийг бууруулах зорилгоор хийгдсэн Монголбанкны интервенцийн үр дүнд гадаад валютын албан нөөцийн хэмжээ буурч, 2022 оны 6 дугаар сарын эцэст 3097.0 сая ам.долларт хүрэв.

Өндөр инфляц, гадаад эдийн засгийн тогтворгүй байдлаас үүдэн аж ахуйн нэгжүүдийн үйлдвэрлэлийн зардал өсөж, ашигт ажиллагаа, төлбөрийн чадварт сөргөөр нөлөөлж байна. Түүнчлэн хувийн секторт олгосон зээлийн салбараарх төвлөрөл нэмэгдэх хандлагатай байгаа нь банкны салбарын эмзэг байдлыг нэмэгдүүлээ. Үүнээс зарим салбаруудад гадна аж ахуй нэгжүүдийн үйл ажиллагааны сэргэлт удаашралтай байгаа нь борлуулалтын орлого буурах, зээлийн эрсдэлийг нэмэгдүүлжээ.



Улсын нэгдсэн төсвийн нийт орлого, тусламжийн хэмжээ 2022 оны эхний 11 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 15.7 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2.3 (17.4%) их наяд төгрөг, тэнцвэржүүлсэн орлого тусламжийн хэмжээ 14.4 их наяд төгрөг болж, 2.7 (23.5%) их наяд төгрөгөөр тус тус өссөн байна. Нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 2022 оны эхний 11 сард 15.6 их наяд төгрөг болж, тэнцвэржүүлсэн тэнцэл 1.1 их наяд төгрөгийн алдагдалтай гарч, төсвийн алдагдал өмнөх оны мөн үеэс 740.8 (39.3%) тэрбум төгрөгөөр буурчээ.

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн хэмжээ 2022 оны 11 дүгээр сард 1.4 их наяд төгрөг болж, өмнөх сараас 4.5 (0.3%) тэрбум төгрөгөөр буурч, нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 1.6 их наяд төгрөг болж, 66.2 (4.4%) тэрбум төгрөгөөр өсжээ. Татварын нийт орлого 2022 оны эхний 11 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 13.1 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2.7 (26.3%) их наяд төгрөгөөр өсөхөд нэмэгдсэн өртгийн албан татвар 954.5 (37.2%) тэрбум төгрөг, нийгмийн даатгалын орлого 691.2 (35.5%) тэрбум төгрөг, бусад төрлийн татварын орлого 1.1 (2.3 дахин) их наяд төгрөгөөр тус тус өссөн нь голлон нөлөөлжээ. Харин орлогын албан татварын орлого 417.4 (13.1%) тэрбум төгрөгөөр буурчээ.

Татварын нийт орлого 2022 оны 11 дүгээр сарын урьдчилсан гүйцэтгэлээр 1.1 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 152.4 (16.2%) тэрбум төгрөгөөр өссөн бөгөөд татварын нийт орлогод 2022 оны эхний 11 сарын байдлаар бусад татвар, төлбөр, хураамжийн орлогын эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 6.8 нэгж хувь, нэмэгдсэн өртгийн албан татварынх 2.1 нэгж хувь, нийгмийн даатгалын орлогынх 1.4 нэгж хувь, гадаад үйл ажиллагааны орлогынх 0.8 нэгж хувиар тус тус өсөж, харин орлогын албан татварынх 9.6 нэгж хувь, онцгой албан татварын орлогынх 1.5 нэгж хувиар тус тус буурсан байна.

Улсын нэгдсэн төсвийн зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 2022 оны эхний 11 сард 15.6 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2.0 (14.8%) их наяд төгрөгөөр өссөн байна. Зарлагын өсөлтөд урсгал шилжүүлгийн зардал өмнөх оны мөн үеэс 1.7 (27.0%) их наяд төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна. Харин бараа, үйлчилгээний зардал 697.8 (17.9%) тэрбум төгрөгөөр буурчээ. Харин хөрөнгийн зардал 2022 оны эхний 11 сард 2.8 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 802.8 (39.6%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

График 8. Улсын нэгдсэн төсвийн орлого, зарлага

- Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого
- Нэгдсэн төсвийн зарлага
- Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл





ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЦУУЛГА

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ: 2022 оны 11 дүгээр сард улсын хэмжээнд өмнөх оны мөн үеэс 14.5 хувь, өмнөх оны эцсээс 12.1 хувиар, өмнөх сараас 1.1 хувиар өссөн байна. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2022 оны 11 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 14.5 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 16.8 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 8.0 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 19.4 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 16.6 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 21.4 хувь, тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 7.7 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2022 оны 11 дүгээр сард өмнөх оны эцсээс 12.1 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 13.3 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 7.5 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 17.1 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 14.8 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 17.9 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2022 оны 11 дүгээр сард өмнөх сараас 1.1 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 2.0 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 0.8 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 1.5 хувь, тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 0.3 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Инфляцын түвшин буюу хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2021 оны 11 дүгээр сард 11.0 хувь гарсан бол 2022 оны 11 дугаар сард 14.5 хувь болж, өмнөх оны мөн үеэс 3.5 нэгж хувиар өссөн бөгөөд инфляц 2022 оны 11 дүгээр сард 14.5 нэгж хувь гарсны 7.4 (51.1%) нэгж хувь нь импортын барааны үнийн өсөлтөөс шалтгаалсан байна.

Санхүүгийн салбарын нөхцөл байдал: Банкны салбарын нийт активын хэмжээ 2022 оны 2 дугаар улиралд 41.9 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 5.6 хувиар буюу 2.2 их наяд төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт активын өсөлт 11.5 нэгж хувиар буурсан байна. Активыг бүтцээр нь авч үзвэл 2022 оны эхний хагас жилийн байдлаар зээл (цэврээр) 4.3 их наяд төгрөгөөр, мөнгөн хөрөнгө 2.0 их наяд төгрөгөөр, бусад актив 0.5 их наяд төгрөгөөр тус тус өссөн бол банкнуудын эрсдэл багатай үнэт цаас дахь хөрөнгө оруулалт, тухайлбал, Төв банкны үнэт цаас дахь хөрөнгө оруулалт 4.5 тэрбум төгрөгөөр, Засгийн газрын үнэт цаас дахь хөрөнгө оруулалт 0.1 их наяд төгрөгөөр тус тус буурсан байна.

Банкны салбарын зээлийн өрийн үлдэгдэл 2022 оны эхний хагаст 23.4 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 22.4 хувиар өсжээ. Энэхүү өөрчлөлтийг зээлдэгчийн төрлөөр салгаж үзвэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад худалдааны болон хэрэглээ, өрхийн аж ахуйн зээл хамгийн өндөр буюу 33.8 хувь болон 33.6 хувиар тус тус өссөн байна. Нийт зээлийн өсөлтийн хамгийн их хэсэг буюу 29.0 хувийг иргэдэд олгосон зээлийн өсөлт бүрдүүлж байгаа бол том аж ахуйн нэгжид олгосон зээлийн өсөлт 17.5 хувийг, дунд аж ахуйн нэгжид олгосон зээлийн өсөлт 14.3 хувийг, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид олгосон зээлийн өсөлт 10.9 хувийг тус тус бүрдүүлжээ. 2022 оны 2 дугаар улирлын байдлаар банкны системийн хэмжээнд олгох боломжит зээлийн дүн 3.7 их наяд төгрөгт хүрсэн байна.

График 9. Зээл, салбараар






Эх сурвалж: Монголбанк

2022 эхний хагас жилд банкны системийн чанаргүй зээл 1.9 их наяд төгрөг, анхаарал хандуулах зээл 1.4 их наяд төгрөгт хүрч, нийт эргэн төлөлтийн доголдолтой зээлийн дүн 3.3 их наяд төгрөгт хүрсэн бөгөөд чанаргүй зээл нийт зээлийн 8.2 хувь, эргэн төлөлтийн доголдолтой зээл 14.3 хувийг тус тус эзэлж байна. Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.3 нэгж хувиар буурсан бөгөөд энэ нь зээлийн чанар сайжирснаас бус харин системийн нийт зээлийн өсөлтөөр тайлбарлагдаж байна.

График 10. Чанаргүй, анхаарал хандуулах зээлийн нийт зээлд эзлэх хувь





Эх сурвалж: Монголбанк

Даатгалын зах зээлд нийт хөрөнгөөрөө эхний 5-д жагсаж байгаа даатгалын компанийн хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үед нийт зах зээлийн 55.0 хувийг эзэлж байсан бол тайлант улиралд 52.1 хувь болж буурчээ. Даатгалын компаниудын нийт хөрөнгө 2022 оны 2 дугаар улирлын байдлаар 431.4 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 2.5 тэрбум төгрөгөөр буюу 0.6 хувиар өссөн байна. Харин нөөц сангийн хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 1.8 хувиар буурч 185.9 тэрбум төгрөгт хүрлээ. Даатгалын тохиолдлын улмаас урт хугацааны болон ердийн даатгалын компаниуд 2022 оны 2 дугаар улирлын байдлаар нийт 48.5 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгосон нь өмнөх оны мөн үеэс 66.1 хувиар өссөн.






График 11 Даатгалын салбарын хөрөнгө, нөөц сан, нөхөн төлбөр (тэрбум төгрөг)



Ердийн болон урт хугацааны даатгалын компаниуд нийт 124.3 тэрбум төгрөгийн даатгалын хураамж төвлөрүүлсний 98.7 хувь буюу 122.6 тэрбум төгрөгийг ердийн даатгалын компаниуд, 1.3 хувь буюу 1.6 тэрбум төгрөгийг урт хугацааны даатгалын компани тус тус төвлөрүүлсэн бөгөөд даатгалын хураамж өмнөх оны мөн үеэс 11.9 хувиар өссөн байна.

График 12. ББСБ-ын нийт хөрөнгө ба зээл (тэрбум төгрөг)




Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан 527 банк бус санхүүгийн байгууллага /ББСБ/ үйл ажиллагаа эрхэлж байгаагаас 83.1 хувь нь Улаанбаатар хотод байршдаг. Нийт ББСБ-уудын 92.7 хувь буюу 489 нь зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай

зөвшөөрөлтэй. Банк бус санхүүгийн байгууллагуудын нийт хөрөнгө болон зээл олголт эрчимтэй тэлж байна. Тухайлбал нийт хөрөнгө 2022 оны 2 дугаар улиралд 3.2 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 40.6 хувиар, нийт зээлийн хэмжээ 2.5 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 58.9 хувиар тус тус өссөн байна. Салбарын нийт харилцагчдын тоо давхардсан тоогоор 4.7 сая хүрч өмнөх оны мөн үеэс 44.2 хувиар өсөж, зээлдэгчдийн тоо 1.5 саяд хүрч өмнөх оны мөн үеэс 102.1 хувиар өссөн.

График 13. ББСБ-ын зээлийн чанар, эхний хагас жилийн байдлаар





Эх сурвалж: СЗХ


2022 оны 2 дугаар улирлын байдлаар тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж буй Хадгаламж зээлийн хоршоо /ХЗХ/-дын тоо өмнөх онтой харьцуулахад 34-өөр буюу 14.5 хувиар буурч 200 ХЗХ болсон байна. Харин ХЗХ-дын гишүүдийн тоо 73,719 байсан бол тайлант үед 1.56 хувиар буурч 72,566 гишүүн болжээ. Тайлант улиралд нийт 200 ХЗХ-ноос 110 ХЗХ нь Улаанбаатар хотод, 90 ХЗХ нь орон нутагт бүртгэлтэй байна.

Улаанбаатар хотын хэмжээнд энэ дүн 9.6 сая төгрөг байгаа бол орон нутагт 2.8 сая төгрөг байна. Тайлант улиралд нийт хөрөнгө өмнөх оны мөн үеэс 0.42 хувиар өсөж 271.6 тэрбум төгрөгт хүрлээ. Харин нийт зээлийн хэмжээ 217.8 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 16.6 хувиар өслөө. Цэвэр зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 16.7 хувиар өсөж 212.2 тэрбум төгрөгт, зээлийн эрсдэлийн сангийн хэмжээ 11.8 хувиар өсөж 5.6 тэрбум төгрөгт хүрлээ. Тайлант үед хэвийн зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 17.3 хувиар өсөж 204.9 тэрбум төгрөг, хугацаа хэтэрсэн зээлийн хэмжээ 10.0 хувиар өсөж 5.6 тэрбум төгрөг, чанаргүй зээлийн хэмжээ 4.7 хувиар нэмэгдэж 7.2 тэрбум төгрөгт тус тус хүрлээ.

График 14. ХЗХ-дын салбарын нийт хөрөнгө, Хадгаламж, зээлийн чанар (тэрбум төгрөг)



Эх сурвалж: СЗХ




Эх сурвалж: СЗХ





Нийт олгосон зээлийн 66.2 хувь нь хэрэглээ болон түүнд холбогдох бусад зориулалтаар, 10.7 хувь нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт, 4.8 хувь нь хөдөө аж ахуйн салбарт олгогдсон байна. Нийт эргэн төлөгдсөн зээлийн 70.5 хувь нь хэрэглээ болон түүнд холбогдох бусад зориулалтаар олгосон зээлээс, 9.3 хувь нь бөөний болон жижиглэнгийн худалдааны үйл ажиллагаанаас, 5.0 хувь нь хөдөө аж ахуйн салбараас эргэн төлөгдсөн байна.

График 15. ХЗХ-ийн чанаргүй зээлийн ангилал



Эх сурвалж: СЗХ

Нийт зээлийн 94.1 хувийг хэвийн, 2.6 хувийг хугацаа хэтэрсэн, 3.3 хувийг чанаргүй зээл тус тус эзэлж байна. Чанаргүй зээлийн ангилал дахь хэвийн бус зээлийн эзлэх хувь өнгөрсөн оны мөн үеэс 4.1 нэгж хувиар буурч 25.1 хувь болжээ.

Эргэлзээтэй зээлийн хувьд өнгөрсөн оноос 2.1 нэгж хувиар буурч 17.7 хувьд хүрсэн бол муу зээлийн нийт чанаргүй зээлд эзлэх жин 57.2 хувь байна.

Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн нөхцөл байдал: Манай улсын хувьд төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцооноос зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжих шилжилтийн эхний үе шатанд үнэт цаасны зах зээлийг өмч хувьчлалыг хэрэгжүүлэх хэрэгсэл хэлбэрээр үүсгэн байгуулсан бөгөөд Улсын Бага Хурлаас 1991 оны 5 дугаар сард батлагдсан Өмч хувьчлах тухай хуулиар өмч хувьчлалын зарчим, хувьчлалд хамрагдах өмчлөлийн зүйлс, хувьчлал явуулах арга хэлбэр, хэрэгжүүлэх ажлын удирдлага, зохион байгуулалтыг тодорхойлон зохицуулсан.

Их хувьчлалыг хэрэгжүүлэхээр үйлдвэрийн газруудыг хувьцаат компани болгон өөрчлөн зохион байгуулж, тэдгээрийн хувьцааг ХОЭБ-ээр худалдаалах ажлыг зохион байгуулахаар 1991 онд хөрөнгийн биржийг байгуулсан бөгөөд 1992 оны 2 дугаар сарын 07-ний өдөр анхдагч зах зээлийн анхны арилжаа явагдаж, 1995 оны 5 дугаар сард хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн. Хөгжиж буй болон хөгжингүй орнуудын туршлагаас үзэхэд хөрөнгийн зах зээлийн хөгжлийг зах зээлийн үнэлгээ, оролцогчид, индекс, хөрвөх чадварын үзүүлэлтээр илэрхийлдэг бөгөөд хоорондын уялдааг эрэлт, нийлүүлэлт, дэд бүтэц, төрийн зохицуулалт, бодлогын орчноор илэрхийлдэг.

Хөрөнгийн зах зээлийн хөгжлийн үзүүлэлтүүд: Хөрөнгийн зах зээлд “Монголын хөрөнгийн бирж” ХК, “Улаанбаатар үнэт цаасны бирж” ХК, “Чингис хаан хөрөнгийн бирж” ХХК зэрэг 3 арилжаа эрхлэх байгууллага үйл ажиллагаа явуулж буй хэдий ч хувийн өмчит “Улаанбаатар үнэт цаасны бирж” ХК-д 1 хувьцаат компанийн хувьцаа арилжаалагдаж,



арилжааны идэвх сул байгаа бол “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн үзүүлэлтээр зах зээлийн хөгжлийн үзүүлэлтийг төлөөлүүлэн авч үзэж байна. Зах зээлийн үнэлгээний үзүүлэлтүүдийг графикаар үзүүлбэл

График 16. Зах зээлийн үнэлгээний ДНБ-д эзлэх хувь хэмжээ



Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 2022 оны 3 дугаар улирлын байдлаар 4.7 их наяд төгрөг болсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.16 хувиар буурсан бөгөөд уг үзүүлэлт ДНБ-ний 11.13 хувийг эзэлж байна. Хөрөнгийн зах зээлийн үнэлгээний 90 гаруй хувийг ТОП-20 индексийн сагсанд бүртгэлтэй хувьцаат компанийн үзүүлэлт бүрдүүлдэг бөгөөд зах зээлийн үнэлгээний өсөлтөд зах зээлд арилжаалагдаж буй хувьцаат компаниуд болох “АПУ” ХК, “Таван толгой” ХК, “МИК Холдинг” ХК, Канадын хөрөнгийн биржид бүртгэлтэй “Эрдэнэ ресурс” ХК-ийн давхар бүртгэлтэй хувьцааг дотоодын биржид бүртгэсэнтэй холбоотойгоор зах зээлийн үнэлгээний хэмжээ нэмэгдсэн бол Банкны салбарын шинэчлэлийн хүрээнд “Богд банк” ХК, “Голомт банк” ХК хувьцаагаа олон нийтэд санал болгон гаргасан нь зах зээлийн үнэлгээг нэмэгдэхэд нөлөөлсөн.

Хөрвөх чадварын хувьд Дэлхийн банкнаас гаргасан үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн байдлаар Монгол Улсын багтдаг ангилал буюу дунджаас бага орлоготой орнуудын хөрвөх чадварын үзүүлэлт 53.6 хувь байгаа бол өндөр орлоготой орнуудын хөрвөх чадварын үзүүлэлт 2020 оны жилийн эцсийн байдлаар 98.6 хувь байна. Монгол Улсын хувьд хувьцааны хөрвөх чадвар энэ оны 3 дугаар улирлын байдлаар 2.69 хувь байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.06 пунктээр буурсан байна.

Хөрвөх чадварыг тооцохдоо тайлант хугацаанд хийгдсэн хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжааны дүнг нийт зах зээлийн үнэлгээнд харьцуулж тооцдог бөгөөд хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжаа 57.18 тэрбум төгрөгөөр буурснаас гадна зах зээлийн үнэлгээний өсөлт өндөр байсан тул буурсан үзүүлэлттэй байна. Түүнчлэн, хөрвөх чадварын үзүүлэлт олон улсын дундаж үзүүлэлттэй харьцуулахад маш бага түвшинд байгаа нь голчлон хувьцааны төвлөрөлтэй хамааралтай байна.

График 17. Хөрвөх чадвар /хувиар/





“Монголын хөрөнгийн бирж” ХК-д ТОП-20, MSE-A, MSE-B гэсэн гурван төрлийн хувьцааны үнийн индексүүдийг тооцон гаргадаг. Зах зээлийн үнэлгээ болон хувьцаа нь идэвхтэй арилжаалагддаг нэр бүхий 20 компаниас бүрдэж буй ТОП-20 индексийн дээд үзүүлэлт тайлант хугацааны байдлаар 36,033.30 нэгж, доод үзүүлэлт 32,836.01 нэгж, дундаж үзүүлэлт 34,568.58 нэгж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8,913.00 нэгжээр буюу 20.76 хувиар буурч, 34,024.26 нэгж болсон байна. Үүнд хөрөнгийн захад бүртгэлтэй “АПУ”, “Ард санхүүгийн нэгдэл”, “Говь” зэрэг ТОП-20 индексийг бүрдүүлэгч дийлэнх компаниудын хувьцааны үнэ оны эхнээс буурч байгаатай холбоотой юм.

“Монголын хөрөнгийн бирж” ХК-аас 2018 онд үнэт цаасны бүртгэлийн I, II ангилалд багтсан компаниудын хамаарах MSE-A болон MSE-B индексийг тооцон гаргадаг болсон. MSE-A индексийн дээд үзүүлэлт тайлант хугацааны байдлаар 13,654.82 нэгж, доод үзүүлэлт 12,098.54 нэгж, дундаж үзүүлэлт 12,800.31 нэгж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 12,800.31 нэгжээр буюу 13.41 хувиар өсөж 12,098.54 нэгж болсон байна.

Харин MSE-B индексийн дээд үзүүлэлт 12,315.82 нэгж, доод үзүүлэлт 11,397.98 нэгж, дундаж үзүүлэлт 11,918.03 нэгж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 298.35 нэгжээр буюу 2.43 хувиар буурч 11,972.15 нэгж болсон байна.

Хүснэгт 14. ТОП-20 индекс

Индекс	2021.09.30	2022.09.30	Өөрчлөлт
ТОП 20	42,937.26	34,024.26	-20.76%

ТОП-20 индексийн сагсыг 54.9 хувийг аж үйлдвэрлэлийн үнэт цаас гаргагч, 20.1 хувийг банк санхүүгийн салбар, 18.3 хувийг уул уурхай, 3.5 хувийг худалдаа, 3.2 хувийг харилцаа холбооны компани бүрдүүлж байгаа бөгөөд 2018 оноос хойших хугацаанд санхүүгийн салбарт үйл ажиллагаа эрхлэгч компаниуд болох Мандал даатгал, Ард даатгал, Бодь даатгал, Монгол даатгал ХК, Лэндмн ББСБ, Ард кредит ББСБ, Инвескор ББСБ ХК, Бодь банк ХК, Төрийн банк ХК зэрэг компаниуд үнэт цаасаа олон нийтэд санал болгох замаар хувьцаат компанийн хэлбэрт шилжиж, хувьцаа нь зах зээлд идэвхтэй арилжаалагдаж байгаа нь ТОП индексийг бүрдүүлэхэд томоохон нөлөөг үзүүлсэн байна.


Тайлант улиралд нийт 150.4 тэрбум төгрөгийн хувьцааны арилжаа хийгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 19.17 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Тайлант улиралд



ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

хувьцааны хоёрдогч зах зээлд нийт 128.95 тэрбум төгрөгийн хувьцааны арилжаа хийгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 30.72 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

График 18. Хөрөнгийн зах зээлийн анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаа



2022 оны 3 дугаар улиралд нийт 61 удаагийн үнэт цаасны арилжаа явагдаж, хувьцааны анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаагаар 111 ХК-ийн 152.8 сая ширхэг хувьцааг 36.72 тэрбум төгрөгөөр, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаагаар 117.25 мянган ширхэг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг 11.72 тэрбум төгрөгөөр, Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн хоёрдогч зах зээлийн арилжаагаар 1.6 сая ширхэг нэгж эрхийг 0.8 тэрбум төгрөгөөр, Компанийн бондын хоёрдогч зах зээлийн арилжаагаар 23.4 мянган ширхэг бондыг 3.21 тэрбум төгрөгөөр тус тус арилжиж, нийт 52.47 тэрбум төгрөгийн арилжаа хийсэн.

Тайлант хугацаанд өдөрт дунджаар 2.5 сая ширхэг үнэт цаасыг 0.86 тэрбум төгрөгөөр арилжсан байна. Нийт арилжааны үнийн дүнгийн 69.98 хувь буюу 36.72 тэрбум төгрөгийг хувьцааны арилжаа, 22.34 хувь буюу 11.72 тэрбум төгрөгийг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа, 1.54 хувь буюу 0.8 тэрбум төгрөгийг хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн арилжаа, 6.13 хувь буюу 3.2 тэрбум төгрөгийг компанийн бондын арилжаа тус тус эзэлж байна.


Олон нийтэд шинээр болон нэмж хувьцаа гаргах ажиллагаа 2007-2008 онуудад эрс идэвхэжсэн боловч 2008 онд тохиолдсон дэлхийн санхүүгийн зах зээлийн хямралт байдал, арилжааны нэр бүхий 2 банк дампуурсантай холбоотойгоор 2017 оныг хүртэлх хугацаанд хангалттай байсан боловч 2017 оноос аж ахуйн нэгжүүд хувьцаа болон өрийн хэрэгслийг олон нийтэд санал болгон гаргах замаар санхүүжилт татах төвлөрүүлэх, олон нийтийн хяналттай хувьцаат компани болох сонирхол эрс нэмэгдсэн. 2005-2022 оны 3 дугаар улирлын байдлаар 29 компани шинээр хувьцааг олон нийтэд санал болгох замаар 139.8 тэрбум, 16 компани нэмж хувьцаа гаргах замаар 39.0 тэрбум төгрөгийг хөрөнгийн зах зээлээс татан төвлөрүүлсэн.

Үнэт цаасны зах зээлд оролцогчдыг төвлөрсөн хадгаламжид бүртгэлтэй дансны нийт тоогоор авч үзэж байгаа бөгөөд 2022 оны 3 дугаар улирлын байдлаар 3,898 данс нээгдэж өссөн дүнгээр нийт 2,439,127 данс нээгдсэн байна. Мөн хугацаанд 15,727 холболтын данс нээгдэж нийт 499,223 холболтын данс нээгджээ. Тайлант хугацаанд нийт арилжаанд



дотоодын иргэний хийсэн арилжаа 52.88 хувь, дотоодын аж ахуйн нэгжийн хийсэн арилжаа 43.73 хувьд, гадаадын иргэний хийсэн арилжаа 2.18 хувь, гадаадын аж ахуйн нэгжийн хийсэн арилжаа 1.20 хувийг тус тус эзэлж байна.

График 19. Хөрөнгө оруулагчдын бүтэц /арилжаанд эзлэх хувиар/



УИХ-аас 2021 онд баталсан Банкны тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлт болон 2022 онд баталсан “Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл”-үүдэд системийн ач холбогдолтой арилжааны банкууд болох “Төрийн банк” ХК, “Голомт банк” ХК, “Хаанбанк” ХХК нь олон нийтэд хувьцаагаа санал болгон гаргаж, нээлттэй хувьцаат компани болсон бол төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн нэг дэд бүтцийн томоохон байгууллага болох “Монголын хөрөнгийн бирж” ХК хувьцааны тодорхой хувийг олон нийтэд санал болгон худалдахаар шийдвэрлэсэн нь хөрөнгийн зах зээлд шинэ төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, зах зээлийн багтаамжийг нэмэгдүүлэх боломж бүрдэж байна.

2.2. Олон улсын болон Монгол улсын хэмжээнд дэх лоттерей буюу хонжворт сугалааны салбарын нөхцөл байдал:

Хонжворт сугалааны салбар нь баялаг түүхтэй бөгөөд анхлан эртний Ромын эзэнт гүрэнд үүсэж, дэлгэрсэн байна. Үүсэл хөгжлийн үе шатанд оролцогчид буюу тоглогчид холбогдох дүрмээ тогтоон, биет хэлбэртэй зүйлсийг ашиглан тоглодог байсан бол сүүлийн жилүүдэд мэдээлэл технологийн салбарын хөгжлөөс шалтгаалан уламжлалт хонжворт сугалааны хэлбэрээс цахим хэлбэрт хурдацтай шилжиж, оролцогчид газар нутаг, цагийн бүсчлэлээс үл хамааран оролцох боломж бүрдэж байна.

Олон улсын хэмжээнд түгээмэл хэрэглэгддэг хонжворт сугалааны төрөл нь лотто буюу лоттерей бөгөөд уг сугалаа нь санамсаргүй байдлаар тоо тааж, тохирол таарсан тохиолдолд шагнал олгодог бооцоот, хонжворт тоглоомын хамгийн алдартай төрөл юм. Технавиогийн мэдээлснээр Дэлхийн сугалааны зах зээл 2020 онд 356 тэрбум долларын борлуулалтын хийсэн бөгөөд 2025 он гэхэд 54%-иар өсч, 550 тэрбум доллар давах төлөвтэй байна гэж үзсэн байна.¹

¹ <https://ir.lottery.com/node/7531/html#T17>





Сугалааны төрөл

Хонжворт сугалааны зах зээлийг ерөнхийдөө 3 бүлэгт хувааж үздэг:

1. draw, or terminal-based, games
2. instant win, or “scratcher”, games
3. sports lottery games

Draw, or terminal-based, games:

Зураглал 3. Mega millions сугалааны загвар



Тоо таах буюу терминал дээр суурилсан тоглоомууд нь хонжворт сугалааны хамгийн эртний бөгөөд хамгийн түгээмэл хэлбэр юм. Энэ төрлийн зарим сугалаануудыг дурдвал Mega Millions®, Powerball®, Il Gioco del Lotto®, elGordo®, Euro Jackpot®, Euro-Millions® зэрэг юм.

Тоглогч энэхүү сугалааг тоглохдоо тоо, үсэг, тэмдэг эсвэл тэдгээрийн хослолыг тааж, тохирол таарсан тохиолдолд шагнал авдаг. Ингэхдээ Сугалааны тоглоомын дүрмээс хамааран тоо, үсэг, тэмдгийг хэрэглэгч өөрөө зааж өгөх эсвэл санамсаргүй тоо үүсгэгчээр сонгож болно. Сугалаа зохион байгуулагч нь тогтоосон өдөр, цагт тохирлыг явуулдаг. Сугалааны тоглоомыг албан ёсны зөвшөөрөлтэй жижиглэн

худалдаа эрхлэгчид худалдаалдаг бөгөөд сугалааны тоглоомыг худалдах, сугалааны тасалбар хэвлэх, худалдсан сугалааны тасалбарыг баталгаажуулах, бусад үйл ажиллагаа явуулах зорилгоор зохион байгуулагчийн суурилуулсан цахим терминалаар дамжуулан гүйцэтгэдэг.

Technavio-ийн салбарын урьдчилсан судалгаагаар энэхүү сугалааны борлуулалт 2020 онд дэлхийн нийт сугалааны зах зээлийн 54.5%-ийг эзэлж, 2020-2025 оны хооронд CAGR ойролцоогоор 9.0%-иар өсөх төлөвтэй байна. Ингэснээр 2020 онд дэлхийн хууль ёсны нийт сугалааны борлуулалт ойролцоогоор 194 тэрбум доллар байсан бол, 54%-иар өсөж 2025 онд 300 тэрбум долларт хүрнэ гэж таамагласан болно.

Instant Win Games:

Шууд ялагч тодруулдаг төрлийн сугалаанууд нь тоглоход хурдан бөгөөд хялбар байдаг. Энэ сугалаа нь карт дээр тоо, үсэг, тэмдэг эсвэл тэдгээрийн хослолыг нуусан байх бөгөөд тоглогч нуусан мэдээллийг хусаж хожсон эсэхээ тодорхойлно. Тоглоомууд нь ихэвчлэн спортын арга хэмжээ, тусгай самбарын тоглоом эсвэл тусгайлсан үйл ажиллагаатай холбоотой байдаг бөгөөд энэ төрлийн хамгийн түгээмэл сугалаа нь Crossword Connect®, Deuces Wild®, Monopoly Millionaire's Club® зэрэг юм. Мөн энэхүү сугалааг тусгай зөвшөөрөлтэй жижиглэн худалдааны цэгүүдээр зардаг бөгөөд iLottery-г зөвшөөрсөн улс орнуудад онлайнгаар тоглох боломжтой.

Энэ төрлийн тоглоомын зах зээл дэх сугалааны жижиглэнгийн үнэ харьцангуй хямд, 2020 онд дэлхийн сугалааны нийт зах зээлийн 26.6 хувийг шууд ялагч тодруулдаг сугалааны





ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

борлуулалт бүрдүүлжээ. Technavio-ийн салбарын урьдчилсан мэдээгээр Шууд ялагч тодруулдаг сугалааны тоглоомын зах зээлийн борлуулалтын орлого 2020 онд 95 тэрбум доллар байсан бол 2025 онд 150 тэрбум доллар болж, ойролцоогоор 58 хувиар өсөх төлөвтэй байна.

Sports Lotteries:

Спортын хонжворт сугалаа нь тоглогчид спортын тэмцээний үр дүнг таамаглаж, хамгийн зөв таамагласан тоглогч шагналын эзэн болдог бооцоот тоглоомын нэг хэлбэр юм. Спортын сугалааны борлуулалт 2020 онд дэлхийн нийт сугалааны зах зээлийн 18.9%-ийг эзэлж байна; Technavio-ийн салбарын урьдчилсан судалгаагаар 2020 онд хууль ёсны спорт сугалааны борлуулалтын орлого 67 тэрбум доллар байсан бол 2025 онд ойролцоогоор 51%-иар д 101 тэрбум доллар болох төлөвтэй байна. Нэмж хэлэхэд, виртуал спорт буюу "и-спорт" сонирхогчдын тоо хурдтай нэмэгдэж байгаа нь спортын сугалааны тоглоомуудын өсөлтийг гол хүчин зүйл болно гэж үзэж байна. И-спортын тэмцээнүүд нь мэргэжлийн болон хагас мэргэжлийн, сонирхогчдын видео тоглоомын лиг зэрэг олон янзын тэмцээн байдаг.

Салбарын урьдчилсан мэдээгээр 2021 онд дэлхийн цахим спортын үзэгчдийн тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8.7%-иар өсч, 474 сая үзэгчдэд хүрэх төлөвтэй байгаа бөгөөд CAGR 7.7%-иар өсч 2024 онд хагас тэрбум буюу 577.2 саяд хүрэх төлөвтэй байна. COVID-19-ээс үүдэлтэй хөл хорионоос үүдэн энэ спортыг сонирхогчдын тоог нэмэгдсэн бөгөөд 2021 онд ч ийм байх болно гэж үзэж байна. Ялангуяа үзэгчдийн тоо Ойрх Дорнод, Африк, Ази-Номхон далайн бүс нутгууд болон Өмнөд Америкт өсөлт илүү нэмэгдэх төлөвтэй байна. COVID 19 цар тахлын улмаас биеийн тамирын спорт тасалдсан мөн тоглоом болон и-спортыг хооронд нь хүчтэй харилцан хамаарал байгаа нь эрэлтийг улам нэмэгдүүлж байна. Newzoo International B.V.-ийн салбарын урьдчилсан мэдээгээр дэлхийн цахим спортын зах зээл 2020 онд 947 сая ам.доллар байсан бөгөөд 2021 онд 14.5 хувиар өсөж, 1.1 тэрбум доллар хүрнэ гэж үзэж байна.

Газар зүйн байршлаар сугалааны ангилал:

Сугалааг газар зүйн байрлалаар нь мөн ангилах боломжтой бөгөөд Technavio-ийн мэдээлснээр 2020 онд Ази Номхон далайн бүс нутаг бүх сугалааны борлуулалтын 37.1%, Европ 31.9%, Ойрх Дорнод, Африкийн бүс нутаг 3.4%, Өмнөд Америк 2.3%, Хойд Америк 25 гаруй хувийг тус тус эзэлжээ. Энэхүү сугалааны борлуулалтад сугалааны систем, терминал, vending машинаар борлуулж буй хууль ёсны бүх төрлийн сугалаанууд багтсан болно.

Сугалааны шагнал: Сугалааны шагнал нь тогтмол дүнтэй мөнгө эсвэл бараа, эд зүйлс байж болдог. Ихэвчлэн сугалааны борлуулалтын орлогын тодорхой хувиар шагналын санг бүрдүүлдэг ба нийтлэг хэлбэр нь "50-50" буюу сугалааны тохирол орлогын 50% байдаг байна.²

Сугалааны цаашдын чиг хандлага: Улс орнуудын хувьд сугалааны орлого нь амралт зугаалгын хөтөлбөр, боловсролын хөтөлбөр, байгаль орчны хөтөлбөрүүд зэрэг олон нийтийн сайн сайхныг санхүүжүүлэх томоохон эх үүсвэр болж байна. Мөн сугалааг тусгай

² <https://www.verifiedmarketresearch.com/product/lottery-market/>



зөвшөөрөл бүхий жижиглэн худалдаачдаар худалддаг байсан бөгөөд энэхүү уламжлалт арга нь тоглогчид сугалааг худалдан авахад хязгаарлалт болж байсан. Тэгвэл COVID-19 цар тахлын нөлөөллөөр сүүлийн үед онлайнаар сугалааг тоглох боломжтой болсон. Тухайлбал, сүүлийн жилүүдэд АНУ iLottery-ийг хуульчилж өгсөн бөгөөд энэ нь сугалааг онлайнаар зохион байгуулах, удирдах, худалдан авах, тоглох боломжийг бий болгосон.

Eilers & Krejci Gaming-ийн мэдээлснээр, 2020 онд iLottery-ийн борлуулалт өмнөх оны мөн үетэй харьцуулахад 114%-иар өсөж 4.0 тэрбум доллар болсон нь АНУ-ын нийт сугалааны тоглоомын борлуулалтын ойролцоогоор 4%, iLottery-д оролцогчдын сугалааны бооцооны ойролцоогоор 11%-ийг бүрдүүлсэн байна.

Ийнхүү онлайн сугалааны системийг дэмжих тоглогчид болон түүнд оруулах хөрөнгө оруулалт нэмэгдэж байгаа нь дэлхийн сугалааны зах зээлийн өсөлтийг нэмэгдүүлэх төлөвтэй байна.³ Учир нь Онлайн орчинд буюу өөрсдийн хувийн орон зайд тоглогчид хонжворт сугалааг тоглох нь хялбар, тав тухтай байдлыг авчирч байна. Ухаалаг гар утасны хэрэглээ нэмэгдэх хэрээр гар утасны програм дээр суурилсан сугалааг тоглоомын зах зээлийг өргөжүүлж лоттерейн зах зээлийн гол хөдөлгөгч хүч болохоор үл барам дэлхий даяар хэрэглэгчдийн таашаалыг хүртсэн хамгийн түгээмэл бооцоот тоглоомын нэг болж байна.

Сугалааны зах зээлийн өсөлтөд голлон нөлөөлж буй хүчин зүйлс

- Сугалааны зах зээлийн өсөлтөд хонжворт сугалааг сурталчлах социал медиа маркетингийн хэрэглээ жил бүр нэмэгдэж байгаа нь голлон нөлөөлөхөөр байна.

Зураглал 4. Сугалааны зах зээлийн өсөлтөд нөлөөлөх хүчин зүйлс



Социал медиа маркетинг

Сугалааг социал медиагаар сурталчлах нь сугалааны зах зээлийг хурдтай нэмэгдүүлж байна.



Онлайн лотто

Онлайн лоттоны систем нь цаг хугацаа, орон зай харгалзахгүй хүмүүсийн тоглох боломжийг дэмжиж байна.



Ухаалаг утас хэрэглээ

Хүмүүс өөрсдийн хувийн орон зайд лотто тоглоход хялбар, тав тухтай байдаг нь зах зээлийн чухал хөдөлгөгч хүчин зүйл юм.



Блокчэйн сугалааны платформ

Сугалааны шинэ хэлбэрийг бий болгож байна.

- Интернет дэх онлайн лоттоны шинэлэг хэлбэр нь цаг хугацаа, орон зай харгалзахгүй хүмүүсийг тоглох боломжийг олгож байгаа тул Лотто тоглогчид, хөрөнгө оруулагчдыг нэмэгдүүлэх гол хүчин зүйл болж байна.

- Сугалаанаас олсон орлогыг сайн үйлс болон нийгмийн сайн сайхны төлөө ашиглах болсон нь тус зах зээлийг өсөхөд эергээр нөлөө үзүүлж байна.

- Өсөн нэмэгдэж байгаа ухаалаг утасны хэрэглээгээр дамжин дэлхийн сугалааны зах зээлд тоглогчдын тоог нэмэгдүүлж, эцсийн хэрэглэгчид өөрсдийн хувийн орон зайд мөрийтэй тоглоом тоглоход хялбар, тав тухтай

байдлыг бий болгож байгаа нь зах зээлийн энэ сегментийн онцлог юм.

³ <https://www.verifiedmarketresearch.com/product/lottery-market/>





ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА



Нөгөөтэйгүүр блокчейн нь хоёр талын ухаалаг гэрээгээр гүйлгээний ил тод байдлыг нэмэгдүүлж лоттерейн салбарт блокчейны ашиг тус дэлхийн зах зээлд асар их боломжийг бий болгоно хэмээн таамаглаж буй юм. Харин интернэтээр дамжуулж аливаа төрлийн гүйлгээ хийхэд банкны аюулгүй байдлын баталгаа болон уг зах зээлд үйл ажиллагаа эрхлэгчдэд төрийн зохицуулагч байгууллагаас тавих хатуу зохицуулалтууд нь лоттерейн зах зээлийн өсөлтийг хязгаарлах төлөвтэй байна.

АНУ-ын сугалааны зах зээл:

АНУ-д анхны орчин үеийн сонгодог сугалааг New Hampshire муж 1964 онд олон нийтэд танилцуулжээ. АНУ-ийн хонжворт сугалаа, казиногийн зах зээл нь 117 тэрбум доллароор хэмжигдэх бөгөөд энэ нь дэлхийн хонжворт сугалааны зах зээлийн 28 хувийг бүрдүүлж байна⁴. Хамгийн сүүлийн үеийн буюу 2022 оны судалгаагаар АНУ-ын нийт хүн амын 57% буюу 181 сая иргэн хамгийн багадаа жилд 1 удаа лоттоны тасалбар худалдаж азаа үздэг байна⁵. Мөн хонжворт сугалаа буюу лотто тоглогч 1 хүн дунджаар 261 долларыг зарцуулдаг аж. АНУ-ын лоттоны зах зээл 2019 онд нийт 29 тэрбум ам долларын орлогыг бүртгэсэн байна. Харин 1982 онд тус орлого ердөө 1.7 тэрбум ам доллар байжээ.

2020 оны эхээр ихэнх COVID-19 дэгдэлт энэ салбарт ихээхэн нөлөөлж хонжворт сугалааны зах зээл 1% -иар буурсан бол 2021 онд хөл хорио, тасалбарын цэгүүдийн сэргэлт ирж зах зээл 17%-иар буюу 13.6 тэрбум ам доллароор өссөн байна.

Зургаан төрлийн лотто байдаг муж бүр өөрсдийн гэсэн лоттоны дүрэм журмуудыг гаргаж даган мөрддөг байна. 2020 онд Лоттоны тасалбар хамгийн их борлуулсан мужаар New York шалгарсан ба нийтдээ 9.7 тэрбум ам долларын лоттоны тасалбар борлуулсан бол Florida, Texas мужууд 7.5, 6.7 тэрбум ам долларын лоттоны тасалбар борлуулж удаалсан байна. Мөн тус улсад жил бүр 2 тэрбум ам долларын лоттоны азтанууд шагналаа авахгүй үлддэг байна. Уг 2 тэрбум доллар нь ихэвчлэн маш олон бага хэмжээгээр сугалаан авсан хүмүүс шагналаа ирж авдаггүй эсвэл авах ёстой хугацаагаа өнгөрүүлсэн мөн сугалааны тасалбараа алдсан гэх мэт шалтгаанаар эзэд нь шагналаа авдаггүй байна. АНУ-ын сугалааны зах зээлд томоохон байр суурь эзэлдэг компаниудад Mega Millions, Powerball, New York Lottery зэрэг багтдаг.

АНУ-ын сугалааны зах зээлийн гол тоглогчдыг доорх хүснэгтээр харуулж байна:

Хүснэгт 15. АНУ-ийн томоохон хонжворт сугалаанууд

Сугалааны нэр	Улс	Тасалбарын үнэ	Тоо	Таах тоо	Шагнал	7 хоногт явуулах тохирлын тоо	Магадлал	Хүн амын тоо
MegaMillions	АНУ	2 доллар	70+25	5+Mega Ball	2 доллар-нийт борлуулагтын 40%	2 удаа	1:302,575,350	334,537,941
Powerballs	АНУ	3 доллар	69+26	5+Powerball	4 доллар-40 сая	3 удаа	1:292,201,338	318,009,994 (46 муж)

⁴ <https://www.globaldata.com/data-insights/travel-and-tourism/market-size-of-the-lotteries-in-the-us/>

⁵ <https://www.lottoland.co.uk/magazine/lottery-demographics.html>





ҮНЭТ ЦААСНЫ ТАНИШУУЛГА

доллар(до
од)

MegaMillions-АНУ: АНУ-ын Mega Millions бол дэлхийн хамгийн том лоттерейн нэг бөгөөд асар их мөнгөн шагнал буюу Жэкоп шагналын сантай. Уг хонжворт лоттерейг тоглохын тулд тоглогч 1-ээс 70 хүртэлх үндсэн 5 тоо, мөн 1-ээс 25 хүртэлх тооноос нэг Mega Ball дугаар сонгох ёстой. Тус лоттерей нь дэлхийн 2 дээд амжилт тогтоосноос 2012 онд гурван азтанд 655 сая ам.долларын мөнгөн шагнал гардуулсан. Улмаар 2018 онд Mega Millions-ын мөнгөн шагнал 1.537 тэрбум ам.доллар болтлоо өссөн үед АНУ-ын Өмнөд Каролина мужаас ялагч тодорч, мөнгөн шагналыг хүртсэн түүхтэй.

Powerballs-АНУ: Powerball нь АНУ-ын зургаан мужаас (Nevada, Utah, Mississippi, Alabama, Alaska, Hawaii) бусад бүх мужид явагддаг ба 69 цагаан болон 26 улаан өнгийн бөмбөгнүүд ашиглан ялагчийг 2 бөмбөг холигч машины (two drum lottery) тусламжтайгаар тодруулдаг. Уг сугалаа нь цорын ганц Жэкоп-ыг амладаг. Powerball лоттерейн хонжвор 40 сая ам.доллароос эхэлдэг. 2016 онд Powerball Жэкоп нь 1.5 тэрбум ам.долларт хүрч дэлхийн хамгийн том лоттерейн Жэкоп болж бүртгэгдсэн байдаг. Powerball-ын үндсэн тасалбарууд нь 2 ам.долларын үнэтэй байдаг⁶.

Тайланд улсын сугалааны зах зээл: Мөнгөн хонжворт сугалааг анх 1868-1910 оны хооронд эзэн хааны санаачилгаар анх олон нийтэд гаргасан бөгөөд хонжворт сугалаанаас олсон орлого нь улсын орлого болж, төсвийн орлогод нэмэлт эх үүсвэр болсон. **Нийт хүн ам нь 67 сая хүн амын 19 хувь буюу бүх насны 12 сая хүн тогтмол засгийн газрын зөвшөөрөлтэй гаргаж буй хонжворт сугалаанд оролцож, 76.0 тэрбум бахт буюу 2.0 тэрбум ам долларыг зарцуулдаг байна.**

Тус орны хувьд бусад улсуудтай харьцуулахад Засгийн газрын хонжворт сугалаа гаргах тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд тавих хяналт шалгалт өндөр бөгөөд хууль бусаар эрхэлсэн нөхцөлд хуулиар хатуу хариуцлага хүлээдэг байна. Хонжворт сугалаанаас олсон ашгийн 28 хүртэлх хувийг улсаас татварт төлдөг. Хонжворт сугалааг зохион байгуулагчид нь цэвэр ашгаас нийгмийн хариуцлагын хүрээнд Тайланд улсын олон улсын улаан загалмай байгууллагад хандивлаж, нийгмийн хариуцлагыг хүлээдэг.

Хонжворт сугалаа зохион байгуулж цуглуулсан мөнгөний 60 хувь нь шагналд, 28 хувь нь татвар, 12 хувь сугалаа зохион байгуулах зардалд, 9 хувь нь борлуулалтын зардал, 3 хувь захиргааны зардалд тус тус зарцуулагддаг байна. Тайланд улсын хонжворт сугалааг Засгийн газрын гаргасан сугалаа, Charity lottery сугалаа гэсэн хоёр төрөлтэй.

Өмнөд Солонгосын сугалааны зах зээл: Өмнөд Солонгост 1947 онд Олимпын хорооны санаачилгаар анхлан хонжворт сугалааг гаргасан. Өмнөд Солонгос улсад Төрийн Хонжворт сугалааны хорооноос хонжворт сугалааны салбарт төрийн зохицуулалт, хяналтыг хэрэгжүүлдэг бөгөөд Төрийн болон бусад байгууллагаас сугалаа гаргаж, татан төвлөрүүлсэн хөрөнгөөр тодорхой нэг төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж, нийгмийн сайн сайханд чиглэгдэж, олон нийтэд танигдсан урлаг соёлын одод сугалааг байнга сурталчилж, зарцуулалт, тайлагналыг олон нийтэд байнга мэдээлдэг тул бүх насны иргэд оролцож,

⁶ How Powerball Works: What You Need to Know to Win (liveabout.com)





ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА



сугалаагаар дамжуулан нийгмийн сайн байдалд хувь нэмрээ оруулдаг гэсэн итгэлийг бий болгож чадсан байна.

Төрийн зарим байгууллагуудын санаачилгаар хонжворт сугалааг дэмжих зорилгоор тодорхой сугалааг санаачлан гаргадаг бөгөөд Солонгос улсын хонжворт сугалааны хорооноос бодлого, хуулийг боловсруулж, эрх байгууллагаар батлуулдаг. Өнөөгийн байдлаар Хонжворт сугалаа болон хонжворт сугалааны санхүүжилтийн акт гэсэн нарийвчилсан хуулиар зохицуулдаг.

Өмнөд Солонгос улсын хонжворт сугалааны зах зээл Дотоодын нийт бүтээгдэхүүний 0.45 хувийг эзэлдэг бөгөөд хонжворт сугалааны 92 хувийг цахим хонжворт сугалаа дангаараа бүрдүүлдэг. 40-49 насны иргэд сугалаанд хамгийн идэвхтэй оролцдог бөгөөд тус насны бүлгийн хүмүүсийн 74 хувь хонжворт сугалаанд идэвхтэй оролцдог байна. Өмнөд Солонгос улсын хонжворт сугалааг цахим хонжворт сугалаа, *Stratch off*, тэтгэврийн хонжворт сугалаа, интернэт хонжворт сугалаа гэсэн 5 төрөлтэй байдаг.

Португал улсын хонжворт сугалааны зах зээл: Португал улс дахь 18-70 насны бүх бүртгэлтэй тоглогчдын 34.3% болох 218,987 идэвхтэй тоглогчдыг хамруулсан судалгаагаар лоттерей тоглоомын тархалтын түвшин 51.3% байсан бөгөөд Португалид мөрийтэй тоглоомын тархалт Европын бусад орнуудтай харьцуулахад харьцангуй өндөр байна. Сүүлийн жилүүдэд тус улсын нийт хүн амын жендерийн харьцаанд эрэгтэйчүүдийн тоо 1%-аар нэмэгдсэн нь тухайн улсын нэг хүнд ногдох сугалааны борлуулалтыг 13.4%-аар нэмэгдүүлсэн байна. Нөгөөтэйгүүр Португал улсын сугалааны борлуулалтад дүн шинжилгээ хийж үзэхэд тухайн улсын аль нэг дүүргийн оршин суугчдын орлогын нэг еврогийн өсөлт бүрт, дүүргийн лоттерейн нийт борлуулалт 4.4%-аар өссөн болохыг тогтоожээ.

Португал улсад хийсэн судалгаанаас үзэхэд насанд хүрсэн эрэгтэй онлайн тоглогчид нийт тоглогчдын 78.7% буюу 121,601 байсан бол насанд хүрсэн эмэгтэй онлайн тоглогч ердөө 21.3% буюу 32,984 байв. Харин Португалын нийт насанд хүрэгчид хүн амын 46.7% буюу 3.99 сая иргэн эрэгтэй байдаг бол 53.3% буюу 4.56 сая эмэгтэй иргэн байдаг. Онлайн лоттерей тоглогчдын дөрөвний гурав нь 49-өөс доош насныхан буюу 74.4%-ийг бүрдүүлж байсан тул онлайн лоттерей тоглогчдын насны бүлгийн төлөөлөл Португалийн хүн амын залуу үе байх хандлагатай байна.

Боловсролын хувьд ч мэдэгдэхүйц ялгаа илэрснээр онлайн лоттерей тоглогчдын боловсролын түвшин нийт хүн амынхаас хамаагүй өндөр байв. Тухайлбал ихэнх тоглогчид дээд боловсролтой буюу 51.7% байсан ба боловсролгүй иргэдийн дунд лоттерей тоглогч маш бага байсан байна.

Монгол Улс дахь хонжворт сугалааны нөхцөл байдал:

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.5.8 дахь заалтад төлбөрт таавар, бооцоот тоглоомын үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэхээр тусгасан бөгөөд хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт заасны дагуу хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас уг зөвшөөрлийг олгохоор, мөн хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэгт “тухайн төрлийн аж ахуйн үйл ажиллагаанд





хамаарах тусгай зөвшөөрөлтэй холбоотой нарийвчилсан журмыг тус тусын хуулиар зохицуулна.” гэж заасан байдаг.

Гэвч Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 7.3-т “Тухайн төрлийн аж ахуйн үйл ажиллагаанд хамаарах тусгай зөвшөөрөлтэй холбоотой нарийвчилсан журмыг тус тусын хуулиар зохицуулна” гэж заасан боловч бооцоот таавар, хонжворт сугалааны үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой харилцааг зохицуулсан хууль байхгүй байна.

Улмаар УИХ-аас 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдөр баталсан Зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар тусгай зөвшөөрлийн жагсаалтын 6.5-д “Эд мөнгөний хонжворт сугалаа гаргах” тусгай зөвшөөрлийг Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгоно гэж заасан. Сангийн яамнаас эд мөнгөний хонжворт сугалаа гаргах тусгай зөвшөөрөлтэй 10 гаруй аж ахуй нэгж байна.

2021 оны жилийн эцсээр Монгол улсын хонжворт сугалааны зах зээл 10.3 тэрбум төгрөгөөр хэмжигдэж байгаа бөгөөд энэ нь өмнөх оны мөн үеэс 8.5 дахин өссөн үзүүлэлт юм.

Хүснэгт 16. Эд мөнгөний хонжворт сугалааны тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгж

№	Тусгай авсан аж ахуйн нэгж	Тусгай зөвшөөрлийн хугацаа	Тусгай зөвшөөрлийн нэр
1	“Эм эн си эн” ХХК	2021-11-22	Аз ив ивээг сугалаа
2	“Саятан лото” ХХК	2022-07-23	Саятан эд мөнгөний хонжворт сугалаа
3	“Пленти фанд” ХХК	2022-11-08	Пленти сугалаа
4	“ЭЙ БИ ДИ ЭС” ХХК	2022-12-07	4 бэрх, Lucky Lotto 6
5	“Гранд системс” ХХК	2023-05-26	Эерэг хандлага
6	“Чинчухажир” ХХК	2023-05-26	Мазаалай
7	“Бизинвин” ХХК	2022-02-21	Үндэсний Лоттерей
8	“Монгол сугалаа” ХХК	2023-09-19	Монгол сугалаа
9	“Арт Кредит” ХХК	2023-11-25	Тэрбумтан хонжворт сугалаа
10	“Гранд спорт лото” ХХК	2023-11-25	Үндэсний бөхийн хонжворт сугалаа
11	“Эгнэшгүй Их” ХХК	2023-11-25	Үндэсний хонжворт сугалаа

Эх сурвалж: Сангийн яам

2022 оны хагас жилийн байдлаар Монгол улсын хэмжээнд 11 эд мөнгөний хонжворт сугалааны тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгж байгаагаас идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй 5 аж ахуйн нэгж байна.

Хүснэгт 17. Монгол улсын томоохон хонжворт сугалаа

	Аж ахуйн нэгж	Байршил	Сугалааны үнэ	Таах тоо	Тохирол явагдах өдөр сар бүрийн 29	Хонжвор мөнгө
1	“Саятан лото” ХХК	Улаанбаатар	Саятан эд мөнгөний хонжворт сугалаа	400-833	0.888888889	
2	“Гранд системс” ХХК*	Улаанбаатар				





ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

3	“Монгол сугалаа” ХХК	Улаанбаатар	Монгол сугалаа	20,000	8/60	өдөр бүр	мөнгө
4	“Эгнэшгүй Их” ХХК**	Архангай	Үндэсний хонжворт сугалаа				
5	Түвшиг говь хангай ХХК	Өвөрхангай	Топ сугалаа	20,000-50,000	6/36	7 хоног 3 удаа	эд, мөнгө

*Grand системс ХХК нь өнгөрсөн хугацаанд шууд олон нийтэд хандалгүй үндэсний томоохон үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллаж, тэдгээр аж ахуйн нэгжүүдийн бүтээгдэхүүн, үйлчилгээний борлуулалтыг нэмэгдүүлж дэмжих зорилгоор сугалаат хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

** “Эгнэшгүй Их” ХХК-ийн сугалааны мэдээлэл олдоогүй болно.

Сугалааны зах зээлд оролцогч тусгай зөвшөөрөл эзэмшдэг байгууллагуудыг хөрөнгийн байдлаар харьцуулбал 2 компаниас бусдынх нь хоорондоо ойролцоо, борлуулалтын орлогоор нь харьцуулбал 3 компани нийт зах зээлийнхээ ~80%-ийг эзэлдэг, цэвэр ашгаар нь харьцуулбал 2 компани салбарын ихэнх ашгийг бүрдүүлдэг, бусад нь цэвэр ашиг багатай, эсвэл алдагдалтай ажилладаг, эсвэл үйл ажиллагаа явуулдаггүй гэж дүгнэж болохоор байна.

Эд мөнгөний хонжворт сугалааны томоохон аж ахуй нэгжүүдийг дурдвал “Түшиг говь хангай” ХХК-ийн зохион байгуулж буй “Топ” сугалаа 7 хоног бүрт 3 өдөр азтан шалгаруулдаг, сугалааны тасалбарын үнэ 20,000 төгрөг, мөн Toyota Land 300 автомашинтай сугалаат хөтөлбөр нь 50,000 төгрөгийн тасалбарын үнэтэй, тухайн автомашины үнийн дүн болон тодорхой хэмжээний ашгийн түвшингээ харгалзан 2,900 ширхэг тасалбар борлогдсон нөхцөлд тохирол явагдахаар төлөвлөж байна. Гар утасаараа бүртгүүлж, сугалааг зохион байгуулагчийн зүгээс үүсгэсэн 8 оронтой тооноос оролцогч өөрсдөө сугалааны дугаараа сонгодог.

“Монгол сугалаа” ХХК нь 1, 2, 3, 4 дүгээр ээлжийн тохиролтой сугалаат хөтөлбөр зохион байгуулж байгаа бөгөөд шагналын сан мөн адил биет хөрөнгө бөгөөд 8-аас 4 орон таах хүртэл шагналтай, сугалааны тасалбарын үнэ 20,000 төгрөг, 3 сугалаа авсан нөхцөлд 1 сугалааны эрх бэлэглэх зэрэг тасалбарын тооноос хамаарсан тасалбарын урамшуулалттай байна. Сугалаанд оролцоходоо гар утасны дугаараар бүртгүүлж, тусгай дугаараас гар утсанд сугалааны дугаар автоматаар ирдэг зохицуулалттай байна.

Лотто сугалаа: 2022 оны эцсээс сонгодог төрлийн лоттог Монгол улсад зохион байгуулж эхэлсэн бөгөөд томоохон компаниудын мэдээллүүдийг дурдвал,



Манай улсад эд мөнгөний хонжворт лотто сугалаат хөтөлбөрийг анх удаа “Плент Фанд” ХХК нь “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК-тай хамтран 2022 оны 11 дүгээр сарын 13-нас эхлэн 6/42 лотто хөтөлбөрийг хэрэгжүүлээд байна. Уг лотто төрлийн сугалаа нь 1-ээс 42 хүртэлх дурын 6 тоог сонгож, дараалал харгалзахгүй таарсан тоогоор шагнал хүртэх боломжтой юм. Уг лотто сугалааны супер шагналын сан буюу Jackpot нь 300.0 сая төгрөгөөс эхэлж байна.

Тоглогчид Гар утасны аппликэйшн дээр суурилсан “Ард аппликэйшн”-ыг ашиглаж энэхүү сугалаанд оролцдог бөгөөд нэгж сугалааны үнэ 2,000 төгрөг байна. Өнгөрсөн хугацаанд “Эгнэшгүй Их” ХХК-ийн зүгээс Үндэсний лоттерей явуулах тусгай зөвшөөрөл авч байсан





ҮНЭТ ЦААСНЫ ТАВИЛЦУУЛГА



бөгөөд 2020 оны 1 дүгээр сарын 21-ний өдрийг хүртэл нийт 10 орчим жил тус үндэсний лоттерей сугалааг явуулж байгаа бөгөөд сугалааны тасалбар анх 990 төгрөгийн үнэтэй, 2020 онд 4950 төгрөгийн үнэтэй байсан. Үндэсний лоттерей сугалаа нь 6/42 үндэсний лоттерей нэртэйгээр 42 тооноос дараалал харгалзахгүй мөн адил 6 оронг таарсан нөхцөлд Jackpot шагналын эзэн тодорч 120.0 сая төгрөг болон 50.0 сая төгрөгийн шагналын эзэн болох тохиролтой байсан. Тус үндэсний лоттерей лото сугалаа нь тасалбар борлуулалтын байртай байсан бөгөөд технологийн хөгжилтэй уялдуулан фэйсбүүк, тусгай дугаарын сувгаар борлуулалтыг хийж, тохирлыг шалгаруулдаг байсан байна.

Эдгээр хуулийн дагуу эд мөнгөний хонжворт сугалаа явуулж буй байгууллагуудаас гадна цахим орчинд казиногийн тоглоом, спортын болон бусад төрлийн бооцоот тоглоом эрхэлдэг гадаадын хуулийн этгээдийн үйл ажиллагаа Монгол Улсын хүн амын дунд түгээмэл болсон бөгөөд оролцогчид гар утас болон бусад хэрэгслээр тоглолт зохион байгуулагчийн програмд хандаж, оролцох сонирхол нэмэгдэж байна.

Сүүлийн хоёр жилийн хугацаанд дэлхий нийтэд үргэлжилсэн коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үеийн хөл хорио, хязгаарлалтын дэглэмийн улмаас интернетийн хэрэглээ хурдацтай нэмэгдэж, цахим орчинд хууль бус мөрийтэй тоглоом зохион байгуулах гэмт хэрэг ихсэх хандлагатай байгаа бөгөөд сүүлийн үед иргэд, байгууллагаас төлбөрт таавар, бооцоот тоглоомын үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл хүсэх, төлбөрт таавар, бооцоот тоглоомын төрөлд ямар тоглоомууд хамаарахыг тодруулах хүсэлт олноор ирэх болсон.


Цагдаагийн байгууллагын хэмжээнд 2002 оны эрүүгийн хуулийн 243, 2015 оны Эрүүгийн хуулийн 20.17, Зөрчлийн тухай хуулийн 5.7 зүйлд заасны дагуу 2015-2020 он, 2021 оны эхний 10 сард цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн судалгааг харахад гэмт хэргийн шинжтэй хэргүүд 2020 онд 38 байсан бол 2021 оны эхний 10 сард гэхэд 305 болж өссөн байна. Харин учирсан хохирлын хувьд 2020 онд 56,735,000 төгрөг байсан бол 2021 оны байдлаар 258,507,000 төгрөг болж өссөн үзүүлэлт гарчээ. Түүнчлэн Зөрчлийн тухай хуулийн 5.7-д 1 заасан зөрчлийн төрөлд хамаарах зөрчлийн хэргийн тоо 2018 онд 140, 2019 онд 175, 2020 онд 275 болж өсжээ.

Боломжит хэрэглэгчийн судалгаа: Монгол улсын хүн амын тоо, өсөлтөөс харахад 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар хүн амын тоо 3,409,939 өсөлтийн хувь 2.6 хувь байна. 2021 оны байдлаар нийт насанд хүрсэн хүн амын тоо нийт хүн амын 63.9% буюу 2.2 сая байна. Эд мөнгөний хонжворт сугалаанд 18 насанд хүрсэн иргэд оролцох хуулийн зохицуулалттай байдаг бөгөөд нь сугалаа тоглох боломжтой хүн амын тоо 2.2 сая байна.

График 20. Монгол улсын хүн ам, түүний бүтэц



ХҮН АМЫН ӨСӨЛТ



■ Хүн амын тоо /мян.хүн/ ■ Өсөлт


НАС ХҮЙСНИЙ БҮТЭЦ



Үүрэн холбооны салбарын эрдэмтэн судлаачид үүрэн хөдөлгөөнт холбооны гурав, дөрөвдүгээр үеийн 3G, 4G технологийн стандартыг баталж, 5G технологийн хөгжлийг хэрэглээнд нэвтэрч, ирээдүйд 6G, 7G технологийн таамаглалуудыг дэвшүүлсэн бөгөөд 2017 оны байдлаар үүрэн холбоо хэрэглэгчид 3,886,167, дата хэрэглэгч 2,625,685, ухаалаг утас хэрэглэгч 2,439,236 байгаа бөгөөд цаашид энэ тоо нэмэгдэх хандлагатай байна. Сүүлийн жилүүдэд олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан супер азтан тодруулах сугалаа тодорхой компаниуд зохион байгуулж, иргэд гар утсаар дамжуулан оролцох сонирхол эрс нэмэгдэж байна. Иймд **Технологи хэрэглээгээр тодорхойлсон хэрэглэгчдийн тоо 2.4 сая** байна.

Монгол улсад 2022 оны 2 дугаар улиралд өрхийн сарын дундаж орлого өмнөх оны мөн үеэс 15.9 хувиар өсөв. Өрхийн орлого ийнхүү өсөхөд цалин хөлсний орлого энэ оны 2 дугаар улиралд өмнөх оны мөн үеэс 27.5 хувиар, хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, үйлчилгээнээс олох орлого 22.7 хувиар тус тус нэмэгдсэн нь голлон нөлөөллөө. Өрхийн орлого сүүлийн жилүүдэд тогтмол өссөн нь сугалааны зах зээлийн өсөлтөд нөлөөлөх боломжтой юм.

График 21. Өрхийн орлого, зарлага



Эх сурвалж: ҮСХ





ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

Хөгжиж буй болон хөгжингүй орнуудын туршлага, олон улсын хонжворт сугалааны зарим байгууллага холбоодоос хийгдсэн судалгаа, хөгжлийн хандлагаас үзэхэд хонжворт сугалааны салбар нь биет буюу цаасан хэлбэрийн хонжвороос илүүтэйгээр цахим хэлбэр лүү шилжиж, сугалаа зохион байгуулагчид дэлхийн өнцөг булан бүрт байгаа хэрэглэгчид оролцох боломжийг бүрдүүлэх шаардлага тулгарч байна. 2019-2022 оны хооронд дэлхий нийтийг хамарсан ковид-19 цар тахлаас шалтгаалан иргэд гар утсаар дамжуулан хөрөнгийн зах зээл, виртуал хөрөнгийн зах зээлд оролцож, хөрөнгө оруулах сонирхол эрс нэмэгдсэн.

Манай улсын хувьд эд хөрөнгийн хонжворт сугалаа зохион байгуулагчид нь хэт уламжлалт шинжтэй маркетингийн аргийг ашиглан сугалааг зохион байгуулж байгаа нь тус салбар эрчимтэй хөгжиж, хүмүүсийн сонирхлыг татсан салбар болж чадаагүй өнөөг хүрлээ. Мөн хонжворт сугалаа, бооцоот сугалааны салбарын нарийвчилсан хууль тогтоомж байхгүйгээс иргэд өмнө дурдсан санхүүгийн луйварт өртөх эрсдэлийг бий болгож байна. Тиймээс бид эд хөрөнгийн хонжворт сугалааны салбарын зах зээлийн багтаамжийг хэдийгээр хийгдсэн судалгаа дутмаг, энэ чиглэлийн мэдээлэл хангалтгүй байгаа хэдий ч нийт хүн ам зүйн бүтэц, үүрэн холбооны салбарын хөгжил, хэрэглээ, виртуал хөрөнгийн зах зээлийн чиг хандлагад тулгуулан дараах байдлаар зах зээлийн хэмжээг таамаглалаа.

- Хүн ам зүйн хувьд 19-29, 30-39 насны хүмүүсийн нийт хүн амын дунд эзлэх хувь хэмжээ өндөр, ухаалаг гар утасны хэрэглээ 2.4 сая иргэн хэрэглэж байгаа зэргээс шалтгаалан тэдгээрийн эрэлт хэрэгцээ, сонирхолд нийцсэн гар утсаар бодит цагийн горимоор оролцох боломжийг бүрдүүлж, шагналын сан, тохирол ил тод нээлттэй явагдсан нөхцөлд 100.0-300.0 мянган иргэн тогтмол 10.0-100.0 мянган төгрөгийн хооронд тогтмол оролцох боломжтой гэж үзэж байна.
- Мөн сүүлийн жилүүдэд ковид-19 цар тахлаас шалтгаалан иргэд хөл хорионы нөхцөлд гадаад, дотоодын хөрөнгийн биржийн арилжаанд идэвхтэй оролцох, виртуал хөрөнгийн зах зээлийг сонирхон оролцож байгаа идэвх зэргээс тооцож үзэхэд 20-35 насны нийт 400.0 мянга гаруй хэрэглэгчид өөрийн орлогын түвшинд тохируулан оролцох боломжтой гэж үзэж байна.
- Эд хөрөнгийн хонжворт сугалааны тохирол оролцох мөнгөн дүнгээс үзэхэд мөрийтэй тоглоомоос бусад хонжворт сугалаанд оролцох хамгийн өндөр дүн 100.0-200.0 мянга хүртэл оролцох боломжтой харагдаж байгаа бөгөөд дунджаар хөрөнгийн болон виртуал хөрөнгийн зах зээлд оролцогчдын дунджийг жилд 400.0 мянга гэж тооцвол ойрын 2-3 жилийн хугацаанд хонжворт сугалааны салбар блокчайн, үүлэн технологийг амжилттай нэвтрүүлж, тохирлыг нээлттэй, ил тод зарласан нөхцөлд 50.0-60.0 тэрбумын үнэлгээтэй зах зээлийн багтаамжтай байх боломжтой гэж үзэж байна.
- Түүнчлэн хонжворт сугалаа зохион байгуулагчдын тоо хязгаартай, дийлэнх оролцогчид гадаад зах зээлд явагдаж буй хонжворт сугалаанд оролцож байгаа нөхцөлд спорт лотто салбарыг олон улсын болон дэлхийн томоохон спортын тэмцээн уралдаантай уялдуулан зохион байгуулсан нөхцөлд 200.0-350.0 мянган иргэд оролцож, дунджаар бооцооны хэмжээнээс шалтгаалан 500.0 мянгаас 1.0 сая төгрөгийн хооронд бооцоо тавьж тоглох боломжтой бөгөөд ингэсэн нөхцөлд зах зээлийн багтаамж 150.0 тэрбум төгрөгт хүрэх боломжтой гэж үзэж байна.





ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

Иймд, үнэт цаас гаргагч нь энэхүү бизнес төлөвлөгөөний хүрээнд урт хугацаанд, үндэсний хэмжээнд тогтвортой үйл ажиллагаа явуулах сонгодог лотто (эд мөнгөний хонжворт сугалаа)-г зах зээлд нэвтрүүлэх, татвар, санхүүгийн хяналтаас гадуурх хонжворт сугалааны бизнесийг нээлттэй, ил тод болгож тус салбарт эргэлдэж байгаа татварын хяналтаас гадуурх хөрөнгийг хууль ёсны бизнест төвлөрүүлэх замаар салбарын хөгжилд хувь нэмэр оруулах нь зүйтэй гэж үзсэн.

Цаашлаад олон улсын жишгээр эд мөнгөний хонжворт сугалааны үйл ажиллагаанаас олсон орлогыг татварын болон бусад орлогыг нийгмийн хариуцлагын бодлогод чиглэсэн хандив, тусламжид зарцуулах нь элбэг бөгөөд төсөл хэрэгжүүлэгчийн хувьд цаашид тогтвортой үйл ажиллагаанаас олсон орлогын тодорхой хувийг нийгмийн хариуцлагын төслүүдэд зарцуулах зорилтыг тавин ажиллаж байна.

Дотоодын зах зээлд хонжворт сугалааны бизнесийг хуулийн дагуу, ил тод, нээлттэй, сонгодог хэлбэрээр явуулдаг аж ахуй нэгжүүд хэдийгээр байгаа ч уг зах зээл салбарын хөгжил хангалттай бус байгаагаас энэ төрлийн үйл ажиллагааг хууль зөрчиж, хяналтгүйгээр явуулах тохиолдол нэлээдгүй гарсаар байна.

2.2. Салбарын хууль эрх зүйн орчин, зохицуулалт хяналт: УИХ-аас 2001 онд батлагдсан Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.4.4 дэх заалтад “Санхүү, эдийн засгийн чиглэлээр эд мөнгөний хонжворт сугалаа гаргах” тусгай зөвшөөрлийг Сангийн яамнаас авахаар хуульчлагдсан боловч Зөвшөөрлийн тухай хууль 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдөр хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсон.

Зөвшөөрлийн тухай хуулийн тусгай зөвшөөрлийн 6 дугаар хавсралтын 6.5-д “эд мөнгөний хонжворт сугалаа гаргах тусгай зөвшөөрлийг Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгохоор хуульчлагдан. Эд мөнгөний хонжворт сугалаа гаргах тусгай зөвшөөрлийг зөвхөн аж ахуйн нэгж байгууллагад олгох, байнгын шалгуурт дараах шаардлага тавигддаг. Эрсдэлийн сан байгуулсан байх, нийгмийн даатгал төлдөг байх, Ебаримт хэвлэдэг байх.

Эд мөнгөний хонжворт сугалаа гаргах тусгай зөвшөөрөл шинээр авахад бүрдүүлэх бичиг баримтыг авч үзвэл:

- ✓ Хүсэлт гаргагчийн аудитаар баталгаажуулсан сүүлийн улирлын тайлан баланс;
- ✓ Сугалааны нөхцөл буюу үйл ажиллагаа эрхлэх төсөл 3 жилээр гаргах, сугалаанаас олсон орлогыг хуваарилах норматив;
- ✓ Сугалааны тасалбар, эсхүл сугалааны нөхцөлөөр тохирсон бусад баримт бичгийн загвар, түүнд тавигдах шаардлага, түүн дээр буулгасан бичиг, зураг, эсхүл тэмдэг, сугалааны тасалбарыг дуурайлган хуулбарлахаас сэргийлэх арга;
- ✓ Сугалааны хонжворыг олгох, төлөх үед билетийг шалгах, магадлах дүрэм;
- ✓ Сугалаа зохион явуулах техник, эдийн засгийн үндэслэл, сугалаа зохион явуулахтай холбогдон гарах зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, сугалааны орлогын урьдчилсан тооцоо;
- ✓ Сугалаа борлуулах зах зээлийн судалгаа;
- ✓ Сугалааны тоног төхөөрөмжийн техникийн үзүүлэлтүүд;





ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

- ✓ Тараагдсан болон тараагдаагүй сугалааны тасалбарыг бүртгэх журам;
- ✓ Тараагдаагүй тасалбарыг хураан авах, хадгалах устгах журам;
- ✓ Тодорсон ялагч нь шаардаж аваагүй хонжворыг хадгалах журам, хонжвор олгох хугацаа дууссаны дараа тэдгээрийг хүлээлгэн өгөх журам.

2.3. Үнэт цаас гаргагчийн дунд хугацааны бизнес төлөвлөгөөний талаар:

Үнэт цаас гаргагч болох “Гранд системс” ХХК нь шинэлэг эд мөнгөний хонжворт сугалгааг орчин үеийн технологи дээр тулгуурлан иргэдэд хүргэхээр зорьж ажиллаж байгаа бөгөөд ингэснээр тоглогчид дэлхийн хаанаас ч хүссэн цагтаа чөлөөт цагаа хөгжилтэй өнгөрөөх боломжтой юм. Энэхүү зорилгын хүрээнд дараагийн 5 жилийн хугацаанд хоорондоо харилцан холбоо бүхий доорх зорилт, стратегийг дэвшүүлэн ажиллаж байна:

- ❖ **Финтек сугалааны компани болох:** “Гранд системс” ХХК нь дэлхийн сугалааны чиг хандлага болоод байгаа финтек сугалааны компани болохоор зорьж байна. Финтек сугалааны компани гэдэг нь сугалааг технологи ашиглан тоглогчдод гар утас болон компьютероор хүргэдэг. Энэхүү зорилгын хүрээнд өргөжүүлэх боломжтой үүлэн технологид суурилсан үндсэн сугалааны системийг хөгжүүлсэн. Энэхүү систем нь вэб суурьтай тул тоглогчид компанийн цахим хуудаст хүссэн үедээ хаанаас ч нэвтрэн сугалаа авах, түүний төлбөр тооцоог хийх, сугалааны түүхээ хянах, хожсон шагналаа авах боломжтой болсон. Цаашид компани нь системийг хөгжүүлж гар утасны аппликэйшнээр тоглогчид тоглох боломжтой болгож хөгжүүлэхээр төлөвлөж байна. Компани нь үндсэн сугалааны системийн найдвартай байдлыг хангах, илүү боловсронгуй болгох тоглогчдод саадгүй, түргэн шуурхай сугалаагаар тоглох тал дээр анхаарлаа байнга хандуулж байна.
- ❖ **Үйл ажиллагааны бүтцийг сайжруулах:** Финтек бизнесийн бүтэц нь орчин үеийн дэвшилтэт технологийг үйл ажиллагаандаа ашиглан тоглогчид сугалаа тоглоход хялбар тоглох боломжийг олгох юм. Энэхүү үйл ажиллагаатай уялдан сугалааны тоо таах, төлбөр төлөх өгөгдлийг хурдан шуурхай, найдвартай дамжуулах, бүртгэл, төлбөр тооцоог түргэн гүйцэтгэх зэрэг “арын алба”-ны үйл ажиллагааг автоматжуулах шаардлага зайлшгүй тулгардаг. Иймд үнэт цаас гаргагч нь дээрх шаардлагад нийцүүлж сугалааны суурь бүртгэлийн системийг хамт хөгжүүлж үйл ажиллагаандаа нэвтрүүлээд байна. Энэхүү программ нь вэб технологи дээр суурилсан программ юм. Тус программыг үйл ажиллагаандаа нэвтрүүлснээр төлбөр тооцоо, гүйлгээ хийхэд шаардлагатай бүхий л өгөгдөл болон мэдээллийг дамжуулах, хянах, бүртгэх, тайлагнах үйл ажиллагааг автоматжуулах бөгөөд эрсдэл болон зардлыг бууруулах давуу талтай.
- ❖ **Үйл ажиллагаагаа зогсолтгүй, хурдтай өргөжүүлэх:** Финтек сугалааны компани болсноор тоглогчдын тоог хязгааргүй нэмэх боломжтой бөгөөд үйл ажиллагаагаа богино хугацаанд өсгөн томруулах стратеги баримтална. Иймээс вэб технологи дээр суурилсан системийг хөгжүүлж сугалааг төрөлжүүлэх, түүний өрсөлдөх чадавхыг нэмэгдүүлэх, хүмүүсийн амьдралд зохицсон аргаар илүү хялбар хүргэх зэргээр тоглогчдыг татан үйл ажиллагаагаа хурдтай өргөжүүлнэ. Финтек бизнесийн загвар





ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

нь үйл ажиллагааны зардлыг багасгадаг тул зах зээлд хурдан өргөжих боломжийг компанид олгох юм. Цаашлаад “Гранд системс” ХХК нь үндсэн сугалааны программ, аппликэйшнээс гадна шинэлэг, хөгжилтэй сугалаа, урамшуулалт хөтөлбөрүүдийг тасралтгүй нэвтрүүлэн тоглогчдодоо хүргэн ажиллана.

- ❖ **Хувьцаа эзэмшигчдэд үнэ цэнэ бий болгох:** “Гранд системс” ХХК нь өнгөрсөн хугацаанд үндэсний томоохон компаниудтай хамтран сугалааг зохион байгуулж, хүмүүст хүргэдэг байсан. Компани үйл ажиллагааны цар хүрээгээ өргөжүүлэн шууд тоглогчдод хандан сугалааг зохион байгуулснаар компанийн үйл ажиллагаа, цар хүрээг өргөжүүлэх замаар хувьцааны үнэ цэнийг нэмэгдүүлэх, сугалааг шинэлэг, өндөр шагналыг сантай хүргэх зэргээр хувьцаа эзэмшигчдэд үр ашиг өгөхийг зорьж байна. Тухайлбал, компани нь үүсгэн байгуулагдсан цагаасаа хойш 3 жилийн турш үйл ажиллагаа явуулахдаа тасралтгүй ашигтай ажилласан бөгөөд цаашид үйл ажиллагаагаа өргөжүүлснээр компанийн ашгийг нэмэгдүүлж, хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашиг жил бүр олгож ажиллахаар зорьж байна.
- ❖ **Гүйцэтгэлээ хэрхэн дүгнэх вэ** Үнэт цаас гаргагчийн дэвшүүлж буй стратеги нь хаана хүрэх, яаж хүрэх, хэрхэн өрсөлдөх зэргийг тодорхойлж, чиглүүлж өгч байгаа гол бодлого юм. Стратегийнхаа хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж, хувьцаа эзэмшигчид, ажилчид, үйлчлүүлэгчид зэрэг бүхий л оролцогч талуудад мэдээллээ тогтмол хүргэж ажиллана.

Эерэг хандлага сугалаа: “Гранд системс” ХХК нь үйл ажиллагааны цар хүрээгээ өргөжүүлснээр хүмүүст өндөр шагналын сантай сугалааг санал болгохоор зорьж байна. Үнэт цаас гаргагчийн бизнес төлөвлөгөөнд борлуулалтын орлого, шагналын сан зэргээс хамаарч сугалааны шагналыг хэмжээг доорх байдлаар төлөвлөсөн байна. Сугалааны шагналын сан нийт тасалбар борлуулалтын орлогын 50%-тай тэнцэх мөнгө байх бөгөөд үүнээс Гранд Шагналын сан нь нийт тасалбар борлуулалтын орлогын 44%-тай тэнцэх мөнгө байна. Үнэт цаас гаргагч нь ₮5,000 болон ₮2,500-ийн үнэтэй 2 төрлийн эд мөнгөний хонжворт сугалаа гаргах бөгөөд доорх хүснэгтээр хонжворын тохирлын таах тоо, түүний магадлал, олгох шагнал зэргийг харууллаа.

Хүснэгт 18. Хонжворт сугалааны хонжворын нэр, магадлал, шагнал

Хонжворын нэр	1 тасалбараас тохиролд таарах тоо	1 Магадлал	Хонжвор /төгрөгөөр/ тасалбар		Тухайн төрлийн тасалбарын борлуулалтын %
			5,000 тасалбар	2,500 тасалбар	
Гранд	1 тасалбарт тохирлын 6-н тооноос 6-г таасан	1:6,096,454	100,000,000	10,000,000	44.0%
2-р байр	1 тасалбарт тохирлын 6-н тооноос 5-г таасан	1:27,462	5,000,000	2,500,000	1.0%
3-р байр	1 тасалбарт тохирлын 6-н тооноос 4-г таасан	1:610	50,000	25,000	2.0%
4-р байр	1 тасалбарт тохирлын 6-н тооноос 3-г таасан	1:39	5,000	2,500	3.0%



5,000 төгрөгийн сугалааны азтан болох болзол хангасан бол доорх шагналын эзэн болох боломжтой:

- 1. Гранд шагнал:** Сугалааны 6 тоог зөв таавал Гранд шагнал буюу нийт тасалбарын борлуулалтын 44%-тай тэнцэх мөнгөний эзэн болно.
- 2. 2 дугаар байрны шагнал:** Сугалааны 5 тоог зөв таавал 2 дугаар байрны шагнал буюу 5 сая төгрөг;
- 3. 3 дугаар байрны шагнал:** Сугалааны 4 тоог зөв таавал 3 дугаар байрны шагнал буюу 50,000 төгрөг;
- 4. 4 дүгээр байрны шагнал:** Сугалааны 3 тоог зөв таавал 4 дугаар байрны шагнал буюу 5,000 төгрөг;

2,500 төгрөгийн сугалааны азтан болох болзол хангасан бол доорх шагналын эзэн болох боломжтой:

- 1. Гранд шагнал:** Сугалааны 6 тоог зөв таавал Гранд шагнал буюу нийт тасалбарын борлуулалтын 44%-тай тэнцэх мөнгөний эзэн болно.
- 2. 2 дугаар байрны шагнал:** Сугалааны 5 тоог зөв таавал 2 дугаар байрны шагнал буюу 2.5 сая төгрөг;
- 3. 3 дугаар байрны шагнал:** Сугалааны 4 тоог зөв таавал 3 дугаар байрны шагнал буюу 25,000 төгрөг;
- 4. 4 дүгээр байрны шагнал:** Сугалааны 3 тоог зөв таавал 4 дугаар байрны шагнал буюу 2,500 төгрөг;

Хүснэгт 19. 5,000 төгрөгийн тасалбарын хонжворт сугалааны шагналын төлөвлөгөө /төгрөгөөр/

	2023	2024	2025	2026	2027
Гранд	100,000,000	1,057,160,000	1,765,712,000	2,628,163,720	3,678,089,901
2-р байр	5,000,000	5,000,000	5,000,000	5,000,000	5,000,000
3-р байр	50,000	50,000	50,000	50,000	50,000
4-р байр	5,000	5,000	5,000	5,000	5,000

Хүснэгт 20. 2,500 төгрөгийн тасалбарын хонжворт сугалааны шагналын төлөвлөгөө /төгрөгөөр/

Үзүүлэлт	2023	2024	2025	2026	2027
Гранд	10,000,000	727,155,000	1,214,170,750	1,807,593,808	2,530,376,807
2-р байр	2,500,000	2,500,000	2,500,000	2,500,000	2,500,000
3-р байр	25,000	25,000	25,000	25,000	25,000
4-р байр	2,500	2,500	2,500	2,500	2,500

Хэд хэдэн тоглогч Гранд шагнал зэрэг авах болзол хангасан тохиолдолд азтан тус бүрт нийт шагналын дүнг тэнцүү хуваасан дүнгээр хонжворыг олгоно. Тухайн сарын сугалааны борлуулалтын дүнгээс шалтгаалан тухайн шагналын сан бүрэн бүрдээгүй бол тохирлын


 СТАНДАРТ
 ИНВЕСТМЕНТ ҮЦК
 ХХК
 ТТС3981-х.5444381


 МОНГОЛЫН ХӨНЖВӨРТ СУГАЛААНЫ
 МОНГОЛЫН ХӨНЖВӨРТ СУГАЛААНЫ
 МОНГОЛЫН ХӨНЖВӨРТ СУГАЛААНЫ
 МОНГОЛЫН ХӨНЖВӨРТ СУГАЛААНЫ
 МОНГОЛЫН ХӨНЖВӨРТ СУГАЛААНЫ



ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

азтан шагналын санд цугларсан байгаа мөнгөн шагналыг авна. Нэг шатлалын шагналд хэд хэдэн ялагч тодорсон бол ялагч тус бүр олгох боломжтой шагналын дүнг тэнцүү хуваасан дүнгээр авна.

Сугалааны борлуулалт, шагналын тооцоолол: Үнэт цаас гаргагч нь “Эд мөнгөний хонжворт сугалааны журам”-ийн дагуу долоо хоног бүр нийт 30,000 хүртэл ширхэг сугалааг худалдаанд гаргаж борлуулах боломжтой. 2023 онд компани нь 7 хоногт 9,500 сугалаа гаргахаар төлөвлөсөн бөгөөд жил бүр сугалааны борлуулалтыг 10%-аар нэмэхээр төлөвлөсөн болно. Сугалааг Монгол улсын 18 нас хүрсэн иргэд зөвшөөрөгдсөн аппликейшн болон компанийн цахим хуудсаар дамжуулан худалдан авах боломжтой.

Хүснэгт 21. Сугалааны борлуулалтын төлөвлөгөө, жилээр, төгрөг

	2023	2024	2025	2026	2027
Нийт борлуулалт	1,755,000,000	2,123,550,000	2,569,495,500	3,109,089,555	3,761,998,362
Сугалааны борлуулалт 1	1,040,000,000	1,258,400,000	1,522,664,000	1,842,423,440	2,229,332,362
Тоо	208,000	228,800	251,680	276,848	304,533
Нэгжийн үнэ	5,000	5,500	6,050	6,655	7,321
Сугалааны борлуулалт 2	715,000,000	865,150,000	1,046,831,500	1,266,666,115	1,532,665,999
Тоо	286,000	314,600	346,060	380,666	418,733
Нэгжийн үнэ	2,500	2,750	3,025	3,328	3,660

Үнэт цаас гаргагч нь 2023 онд 5,000 төгрөгийн сугалааг 208 мянга, 2,500 төгрөгийн сугалааг 286 мянга ширхгийг борлуулж, жилд 1.8 тэрбум төгрөгийн сугалааны борлуулалтын орлоготой ажиллахаар төлөвлөсөн. Үнэт цаас гаргагч нь сугалааны шагналын сангаас хамааруулан сугалааны үнийг 5,000 болон 2,500 төгрөгөөр тогтоосон бөгөөд 2027 онд сугалааны үнийг нэмэгдүүлж, 7,321 болон 3,660 төгрөг болгохоор төлөвлөсөн болно.

Хүснэгт 22. Сугалааны үнийн төлөвлөгөө

Үзүүлэлт	2023	2024	2025	2026	2027
Тасалбарын үнэ 1	5,000	5,500	6,050	6,655	7,321
Тасалбарын үнэ 2	2,500	2,750	3,025	3,328	3,660
Өсөлт 1	0%	10%	10%	10%	10%
Өсөлт 2	0%	10%	10%	10%	10%

Сугалааны борлуулалт, тохирол таарах магадлал зэргийг тооцон үзэж сугалааны хонжвор таарах тохиолдлыг төлөвлөсөн бөгөөд сугалааны борлуулалт нэмэгдэх тусам 43 тооноос 6-н тоог тааж, Гранд шагнал хожих магадлал нь нэмэгдэх юм.

Хүснэгт 23. Тохирол таарах тохиолдол, жилээр, ширхэг

Таах тоо	2023	2024	2025	2026	2027
Тасалбар 1					
6	-	-	-	-	-
5	-	-	-	-	-
4	364.00	364.00	416.00	468.00	520.00





ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

3	5,304.00	5,824.00	6,396.00	7,072.00	7,748.00
Тасалбар 2					
6	-	-	-	-	-
5	-	-	-	-	-
4	468.00	520.00	572.00	624.00	676.00
3	7,280.00	8,008.00	8,840.00	9,724.00	10,660.00

Тохирол таарсан нөхцөлд олгох шагналыг хонжвор тус бүрээр тооцон доорх хүснэгтэд төлөвлөсөн болно. Тухайлбал, 2023 онд нийт тодрох азтаны тохирлын хонжворт 74.6 сая төгрөг олгохоор төлөвлөсөн бол цаашид борлуулалтын өсөлттэй хамааруулан 108.3 сая төгрөг хүртэл өснө гэж төлөвлөсөн болно.

Хүснэгт 24. Тохирол таарсан нөхцөлд хонжворт олгох шагналын нийт дүн /төгрөгөөр/

	2023	2024	2025	2026	2027
Нийт	74,620,000	80,340,000	89,180,000	98,670,000	108,290,000
6	-	-	-	-	-
5	-	-	-	-	-
4	29,900,000	31,200,000	35,100,000	39,000,000	42,900,000
3	44,720,000	49,140,000	54,080,000	59,670,000	65,390,000
Тасалбар 1	44,720,000	47,320,000	52,780,000	58,760,000	64,740,000
6	-	-	-	-	-
5	-	-	-	-	-
4	18,200,000	18,200,000	20,800,000	23,400,000	26,000,000
3	26,520,000	29,120,000	31,980,000	35,360,000	38,740,000
Тасалбар 2	29,900,000	33,020,000	36,400,000	39,910,000	43,550,000
6	-	-	-	-	-
5	-	-	-	-	-
4	11,700,000	13,000,000	14,300,000	15,600,000	16,900,000
3	18,200,000	20,020,000	22,100,000	24,310,000	26,650,000

Шагналын сан: Үнэт цаас гаргагч нь сугалааны шагналын санг 2 хувааж, дараах 2 төрлийн шагналын санг үүсгэж явна:

- ❖ **Шагналын сан:** Уг санд тухайн сарын сугалааны борлуулалтын орлогын 50-аас багагүй хувийг төвлөрүүлнэ.
- ❖ **Шагналын нөөц сан:** Уг сан нь системийн алдаа эсвэл бусад шалтгааны улмаас хүчин төгөлдөр боловч урьдчилан тооцоолоогүй улмаас гарсан шагналын нэхэмжлэлийн төлбөрийг барагдуулахад ашиглах сан юм. Тус санд тухайн 7 хоногийн сугалааны борлуулалтын орлогын 5-аас багагүй хувийг төвлөрүүлнэ.

Нийт 2 шагналын сан нь тухайн тохирлыг үе дэх нийт сугалааны борлуулалтын орлогын 55%-аас багагүй хувийг төвлөрүүлнэ. 2023 оны эцсээр шагналын санд нийт борлуулалтаас 877.5 сая төгрөг төвлөрүүлэхээс 520 сая төгрөг нь 5,000 төгрөгийн тасалбарын шагналын сан, 357.5 сая төгрөг нь 2,500 төгрөгийн тасалбарын шагналын сан байхаар төлөвлөсөн болно.



Хүснэгт 25. Шагналын сан, төгрөг, тасалбар тус бүрээр

	2023	2024	2025	2026	2027
Нийт шагналын сан	877,500,000	1,061,775,000	1,284,747,750	1,554,544,778	1,880,999,181
Шагналын сан 1	520,000,000	629,200,000	761,332,000	921,211,720	1,114,666,181
Борлуулалтаас тооцох хувь	50.0%	50.0%	50.0%	50.0%	50.0%
Шагналын сан 2	357,500,000	432,575,000	523,415,750	633,333,058	766,333,000
Борлуулалтаас тооцох хувь	50%	50%	50%	50%	50%

2023 онд нийт 2 сугалааны тасалбарын шагналд 74.6 сая төгрөгийг тохирлын азтанд олгохоор төлөвлөсөн болно. Ингэснээр Шагналын сангийн үлдэгдэл 802.8 сая төгрөг байхаар төлөвлөсөн. Цаашид Шагналын сангийн үлдэгдэл борлуулалтын орлоготой уялдан 2024 онд 1.8 тэрбум төгрөг, 2027 онд 6.2 тэрбум төгрөгт болж өсөх төлөвлөгөөг гаргалаа.

Хүснэгт 26. Шагналын сан, төгрөг, үлдэгдлээр


	2023	2024	2025	2026	2027
Эхлэх	-	802,880,000	1,784,315,000	2,979,882,750	4,435,757,528
Нэмэгдсэн	877,500,000	1,061,775,000	1,284,747,750	1,554,544,778	1,880,999,181
Хувь	50%	50%	50%	50%	50%
Төлөгдсөн	74,620,000	80,340,000	89,180,000	98,670,000	108,290,000
Эцсийн	802,880,000	1,784,315,000	2,979,882,750	4,435,757,528	6,208,466,708

Шагналын нөөц санд нийт борлуулалтын орлогын 5-аас багагүй хувийг төвлөрүүлэх ба уг сан нь хүчин төгөлдөр боловч системийн алдаа, бусад шалтгаан, урьдчилан тооцоолоогүй нөхцөл байдлын улмаас гарсан шагналын нэхэмжлэлийн төлбөрийг барагдуулахад ашиглах нөөцийн сан юм. Шагналын нөөцийн санд 2023 онд нийт борлуулалтын орлогын 5 хувь буюу 87.8 сая төгрөг байршуулахаар төлөвлөсөн болно.

Хүснэгт 27. Шагналын нөөц сан /төгрөгөөр/

Үзүүлэлт	2023	2024	2025	2026	2027
Эхлэх	-	87,750,000	193,927,500	322,402,275	477,856,753
Нэмэгдсэн	87,750,000	106,177,500	128,474,775	155,454,478	188,099,918
Хувь	5%	5%	5%	5%	5%
Төлөгдсөн	-	-	-	-	-
Эцсийн	87,750,000	193,927,500	322,402,275	477,856,753	665,956,671

Хүснэгт 28. Эерэг хандлага сугалааны зохион байгуулах үйл явц

1.		<p>Сугалаа үүсгэх</p> <ul style="list-style-type: none"> - Сугалааны явуулах давтамжийн дагуу Сугалааг програм үүсгэнэ. - Ажилтан сугалааны эхлэх дуусах дугаарлалтыг гараас оруулж өгнө.
----	---	---





ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

тогтоомж, төрийн эрх бүхий байгууллагаас баталсан стандарт, нөхцөл шаардлагын хүрээнд зохион байгуулж, найдвартай байдлыг ханган ажилладаг.

Компани нь өнгөрсөн 3 жилд дунджаар сугалаат хөтөлбөрийн хүрээнд 4.2 сая ширхэг сугалааны стикер гаргаж байсан билээ. Тэгвэл цаашид програм хангамж болон борлуулалтаа сайжруулж, энэхүү үйлчилгээгээ жилд 20%-аар өсгөхөөр төлөвлөөд байна. 2022 оны байдлаар компани нь 4.8 сая стикер гаргаж, 120 сая төгрөгийн орлого олж байсан бол 2023 онд 6.0 сая стикер гаргахаар төлөвлөсөн болно. Компани нь өнгөрсөн хугацаанд 10 гаруй аж ахуй нэгжийн бүтээгдэхүүнд урамшуулалт хөтөлбөрийг зохион байгуулж байсан бол Монгол улсын хэмжээнд 180 мянган аж ахуй нэгж байгаагаас 151.6⁷ мянга нь үйл ажиллагаа явуулж байгаа том зах зээл тул бид харилцагчдынхаа тоог бүрэн нэмэгдүүлэх боломжтой гэж харж байна.

Хүснэгт 29. Сугалааны стикер гаргах төлөвлөгөө

Үзүүлэлт	2023	2024	2025	2026	2027
Сугалааны тоо	6,036,266	7,545,333	9,431,666	11,789,583	14,736,978
Орлого	158,451,990	207,968,237	272,958,312	358,257,784	470,213,342

Хүний нөөцийн төлөвлөгөө: Үнэт цаас гаргагч нь үйл ажиллагааны бүтцийн хувьд чадварлаг, цомхон бүрэлдэхүүнтэй ажиллахыг зорьж байгаа бөгөөд 4 албатай, 7 ажилтантай, бүтэц зохион байгуулалттайгаар үйл ажиллагаа явуулахаар төлөвлөсөн. Бүтэц зохион байгуулалт нь санхүүгийн мэдээллийн ил тод, засаглал, хяналтын чиг үүргүүдийг бүтээмжтэй, мэргэжлийн байх нөхцөл бололцоог хангасан байх боломжийг олгох юм. Үнэт цаас гаргагч нь одоогоор 5 ажилтны бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд цаашид 7 хүртэл ажилтантайгаар хонжворт сугалааны үйл ажиллагаа явуулахаар төлөвлөж байна. Гүйцэтгэх захирал, ерөнхий нягтлан, маркетинг болон борлуулалтын ажилтан, програм хангамжийн ажилтан гэсэн бүрэлдэхүүнтэй бөгөөд цаашид сугалааны борлуулалтыг нэмэгдүүлэх үүднээс борлуулалтын менежерын тоог нэмэхээр төлөвлөсөн.

Хүснэгт 30. Хүний нөөц, цалингийн зардлын төлөвлөгөө

Үзүүлэлтүүд	2023	2024	2025	2026
Ажилтны тоо	6	7	7	7
Нийт цалин	127,260,000	153,468,000	161,141,400	169,198,470
НДШ	13,998,600	16,881,480	17,725,554	18,611,832

Хүний нөөцтэй холбоотойгоор гарах цалингийн зардлын төлөвлөгөөг доорх байдлаар төлөвлөж үйл ажиллагааны зардалд оруулсан. Тухайлбал 2023 онд ажилчдын тоо нэмэгдсэн мөн сугалааны үйл ажиллагаа тасралтгүй явуулахаар төлөвлөж байгаатай холбоотойгоор цалингийн зардал 127.3 сая төгрөг байхаар төлөвлөсөн болно.

2.4. Эрсдэл, эрсдэлийн удирдлагын талаар:

⁷ <https://ikon.mn/n/2nsg>





ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

Үнэт цаас гаргагчийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 22/4 тоот тогтоолын 8 дугаар хавсралтаар “Эрсдэлийн удирдлагын журам”-ыг баталсан. Энэхүү журмаар үнэт цаас гаргагчийн дунд хугацааны бизнес төлөвлөгөөнд тусгагдсан зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэхэд учирч болох эрсдэлийг таних, хэмжих, түүнд тохирсон арга хэмжээг хэрэгжүүлж эрсдэлийн нөлөөллийг удирдахад чиглэсэн. Эрсдэлийг тодорхойлохдоо үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд өнгөрсөн хугацаанд гарсан эрсдэлийг тодорхойлж, ирээдүйд бий болох эрсдэл, тэдгээрийн давтамж, цар хүрээг тооцох, цаашид урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэхтэй холбоотой.

Үнэт цаас гаргагчийн хэвийн үйл ажиллагааг хангахтай холбоотой Санхүүгийн эрсдэл, үйл ажиллагааны эрсдэл, компанийн бичиг баримт, хууль тогтоомжийн хэрэгжилтийн эрсдэл, гадаад хүчин зүйлсийн эрсдэлийг авч үзсэн.

Хүснэгт 31. Эрсдэлийн удирдлагын хөтөлбөр

Үйл ажиллагаа	Санхүү	Гадаад хүчин зүйл	
Үйл ажиллагааны эрсдэл, компанийн бичиг баримт, хууль тогтоомжийн хэрэгжилтийн эрсдэл	Санхүүгийн эрсдэл	Макро эдийн засгийн нөхцөл байдал	Хэрэглэгчийн зан төлөв, хууль эрх зүйн зохицуулалтын орчны өөрчлөлт


Хүснэгт 32. Эрсдэлийн үнэлгээ

Эрсдэлийн оноо	Эрсдэлийн төлөв	Үзүүлэх хариу үйлдэл
0.26-0.84	Ноцтой	Гарцаагүй хариу үйлдэл хийж, нэн тэргүүнд шийдвэрлэх
0.06-0.25	Нөлөө үзүүлэхүйц	Хариу үйлдэл хийж, шийдвэрлэх шаардлагатай
0.01-0.05	Нөлөө багатай	Эрсдэлд байнгын хяналт тавих

Хүснэгт 33. Эрсдэлийн үнэлгээ

	Бүлэг	Эрсдэлийн төлөв		
		Н	НҮ	НБ
1	Хүний нөөц	✓		
2	Санхүү		✓	





3	Үйл ажиллагаа		✓	
4	Үйлдвэрлэл			✓
5	Борлуулалт, маркетинг	✓		
6	Гадаад хүчин зүйл		✓	

Хүснэгт 34. Эрсдэлийн төрөл

Эрсдэлийн
хүчин зүйлс

Үүсэж болзошгүй нөхцөл байдал

Урьдчилан
сэргийлэх
хэрэгсэл

арга,

Бизнес, зах зээл
болон эдийн
засгийн эрсдэл

Дэлхийн хонжворт сугалааны салбар дахь өрсөлдөөн ихтэй бөгөөд хэрвээ үр дүнтэй өрсөлдөж чадахгүй бол боломжит хэрэглэгчид маань өрсөлдөгчдөдөө эсвэл телевиз, кино, онлайн тоглоом, спортын бооцоо тавих зэрэг энтертайнментын татагдаж болзошгүй. Ингэснээр үнэ, ашигт ажиллагаа, зах зээлд эзлэх хувь алдагдаж цаашлаад бизнес, санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнд хохирол учруулж болзошгүй.

- Үнэт цаас гаргагчаас үл хамаарах эдийн засгийн уналт, улс төрийн тогтворгүй байдал нь бидний бизнес, санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнд сөргөөр нөлөөлж болзошгүй.
- Хэрэглэгчид эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан хэрэглээний зардлаа бууруулах нь мөн санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнд сөргөөр нөлөөлж болзошгүй.
- Хонжворт сугалаатай холбоотой сөрөг үйл явдлууд эсвэл сөрөг мэдээлэл хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацагдах, сугалаа, онлайн тоглоом, бооцооны хэлбэр, тоглоомын салбартай холбоотой бусад сөрөг мэдээлэл нь манай үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж болзошгүй.
- Бизнесийн өсөлт нь тоглогчдыг татах, хэрэглэгчдийг авч үлдэх чадвараас хамаарах бөгөөд хэрэглэгчдээ алдах, шинэ хэрэглэгчдийг

Макро эдийн засгийн болон салбарын тоон болон чанарын шинжилгээг хийж, зах зээлийн нөхцөл байдлыг тодорхойлж, эрсдэлтэй нөхцөл байдлыг илрүүлж, маркетинг, PR оновчтой бодлогыг тухай бүр хэрэгжүүлэх



хямд зардлаар татах боломжгүй байх, бизнесийн өсөлтөө үр дүнтэй удирдаж чадахгүй байх нь бидний бизнес, санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнд мөн нөлөөлөх эрсдэлтэй.

- Интернет хайлтын системүүд дээр бид хайлтын үр дүнд тод харагдахгүй бол бидний шинэ хэрэглэгчдийн өсөлт буурч, бизнес, санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнд сөргөөр нөлөөлнө.

- Үнэт цаас гаргагч өөрсдийн бизнест ашигладаг домэйн нэрийг үргэлжлүүлэн ашиглах эсвэл манай брэнд, барааны тэмдэг, үйлчилгээний тэмдгийн үнэ цэнийг зөрчсөн, ижил төстэй, эсвэл өөр байдлаар бууруулдаг домэйн нэрийг гуравдагч этгээд олж авах, ашиглахаас урьдчилан сэргийлэх боломжгүй байж магадлалтай.

- Цар тахал, халдварт өвчний дэгдэлттэй холбоотой эрсдэлүүд мөн үйл ажиллагааг тасалдуулж, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлж болзошгүй юм.

- Бид компанийн нийгмийн хариуцлага, нэр хүнд, ёс зүйтэй холбоотой эрсдэлд өртөх магадлалтай.

Үйл ажиллагааны эрсдэл

Цахим сугалааны зах зээл өсөлтийн харьцангуй эхэн үе шатандаа байгаа бөгөөд хэрэв уг зах зээл цаашид өсөхгүй, бидний төсөөлж байснаас удаан өсөх эсвэл бидний таамаглаж байснаас өсөхгүй бол бидний бизнес, санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнд сөргөөр нөлөөлж болзошгүй юм.

- Үнэт цаас гаргагчийн одоо байгаа болон ирээдүйн бүтээгдэхүүн, технологи, үйлчилгээ, шийдлүүд нь хурдацтай өөрчлөгдөж буй технологи, хөгжиж буй салбарын стандарт, өөрчлөгдөж буй зохицуулалттай хөл нийлүүлэн алхаж, дасан зохицож чадахгүй бол манай бизнест сөргөөр нөлөөлж болзошгүй.

Үйл ажиллагааны эрсдэлийг тоон болон чанарын шинжилгээгээр тогтоох, VaR аргачлалыг ашиглана.

- Бидний үйл ажиллагааны үр дүн улирлын болон бусад хүчин зүйлээс шалтгаалж



хэлбэлзэж болзошгүй тул бидний тодорхой хугацааны үйл ажиллагааны үр дүн ирээдүйн гүйцэтгэлийн баталгаа бүрэн болохгүй байх магадлалтай.

• Бид үйл ажиллагааны зардал, эдгээр салбарыг зохицуулж буй хууль тогтоомж болон бусад хүчин зүйлсээс шалтгаалан тоглоомын болон сугалааны салбарын чиг хандлага, өөрчлөлтийг бүрэн дүүрэн ашиглах боломжгүй байх эрсдэлтэй.

Брэнд болон нэр хүндэд учрах эрсдэл

Хонжворт сугалааны салбар нь нэр хүндээс ихээхэн хамаардаг бөгөөд хэрэв үнэт цаас гаргагч өөрсдийн брэнд, нэр хүндээ хөгжүүлж, хадгалж, өсгөж чадахгүй бол, тэр дундаа сөрөг сурталчилгааны үр дүнд бидний бизнес, үйл ажиллагааны үр дүнд хохирол учруулж болзошгүй.

Маркетингийн оновчтой бодлогыг хэрэгжүүлж, цахим маркетингийн бодлогыг хэрэгжүүлэх

- Бизнесээ хөгжүүлэхэд туслах бидний маркетингийн хүчин чармайлт үр дүнгүй байж магадгүй.
- Хэрэглэгчдэд чанартай түргэн шуурхай тусламж дэмжлэг үзүүлэхгүй байх нь бидний хэрэглэгчидтэй харилцах харилцаанд сөргөөр нөлөөлж, бидний нэр хүнд, брэнд, бизнес, санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнд сөргөөр нөлөөлж болзошгүй.

Мэдээллийн технологийн эрсдэл

Бид мэдээллийн технологи болон бусад систем, үйлчилгээнд тулгуурладаг бөгөөд манай системд гарсан аливаа доголдол, алдаа, согог, тасалдал эсвэл үйлчилгээнийхээ хүртээмж нь бидний брэнд, нэр хүндийг бууруулж, хариуцлага хүлээлгэж, бизнесээ тасалдуулж, ажиллах чадварт нөлөөлж болзошгүй.

Мэдээллийн аюулгүй байдлын бодлогыг хэрэгжүүлэх, back up бодлогыг хэрэгжүүлэх

Эрсдэлийн удирдлагын үйл явц:

- *Нөхцөл байдлыг тодорхойлох:* Үнэт цаас гаргагч нь гадаад, дотоод нөхцөл байдлыг тоон болон чанарын шинжилгээг хийж, тайлбарлагч болон тайлбарлагдагч хүчин зүйлсийн хоорондын хамаарлыг илрүүлэх;
- *Эрсдэлийг үнэлэх:* Гадаад, дотоод хүчин зүйлс, тэдгээрийн хоорондын хамааралд үндэслэн үндсэн үйл ажиллагаанд тулгарч болох эрсдэлийг тодорхойлж, хамгийн өндөр болон бага эрсдэлийг илрүүлж, эрсдэл тус тус бүрээр үнэлгээ хийх;





ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА



- Эрсдэлийн хариу арга хэмжээ авах: Тодорхойлсон эрсдэлүүдийг үнэлсний үндсэн ноцтой нөлөө үзүүлэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэл учирсан нөхцөлд даван туулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
- Эрсдэлийн мониторинг;
- Мэдээлэл солилцож, зөвлөлдөх
- Тайлагнах

Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх этгээд: Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн гадаад ба дотоод үйл ажиллагааны бүхий л эрсдэл, санхүү, хууль тогтоомжийн хэрэгжилт болон бусад эрсдэлийг эрсдэлийн удирдлагаар хангах нэгдсэн үйл ажиллагааг хариуцна.

- Эрсдэлийн удирдлагын бодлогыг тодорхойлох, түүний дагуу эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх;
- Эрсдэлийн удирдлагын хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулах;
- Эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, хариу арга хэмжээ авах талаар журмыг боловсруулах, батлах, хэрэгжүүлэх;

Дотоод хяналтын алба, чанарын албаар дамжуулан эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, түүний хэрэгжилтэд хяналт тавин ажиллахаар холбогдох дүрэм, журмаар зохицуулсан.





3.2. Нийтэд санал болгох хувьцааны тоо ширхэг, санал болгох үнэ, үнэлгээний товч тайлан, хувьцаа эзэмшигчдийн бүтцийн өөрчлөлт:

Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн болон төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 22/7 тоот тогтоолуудаар нийтэд санал болгох хувьцааны тоо ширхэг, санал болгох үнийг хувьцаагаа олон нийтэд санал болгон гаргах ажиллагаанд хөндлөнгийн үнэлгээний үзүүлэгч “АТЕН” ХХК-ийн үнэлгээний тайлан, андеррайтерийн компанийн саналыг тус тус үндэслэн дараах байдлаар тогтоосон.

Хүснэгт 1. Үнэт цаасны товч танилцуулга

Үзүүлэлт	Тодорхойлолт
Үнэт цаас гаргагч	“Гранд системс” ХХК
Үнэт цаасны төрөл	Энгийн хувьцаа
Нийт гаргасан хувьцааны тоо	3,000,000 ширхэг
Нэрлэсэн үнэ	100 төгрөг
Олон нийтэд санал болгох хувьцааны тоо	750,000 ширхэг
Олон нийтэд санал болгох хувьцааны хувь	20.0%
Олон нийтэд санал болгох хувьцааны үнэ	900 төгрөг
Нийт татан төвлөрүүлэх хөрөнгө	675,000,000 төгрөг
Олон нийтэд санал болгосны дараах хувьцааны тоо	3,750,000 ширхэг
Олон нийтэд санал болгох арга хэлбэр	Тогтоосон үнийн арга
Татсан хөрөнгийн зарцуулалт	<ul style="list-style-type: none"> • Үйл ажиллагаагаа өргөжүүлэх, техник шинэчлэл хийх, програм хангамж хөгжүүлэх
Арилжааг зохион байгуулах байгууллага	“Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК
Андеррайтер	“Стандарт Инвестмент ҮЦК” ХХК

Үнэт цаас гаргагчийн хувьцаагаа олон нийтэд санал болгох ажиллагаанд хөндлөнгийн үнэлгээний үйлчилгээг “АТЕН” ХХК гүйцэтгэхээр 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдөр бизнесийн үнэлгээг хийх тухай гэрээг байгуулан ажилласан. Үнэлгээний компаниас үнэт цаас гаргагчийн хувьцаа гаргах ажиллагаанд бизнесийн үнэлгээг гүйцэтгэсэн бөгөөд үнэлгээний тайланг товч байдлаар авч үзвэл:

Үнэлгээний товч тайлан: Үнэлгээний үйлчилгээ үзүүлэгч “АТЕН” ХХК нь “Гранд системс” ХХК-ийн бизнесийн үнэ цэнийг тогтоохдоо Үнэлгээний олон улсын стандартын консул (International Valuation Standart Council “IVSC”) -аас гаргасан Үнэлгээний олон улсын стандарт (YOUC)-ууд болох Үнэлгээний ажлын цар хүрээ (YOUC 101), Тайлагнал (YOUC 103), Үнэ цэнийн сууриуд (YOUC 104), Үнэлгээний хандлагууд ба аргууд (YOUC 105), Бизнес ба бизнесийн хувь оролцоо (YOUC200) болон Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ)-ны даргын хамтарсан 274/240 тоот тушаалаар батлагдсан “Бизнесийн үнэлгээний аргачлал” тус тус баримталсан.





ГУРАВ: ОЛОН НИЙТЭД САНАЛ БОЛГОН ГАРГАХ ХУВЬЦАА, ТАТАН ТӨВЛӨРҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ


3.1. Олон нийтэд хувьцаа гаргаж, компанийн хэлбэрийг өөрчлөх шийдвэр:

Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 9/23 тогтоолоор Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.3 дахь хэсэг, мөн хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2.1 дахь хэсгийг үндэслэн “Гранд системс” ХХК-ийн дүрэм, 2022 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн №22/2 тоот “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тэмдэглэл”, хувьцаа эзэмшигчдийн хурлын №9/23 тоот тогтоолыг тус тус үндэслэн үнэт цаас гаргагч нь 750,000 ширхэг энгийн хувьцааг нэмж гарган 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 3,750,000 ширхэг энгийн хувьцаатай байхаар тогтоосон.

Мөн уг тогтоолоор Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.4 дэх хэсэг, 55 дугаар зүйлийн 55.2 дахь хэсгийг үндэслэн нэмж гаргаж буй хувьцааны үнэ болон түүний нөхцөлийг тогтоох эрхийг төлөөлөн удирдах зөвлөлд олгосон болно.

Үнэт цаас гаргагчийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн ТУЗ-ийн 22/7 тоот тогтоолоор хөрөнгийн болон бизнесийн үнэлгээний тайланг тус тус үндэслэн компанийн үнэлгээг 2.7 тэрбум төгрөгөөр тогтоож, 750,000 ширхэг хувьцааг нэг бүрийг 900 төгрөгөөр олон нийтэд санал болгохоор шийдвэрлэсэн.

Зураглал 5. Хувьцаа эзэмшигчдийн шийдвэр.





ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА



Үнэлж буй “Гранд системс” ХХК-ийн оршин буй салбарын бизнесийн онцлог нь Зөвшөөрлийн тухай хуулийн дагуу тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхэлдэг, ижил төрлийн бизнесийг дахин бий болгоход хязгаарлагдмал бөгөөд бий болгох боломжит орлогыг төсөөлөх боломжтой, орлого бий болгох чадвартай, салбарт орших бизнесүүд технологи, менежмент маркетингийн зөв бодлогоор өрсөлдөөнийг бий болгодог зэрэг хүчин зүйлсийг харгалзан үзэж бизнес, бизнесийн хувь оролцооны үнэ цэнийг Орлогын хандлагаар гүйцэтгэлээ.

“Гранд системс” ХХК-ийн бизнесийн үнэлгээг хийхдээ Монголбанкны судалгаагаар хүлээгдэж буй ДНБ-ийн өсөлтийн хувь 4.4-6.1 хувь, уул уурхайн бус салбарынх 3.6-6.1 хувь, Олон улсын валютын сангийн гаргасан судалгаагаар 6.5 хувь байх нөхцөлийг баримталсан бөгөөд хонжворт сугалааны зах зээлийн өсөлт 2027 оны байдлаар CAGR 9.4 хувь, Ази номхон далайн бүс нутагт 10.1 хувь хүрэх төлөвтэй байгааг харгалзан үзсэн.

Хорогдуулгын хувийн судалгаагаар 50 хувийн quartile2-24 хувь, 75 хувийн quartile-33 хувь байх боломжтой гэж үзэн, капитал хорогдуулалтын WACC загвараар салбарын бетта-1.16, CRP-6.43 хувь, ERP-10.67 хувь, Монгол улсын урт хугацааны өсөлт 6.5 хувь, АНУ 2.4 хувь байх зэрэг үндсэн нөхцөлийг дэвшүүлэн тооцоход 29.12 хувийг үндэслэлтэй гэж үзэн хорогдуулан хүү 23.12 хувь-35.12 хувь завсарт мэдрэмжийн шинжилгээг хийсэн.

“Гранд системс” ХХК-ийн бизнес, бизнесийн 100 хувийн оролцооны зах зээлийн үнэ цэнийг үнэт цаасны зах зээлд шинээр хувьцаа гаргах зорилгоор тооцоолоход:

- Нэгдүгээр хувилбар: Үнэт цаас гаргагчийн бизнес төлөвлөгөөнд тусгасан урьдач нөхцөл, тусгай төсөөллийн хүрээнд: 3,752,161,155 төгрөг;
- Хоёрдугаар хувилбар: Үнэлгээчдийн дэвшүүлсэн тусгай төсөөллийн хүрээнд: 2,286,404,286 төгрөг.

Үнэлгээчдийн тооцоолсон үнэ цэнд хорогдуулгын хувь 3 хувь, өсөлтийн хувь 1 хувиар хэлбэлзэхэд үнэ цэнэ хэрхэн өөрчлөгдөх боломжтойг тодруулсан мэдрэмжийн шинжилгээний үр дүнд:

- Бизнес, бизнесийн оролцооны зах зээлийн үнэ цэнэ 2,044,294,489 төгрөгөөс багагүй;
- Бизнес, бизнесийн оролцооны зах зээлийн үнэ цэнэ 2,719,747,293 төгрөгөөс ихгүй байх боломжтой тооцооллыг хийв.

Үнэт цаасны зах зээлд шинээр хувьцаа гаргах зорилгоор “Гранд системс” ХХК-ийн бизнесийн өмчийн 100 хувь оролцооны зах зээлийн үнэ цэнийг 2,286,000,000-2,720,000,000 төгрөг байх боломжтой гэж тодорхойлсон.

Үнэт цаас гаргагч нь 300.0 сая төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй байгаа бөгөөд Монгол Улсын Сангийн Яамнаас олгосон эд хөрөнгийн хонжворт сугалаа явуулах тусгай зөвшөөрөлтэй бөгөөд мөн өнгөрсөн хугацааны туршлага дээрээ үндэслэн компанийн үнэ цэнийг 2.7 тэрбум төгрөг гэж ТУЗ-ийн шийдвэрээр үнэлгээг баталгаажуулсан болно. Иймд нийт үнэлгээний 20%-тай тэнцэх 675.0 сая төгрөгийн хувьцааг нэмж гаргахаар төлөвлөсөн. Үнэт цаас гаргагчийн 2022 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталсан дүрэмд компанийн энгийн хувьцааны нэрлэсэн үнэ 100 төгрөгийн





ҮНЭТ ЦААСНЫ ГАНЦЛУУЛГА

3,750,000 ширхэг болгон шийдвэрлэснээр хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 375,000,000 төгрөг болно.

Хүснэгт 36. Олон нийтэд хувьцаа гаргасны дараах хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц:

	2022			2023			Хувь
	Ширхэг	Нэгжийн үнэ	ХНХ	Ширхэг	Нэгжийн үнэ	ХНХ	
Одоо байгаа	3,000,000	100	300,000,000	3,000,000	100	300,000,000	80.0%
Олон нийтэд нэмж гаргах				750,000	100	75,000,000	20.0%
Нийт						375,000,000	100.0%

Олон нийтэд анх удаа нэмж хувьцаа гаргасны дараа үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн бүтцийг доорх хүснэгтээр харуулав.

Хүснэгт 37. Олон нийтэд санал болгон гаргасны дараах хувьцаа эзэмшигчдийн бүтэц:

	Хувьцаа гаргахаас өмнө		Хувьцаа гаргахаас өмнө	
	Хувьцааны тоо	Хувь	Хувьцааны тоо	Хувь
“Баялаг хонд” ХХК	2,670,000	89.0%	2,670,000	71.2%
Н.Сүрэнхорлоо	300,000	10.0%	300,000	8.0%
Н.Лхамсүрэн	30,000	1.0%	30,000	0.8%
Олон нийт	-	0.0%	750,000	20.0%
Нийт	3,000,000	100.0%	3,750,000	100.0%

3.3. Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалтын төлөвлөгөө, үр ашгийн тооцоолол:

“Гранд системс” ХХК нь нийт 750,000 ширхэг хувьцааг нэг бүрийг 900 төгрөгөөр олон нийтэд санал болгон гаргаж, нийт 675,000,000 төгрөгийн санхүүжилтийг олон нийтээс татан төвлөрүүлэхээр төлөвлөж, хувьцааны борлуулалтаар татан төвлөрүүлсэн хөрөнгөөр хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлж, үйл ажиллагаа өргөжүүлэхэд зарцуулахаар төлөвлөсөн.

Хүснэгт 38. Үнэт цаасаар татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт

Зарцуулалт	Үнийн дүн
Үнэт цаас анх удаа гаргахтай холбоотой зардлууд	100,000,000
Сугалааны машины, түүний програм	25,982,880
Програм хангамж хөгжүүлэх	250,000,000
Маркетинг	299,017,120
Нийт	675,000,000

Үнэт цаас гаргагч нь олон нийтэд анх удаа санал болгож буй 750,000 ширхэг энгийн хувьцааг амжилттай арилжаалан 675,000,000 төгрөгийн санхүүжилтийг татан төвлөрүүлэхээр төлөвлөж байна. Энэхүү санхүүжилтээс анх удаа үнэт цаас гаргахтай





холбоотой мэргэжлийн байгууллагуудын зардлыг холбогдох журмын дагуу хасаж үлдэх хөрөнгийг компанийн үйл ажиллагааг өргөжүүлэхэд зарцуулна гэж төлөвлөсөн болно.

Сугалааны тоног төхөөрөмжийн танилцуулга: Үнэт цаас гаргагчийн сонгодог төрлийн эд мөнгөний хонжворт сугалааны үйл ажиллагааг явуулах хамгийн чухал тоног төхөөрөмж бол хонжворт сугалааны тохирлыг явуулах машин, төхөөрөмж бөгөөд сугалааны тохирлыг найдвартай явуулах, сугалааны тоо хэмжээ, дугаарыг бүртгэх олон улсын стандарт хангасан тоног төхөөрөмж, програм зайлшгүй шаардлагатай. Иймээс үнэт цаас гаргагч нь Хятад улсад байршилтай 2017 оноос тасралтгүй үйл ажиллагаа явуулж ирсэн Kydavr Tech компаниас сугалааны машин авахаар төлөвлөсөн. Харин сугалааны програм болон машиныг Хятад улсын ЕКЕМР компаниас авахаар төлөвлөж байна.

Компанийн нийт орлого нь үндсэн үйл ажиллагаа болох сугалаат хөтөлбөр болон эерэг хандлага сонгодог төрлийн сугалааны борлуулалт, шагналын нөөц сангийн хадгаламжийн хүү болон бусад орлогоос бүрдэх юм. Тухайлбал, 2023 онд 1.9 тэрбум төгрөгийн орлого олохоор төлөвлөсөн бөгөөд үүний 8.1% нь сугалаат хөтөлбөрийн орлого, 89.7% нь эерэг хандлага сугалааны борлуулалтын орлого байхаар төлөвлөсөн болно. Компани нь сугалаат хөтөлбөрийн стикерийн борлуулалтыг 25%, эерэг хандлага сугалааны борлуулалтыг жил бүр тогтвортой 10%-аар өсөхөөр төлөвлөж байгаа бөгөөд 2027 онд нийт орлого 3.8 тэрбум төгрөг болохоор төлөвлөсөн.

Зардлын хувьд сугалааны үйл ажиллагаатай холбоотойгоор маркетинг борлуулалтын зардлыг ирэх жилүүдэд эрчимтэй нэмэгдүүлсэн болно. 2023 онд нийт 1.6 тэрбум төгрөгийн үйл ажиллагааны зардал гаргахаар төлөвлөсөн бөгөөд үүний 17.0% нь ерөнхий удирдлагын зардал, 14.7% нь борлуулалт, маркетингийн зардал, 57.0% нь шагналын сан болон шагналын нөөц сангийн зардал, 5.8% нь бусад зардал болно. Цаашид програм хангамж ашиглаж байгаатай холбоотой ерөнхий удирдлагын зардал буурч 2027 онд 11.6% хүртэл буурах бол шагналын сан нийт зардлын 65.7% хүртэл нэмэгдэх бөгөөд хандив тусламжийн зардал 6.3% болохоор төлөвлөсөн болно. 2023 онд татварын дараах ашиг 194.9 сая төгрөгийн ашигтай ажиллахаар төлөвлөсөн бол 2027 онд 1.3 тэрбум төгрөг хүрэх тооцоог гаргасан.

Хүснэгт 39. Төлөвлөсөн орлогын тайлан, төгрөг

	2023	2024	2025	2026	2027
Үйл ажиллагааны орлого	1,882,990,390	2,393,473,962	3,015,304,688	3,776,537,554	4,709,354,036
Сугалаат хөтөлбөрийн орлого	158,451,990	207,968,237	272,958,312	358,257,784	470,213,342
Эерэг хандлага сугалааны орлого	1,755,000,000	2,123,550,000	2,569,495,500	3,109,089,555	3,761,998,362
Бусад	44,158,400	142,295,725	262,030,876	407,860,215	585,432,333
Сугалааны шагнал	74,620,000	80,340,000	89,180,000	98,670,000	108,290,000
Үйл ажиллагааны зардал	1,557,685,365	1,840,410,895	2,150,181,605	2,519,777,242	2,979,718,434
Ерөнхий ба удирдлагын зардал	259,964,520	295,861,620	310,985,277	327,481,796	340,885,688
Цалин	129,150,000	155,452,500	163,225,125	171,386,381	179,955,700
НДШ	14,206,500	17,099,775	17,954,764	18,852,502	19,795,127

Апп
хөгжүүлэлт





2023-09-04

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

Ажлын байрны гүрээс	15,120,000	15,876,000	16,669,800	17,503,290	18,378,455
Аудит	35,200,000	36,960,000	38,808,000	40,748,400	42,785,820
Элэгдэл	66,288,020	70,473,345	74,327,588	78,991,223	79,970,586
Бусад	-	-	-	-	-
Борлуулалт	229,257,600	246,336,480	265,448,664	286,943,483	311,239,744
маркетингийн зардал					
Шагналын сан	802,880,000	981,435,000	1,195,567,750	1,455,874,778	1,772,709,181
Шагналын нөөц сан	87,750,000	106,177,500	128,474,775	155,454,478	188,099,918
Бусад 2	90,083,245	104,422,795			
Хяндив, тусламж	87,750,000	106,177,500	121,230,364	138,568,231	178,683,986
Татвар төлөхийн өмнөх ашиг	325,305,026	553,063,067	865,123,083	1,256,760,312	1,729,635,602
Татварын зардал	130,368,503	174,685,307	231,764,038	302,354,404	387,854,462
Татварын дараах ашиг	194,936,523	378,377,761	633,359,045	954,405,907	1,341,781,140

Компани нь 2023 онд 2.3 тэрбум төгрөгийн хөрөнгөтэй байхаар төлөвлөсөн болно. Энэ нь нэмж хувьцаа гаргаж байгаатай холбоотой нэмэгдэж байгаа болно. Цаашид тасралтгүй үйл ажиллагаагаа өргөжүүлснээр явуулснаар 2027 онд 11.2 тэрбум төгрөгт хүрэх юм.

Хүснэгт 40. Төлөвлөсөн санхүүгийн тайлан, төгрөг

Үзүүлэлтүүд	2023	2024	2025	2026	2027
Хөрөнгө	2,334,364,658	3,844,671,723	5,732,480,215	8,177,924,563	11,163,480,517
Мөнгө	1,817,128,798	3,371,673,708	5,308,114,833	7,801,459,508	10,829,366,064
Үндсэн хөрөнгө	39,485,856	42,108,592	39,391,560	36,263,409	35,746,893
Биет бус хөрөнгө	477,750,004	430,889,423	384,973,822	340,201,646	298,367,560
Бусад					
Өр төлбөр	1,025,377,003	2,157,306,307	3,538,427,563	5,220,347,185	7,266,656,341
Өглөг					
Зээл					
Татварын өр	134,747,003	179,063,807	236,142,538	306,732,905	392,232,962
Бусад					
Урьдчилж орсон орлого	-	-	-	-	-
Шагналын сан 1 нөөц	802,880,000	1,784,315,000	2,979,882,750	4,435,757,528	6,208,466,708
Шагналын сан 2 нөөц	87,750,000	193,927,500	322,402,275	477,856,753	665,956,671
Эздийн өмч	1,308,987,655	1,687,365,416	2,194,052,652	2,957,577,378	3,896,824,176
Хувьцаат капитал	375,000,000	375,000,000	375,000,000	375,000,000	375,000,000
Хуримтлагдсан ашиг	333,987,655	712,365,416	1,219,052,652	1,982,577,378	2,921,824,176
Өмнөх	139,051,132	333,987,655	712,365,416	1,219,052,652	1,982,577,378
Тайлант	194,936,523	378,377,761	633,359,045	954,405,907	1,341,781,140
Ногдол ашиг			126,671,809	190,881,181	402,534,342
Бусад	600,000,000	600,000,000	600,000,000	600,000,000	600,000,000

Нийт өр төлбөрийн хэмжээ 2023 онд 1.0 тэрбум төгрөгөөс 2027 онд 7.3 тэрбум төгрөгт хүрэх ба уг өр төлбөрийн дийлэнх хувь буюу 94.6%-ийг сугалааны шагналын сан болон нөөц сан





ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

бүрдүүлж байна. Компанийн Эздийн өмч нь 2023 оны эцсээр 1.3 тэрбум төгрөгт хүрнэ гэж төлөвлөсөн. Үүнд компани нэмэлт хувьцаа гаргах голлон нөлөөлсөн болно. Тухайлбал, нийт хувьцааны 20%-тай тэнцэх энгийн хувьцааг нэмж гаргаснаар хувь нийлүүлсэн хөрөнгө 375.0 сая төгрөг болох бол нэмж төлсөн капиталд 600.0 сая төгрөг бүртгэгдэхээр байна. Цаашид хуримтлагдсан ашгаар эздийн өмчийн дүн нэмэгдэж 2027 онд 4.0 тэрбум төгрөг болж өсөх тооцоо гарсан байна.

3.4. Нийтэд санал болгож буй хувьцаагаар гэрчлэгдэх эрх үүрэг:

Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигч нь Монгол Улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн засаглалын кодекс, Компанийн дүрэм болон хувьцаат компанийн дүрмийн төсөлд зааснаар дараах эрхүүдийг эдэлнэ. Үүнд:

Үнэт цаас эзэмшигчийн эрх:

- Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, хурлаар хэлэлцэж байгаа асуудлаар эзэмшиж байгаа хувьцааны тоотой хувь тэнцүү санал өгөх;
- Эзэмшиж буй хувьцааны хувь хэмжээгээр ногдол ашиг авах;
- Компанийн талаарх бүх мэдээллийг авах, санхүүгийн болон бусад баримт бичигтэй танилцах;
- Компанийг татан буулгах үед Компанийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан журмын дагуу үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хувь хүртэх;
- Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйл болон Компанийн дүрэмд заасны дагуу Компаниас нэмж гаргах хувьцаа, түүнд хамаарах үнэт цаасыг өөрийн эзэмшиж байгаа хувьцаанд хувь тэнцүүлэн тэргүүн ээлжид худалдан авах;
- Хувьцаа эзэмшигч нь компаниас доорх мэдээллийг шаардан авах эрхтэй. Үүнд: Компанийн анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн тайлан, гүйцэтгэх удирдлагын хурлын тэмдэглэл, тушаал шийдвэр болон хууль тогтоомжоор нийтэд мэдээлэхийг хориглосноос бусад баримт бичигтэй танилцах, үнэ төлбөртэй хуулбарлан авах;
- Компанийн жилийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, компанийн нэгдмэл сонирхолтой этгээдийн нэр, тэдгээрийн эзэмшлийн хувьцааны төрөл, тоо болон Санхүүгийн Зохицуулах Хороо, “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн дүрэм журмаар тогтоосон бусад мэдээлэлтэй танилцах;
- Компанийн бусад энгийн хувьцаа эзэмшигчдийн эцэг/эхийн нэр, өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг, түүний эзэмшлийн хувьцааны тоо зэргийг агуулсан бүртгэлийг шаардах эрхтэй бөгөөд үүнтэй холбогдон гарах зардлыг шаардлага гаргасан хувьцаа эзэмшигч хариуцна
- Хууль тогтоомж болон Компанийн дүрмээр тогтоосон бусад эрх багтана.

Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчид дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

- Өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг болон эзэмшиж байгаа үнэт цаасны тоог Компанийн үнэт цаас эзэмшигчдийн бүртгэл хөтлөх этгээдэд мэдээлэх, түүнчлэн эдгээрт орсон нэмэлт, өөрчлөлтийг тухай бүрд нь мэдэгдэх;
- Нийт гаргасан хувьцааны гуравны нэг болон түүнээс дээш хувийг дангаараа эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран худалдан авч эзэмшихийг хүссэн этгээд Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасны дагуу тендер санал зарлах;





ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

- Нийт гаргасан хувьцааны таваас дээш хувийг дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэйгээ хамтран эзэмшсэн этгээд өмчлөх эрх үүссэнээс хойш ажлын 3 хоногийн дотор энэ тухай Компанид бичгээр мэдэгдэх;
- Компанийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5 заалтад зааснаас бусад тохиолдолд өөрийн эзэмшлийн хувьцааныхаа хэмжээгээр хариуцлага хүлээх;
- Хууль тогтоомж болон Компанийн дүрмээр тогтоосон бусад үүрэг орно.

3.5. Хоёрдогч зах зээлд хувьцааны үнэ тогтворжуулах ажиллагаа:

Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 225 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 8 дугаар бүлгээр андеррайтер нь нийтэд санал болгон анх удаа хувьцаа гаргаж байгаа үнэт цаас гаргагчийн хувьцааны үнийг тогтворжуулах ажиллагааг хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн өдрөөс хойш 1 сараас доошгүй хугацаанд гүйцэтгэхээр зохицуулсан. Андеррайтер нь хувьцааг анхдагч зах зээлд санал болгон худалдах ажиллагааг идэвхижүүлэх зорилгоор 1,000 ширхэг хувьцааг худалдан авч, арилжааг эхлүүлнэ.

Андеррайтерийн компанийн зүгээс үнэт цаас гаргагчийн гаргасан нийт энгийн хувьцааны хоёрдогч зах зээлд хэт нийлүүлэлтээс сэргийлэх, ханш тогтворжуулах арга хэмжээг 1 сараас доошгүй хугацаанд доорх нөхцөлөөр хэрэгжүүлнэ. Үүнд:

- Хоёрдогч зах зээлд нийлүүлэлт: Үнэт цаас гаргагч болон андеррайтер нь үнэт цаас гаргагчийн хяналтын багцыг эзэмшигч хувьцаа эзэмшигчдийн хувьцааг Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 225 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын дагуу 6 сарын хугацаанд тусгаарлуулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Дээрх арга хэмжээ нь хоёрдогч зах зээлийн арилжаанд хэт нийлүүлэлт үүсэх, ханшид сөргөөр нөлөөлөхөөс урьдчилан сэргийлнэ.
- Нийтэд санал болгон гаргаж буй хувьцааг тодорхой хувийг стратегийн хөрөнгө оруулагч нарт санал болгон тэдгээрийн хувьцааг 6 сарын хугацаанд тусгаарлана.
- Хувьцааны үнэ тогтворжуулах ажиллагаанд “Андеррайтер нь Үнэт цаас гаргагчийн хувьцааны үнийн хэт өндөр өсөлт, бууралтаас хамгаалах, хөрвөх чадварыг нэмэгдүүлэх, үнийн тогтвортой байдлыг хангах зорилгоор хувьцааны үнийг тогтворжуулах ажиллагааг хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн өдрөөс хойш 1 сарын хугацаанд гүйцэтгэнэ. Ингэхдээ Хувьцааны хоёрдогч зах зээлийн ханш нийтэд анх санал болгосон үнээс 20 ба түүнээс дээш хувиар буурсан тохиолдолд Андеррайтер нь 50,000,000 хүртэлх сая төгрөгийн үнийн дүн бүхий үнэ тогтворжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.”
- Үнэт цаас гаргагчийн хөрвөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор үнэт цаас гаргагчийн хоёрдогч зах зээлд хэт өндөр эрэлт үүсэх, ханшийн хэт хөөргөдөл бий болсон нөхцөлд нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн хувьцааг хоёрдогч зах зээлд нийлүүлнэ. Үүний тулд үнэт цаас гаргагчийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн хувьцааг Санхүүгийн зохицуулах хорооны зөвшөөрлөөр хэсэгчлэн чөлөөлж зах зээлд нийлүүлэх хэлбэрээр хөрвөх чадварыг дээшлүүлнэ.

3.6. Үнэт цаас гаргагчийн ногдол ашгийн бодлого:





ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

Үнэт цаас гаргагчийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 22/4 тоот тогтоолын 11 дүгээр хавсралтаар “Ногдол ашгийн бодлого”-ыг баталсан бөгөөд тус бодлого нь Компанийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос батлагдсан Компанийн засаглалын кодекс, Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 225 дугаар тогтоолоор батлагдсан Үнэт цаасны бүртгэлийн журам болон холбогдох бусад хууль тогтоомж, үнэт цаас гаргагчийн дүрэмд үндэслэн батлав.

Ногдол ашгийн бодлого нь нэг талаас үнэт цаас гаргагчийн ашгийг зохистой хэмжээнд хувьцаа эзэмшигчдэд шууд хуваарилах, нөгөө талаас үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг ханган, үнэт цаас гаргагчийн ирээдүйн өсөлтийг бий болгох гэсэн хоёр үндсэн зорилтын тэнцвэртэй байдлыг хангахад чиглэгдэнэ.

Ногдол ашиг тооцох зарчим:

Ногдол ашгийг тооцохдоо дараах зарчмыг баримтална. Үүнд:

- Хувьцаа эзэмшигчдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах,
- Компанийн засаглалын стандартыг дагаж мөрдөх,
- Ногдол ашгийн тооцоо, төлбөрийн ил тод байдлыг хангах,
 - Хувьцаа эзэмшигчдийн богино хугацааны болон урт хугацааны ашиг сонирхлын зохистой тэнцвэрийг хадгалах,
 - Үнэт цаас гаргагчийн хөрөнгө оруулалтын сонирхол, үнэ цэнийг нэмэгдүүлэхэд анхаарах,
- Ногдол ашиг үнэт цаас гаргагчид хөрөнгө оруулалт татах гол үзүүлэлтүүдийн нэг гэдгийг хүлээн зөвшөөрөх.

Үнэт цаас гаргагчийн ногдол ашиг хуваарилахдаа дараах хүчин зүйлсийг тооцно. Үүнд:

- Хууль тогтоомж болон зохицуулагч байгууллагын шаардлага,
- Тухайн жилийн болон хүлээгдэж буй санхүүгийн гүйцэтгэл,
- Бизнесийн өсөлт болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөө,
 - Тухайн үеийн болон хүлээгдэж буй өөрийн хөрөнгийн хүрэлцээ цаашид дагаж мөрдөх зохицуулалт ба өсгөх шаардлага,

Үнэт цаас гаргагч нь дараах нөхцөлүүдийг хангасан тохиолдолд ногдол ашиг хуваарилах боломжтой. Үүнд:

- Ногдол ашиг төлсний дараа банк нь төлбөрийн чадвартай байх,
- Үнэт цаас гаргагч нь ногдол ашиг хуваарилсны дараа холбогдох санхүүгийн зохистой харьцааны үзүүлэлтүүдийг бүрэн хангаж байх,
- Нэг төрлийн хувьцаанд ногдох ногдол ашгийн хэмжээ нь ижил байх бөгөөд тухайн төрлийн нийт хувьцаанд хуваарилахаар тооцогдсон ногдол ашгийн дүнг тухайн төрлийн хувьцааны нийт тоонд хуваасантай тэнцүү байна.
- Үнэт цаас гаргагчийн эзэмшдэг (халаасны) хувьцаанд болон Монгол Улсын холбогдох хуульд заасан бусад тохиолдолд ногдол ашиг хуваарилахгүй, төлөхгүй.

Ногдол ашиг хуваарилах, шийдвэр гаргах: Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэрийг Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөл санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор гаргаж, Хувьцаа эзэмшигчдэд танилцуулна. Уг шийдвэрт хувьцаа бүрд ногдох ашгийн хэмжээ, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах





ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

өдөр болон ногдол ашиг хуваарилах өдөр зэргийг заана. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчийг бүртгэлийн өдрөөр тасалбар болгон тодорхойлно. Зарласан болон тараасан ногдол ашиг хуваарилах хугацаандаа тодорхой хувьцаа эзэмшигчдэд давуу эрх олгохгүй. Төлөөлөн удирдах зөвлөл нь ногдол ашиг хуваарилалтын тайланг Хувьцаа эзэмшигчдийн дараагийн хуралд тайлагнана. Үнэт цаас гаргагч нь тайлант хугацааны татварын дараах ашгийн 30-аас доошгүй хувийг ногдол ашиг болгон тараах бодлогыг баримтална. Ногдол ашгаас тооцогдох татвар: Ногдол ашгаас Монгол Улсын татварын хууль тогтоомж, олон улсын гэрээнд заасан журмын дагуу татвар ногдуулна. Хэрэв ногдол ашиг хуваарилах хугацаанд татварын хууль, тогтоомжид нэмэлт, өөрчлөлт орсон бол үнэт цаас гаргагч нь ногдол ашгаа олгохдоо тухайн төлбөр хийх үеийн Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа татварын хууль тогтоомжийн дагуу зохих татварыг тооцоолж өөрчлөлт оруулна.





ДӨРӨВ: ШИНЭЭР САНАЛ БОЛГОН ГАРГАЖ БУЙ ХУВЬЦААГ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛД САНАЛ БОЛГОН ХУДАЛДАХ АЖИЛЛАГАА:

4.1. Хувьцааг анхдагч зах зээлд санал болгох, худалдах арга, хэлбэр: УИХ-аас 2013 онд баталсан Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 225 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-аар тус тус үнэт цаас гаргагч нь гаргасан хувьцаагаа олон нийтэд санал болгохдоо арилжаа эрхлэх байгууллага болон андеррайтерийн компаниар дамжуулан зохион байгуулахаар зохицуулагдсан.

Үнэт цаас гаргагч нь андеррайтерийн компанитай хамтран тохиролцсоны үндсэн дээр холбогдох хууль, журмын шаардлагад нийцүүлэн нийтэд 750,000 ширхэг буюу нийт гаргасан хувьцааны 20%-ийг анхдагч зах зээлд санал болгон арилжина. Үнэт цаас гаргагч нь нийтэд санал болгож буй хувьцааг тогтоосон үнийн аргаар, нэг бүрийг 900 төгрөгөөр анхдагч зах зээлд санал болгоно. Тогтоосон үнийн арга гэдэг нь Үнэт цаас гаргагчаас тогтоосон, тодорхой нэг үнийн түвшинд үнэт цаасыг санал болгон арилжих ажиллагааг ойлгодог.

Үнэт цаас гаргагч нь нийтэд анх удаа санал болгож буй үнэт цаасаа бүртгүүлэх хүсэлтийг “Монголын хөрөнгийн бирж” ХК болон Санхүүгийн зохицуулах хороонд нэгэн зэрэг гарган, арилжаа эрхлэх болон төрийн зохицуулагч байгууллагаас тус тус бүртгэлд үнэт цаасыг бүртгэх зөвшөөрөл олгогдсоны дараа нийтэд санал болгох бөгөөд анхдагч зах зээлийн арилжааг “Монголын хөрөнгийн бирж” ХК-аар дамжуулан зохион байгуулна. Анхдагч зах зээлийн арилжааг Андеррайтер болон үнэт цаас гаргагч нь үнэт цаасны эрэлт, зах зээлийн нөхцөл байдлаас хамааран бусад арга хэлбэртэй хослуулан зохион байгуулж болно.

4.2. Хувьцааг анхдагч зах зээлд байршуулах, хуваарилах хуваарь: Андеррайтерийн компани болон үнэт цаас гаргагч нь анхдагч зах зээлд 750,000 ширхэг энгийн хувьцааг санал болгохоос 50 хүртэлх хувийг стратегийн хөрөнгө оруулагчдад, үлдэх хувийг бусад хөрөнгө оруулагчдад хуваарилна.

Хүснэгт 41. Анхдагч зах зээлийн арилжааны хуваарилалт

Хөрөнгө оруулагчид	Нийтэд санал болгож буй хувьцаанаас санал болгох хувь	Санал болгох хувьцааны тоо	Санал болгох үнэ (төгрөг)	Татан төвлөрүүлэх дүн
Стратегийн	50%	375,000	900	337,500,000
Олон нийт	50%	375,000	900	337,500,000
Нийт	100%	750,000		675,000,000

Стратегийн хөрөнгө оруулагч нь анхдагч зах зээлийн арилжаанд 50.0 сая төгрөг болон түүнээс дээш үнийн дүнгээр үнэт цаасыг худалдан авах урьдчилсан гэрээ байгуулсан, үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа нээгдсэнээс хойш 6 сарын хугацаанд арилжихгүй





байх нөхцөлтэй байна. Андеррайтер нь үнэт цаас гаргагчийн стратегийн хөрөнгө оруулагчдын захиалгыг 100% биелүүлэх зарчмыг баримтлах ба бусад хөрөнгө оруулагчдад санал болгох хувьцааны анхдагч зах зээлийн эрэлт нийлүүлэлтээс давсан тохиолдолд хувь тэнцүүлэн захиалгыг биелүүлэх зарчмаар хуваарилалтыг гүйцэтгэнэ.

Үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгосон хувьцааны эрэлт нийлүүлэлтээс давсан тохиолдолд Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 7.20-т заасны дагуу Андеррайтер болон Үнэт цаас гаргагч нь тохиролцсоны үндсэн дээр анхдагч зах зээлд хувьцаа нэмж санал болгож болно гэж заасан бөгөөд үнэт цаасны гаргагч нь андеррайтерийн компанитай харилцан тохиролцсоны дагуу нэмж гаргахгүйгээр тогтсон.

Хүснэгт 42. Хувьцаа гаргах үйл ажиллагааны хуваарь

Үйл ажиллагаа	1 сар	2 сар	4 сар	5 сар
Бэлтгэл ажил				
Бичиг баримтыг бэлтгэх				
Хамтран ажиллах компани сонгох				
Хувьцаа эзэмшигчдийн хурал				
Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал				
Зохицуулах байгууллагаас зөвшөөрөл авах				
МХБ-ийн зөвшөөрөл				
СЗХ-ны зөвшөөрөл				
Олон нийтэд танилцуулах, захиалга авах				
Үнэт цаасыг олон нийтэд танилцуулах				
Үнэт цаасны захиалга авах				
Үнэт цаасны нийлүүлэлт хийж анхдагч зах зээлийн арилжааг хаах				
СЗХ-нд анхдагч зах зээлийн арилжааны тайлан мэдэгдэх				
Хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх				

Анхдагч зах зээлийн арилжаа: Андеррайтер болон үнэт цаас гаргагч нь арилжаа эрхлэх байгууллагаар дамжуулан анхдагч зах зээлийн арилжааг дараах байдлаар зохион байгуулна.

Зураглал 6. Анхдагч зах зээлийн арилжааны ерөнхий схем





4.3. Анхдагч зах зээлд арилжих зөвшөөрөл: Төрийн зохицуулагч байгууллагаас хувьцааг нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгэснээр андеррайтер болон үнэт цаас гаргагч нь Санхүүгийн зохицуулах хороо нь нийтэд танилцуулах, сурталчлах болон анхдагч зах зээлийг “Монголын хөрөнгийн бирж” ХК-аар дамжуулан эхлүүлэх хугацаа, хуваарь зэрэг мэдээллийг тусгасан анхдагч зах зээлийн арилжааны төлөвлөгөө, хүсэлтийг уг ажиллагаа эхлэхээс ажлын 3-аас доошгүй өдрийн өмнө хүргүүлэн зөвшөөрөл авна.

4.4. Хувьцааг олон нийтэд санал болгон танилцуулах:

Санхүүгийн зохицуулах хорооны үнэт цаасыг анхдагч зах зээлд санал болгох, арилжаалахыг зөвшөөрсний дараа анхдагч зах зээлийн арилжааны төлөвлөгөөнд заасан хугацаанд үнэт цаасыг нийтэд танилцуулах ажиллагааг дараах байдлаар зохион байгуулна.


- Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр үнэт цаасны мэдээллийг хүргэх;
- Нийтэд зориулсан танилцуулга уулзалт зохион байгуулах;
- Үнэт цаасны танилцуулга, хураангуй танилцуулгыг боломжит хөрөнгө оруулагчдад танилцуулах;
- Олон улсын хөрөнгө оруулагчдад танилцуулах;
- Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 225 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 7.4-т заасны дагуу олон нийтэд танилцуулах ажиллагааг хэрэгжүүлэхээс өмнөх хугацаанд стратегийн болон мэргэжлийн хөрөнгө оруулагчдад танилцуулж болно;
- Хувьцааг олон нийтэд танилцуулах маркетингийн төлөвлөгөөний дагуу бусад арга хэлбэрээр танилцуулна.

4.5. Хувьцааг анхдагч зах зээлийн захиалга өгөх заавар: Үнэт цаас гаргагчийн анхдагч зах зээлийн арилжааны төлөвлөгөөний дагуу анхдагч зах зээлийн арилжааг эхлүүлэн,



захиалгын санг бүрдүүлнэ. Хөрөнгө оруулагч нь дараах зааврын дагуу үнэт цаас гаргагчийн анхдагч зах зээлийн арилжаанд оролцоно.

Зураглал 7. Үнэт цаас гаргагчийн анхдагч зах зээлд оролцох заавар



Үнэт цаасны данс нээлгэх: Үнэт цаасны анхдагч зах зээлд оролцох гэж буй этгээд нь үнэт цаасны данстай бол өөрийн харилцдаг үнэт цаасны компаниар дамжуулан үнэт цаас гаргагчийн хувьцаа худалдан авна. Хэрэв үнэт цаасны анхдагч зах зээлд оролцох гэж буй этгээд нь үнэт цаасны дансгүй бол Санхүүгийн зохицуулах хорооны тусгай зөвшөөрөлтэй, “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн гишүүнчлэлтэй үнэт цаасны компаниар дамжуулан цахимаар болон биечлэн үнэт цаасны данс нээх боломжтой бөгөөд уг данс нь ажлын 1-2 хоногийн дотор нээгдэнэ.

Мөнгө байршуулах:

Андеррайтерийн компанийн харилцагчдын хувьд: Хөрөнгө оруулагч нь үнэт цаас гаргагчид андеррайтерийн үйлчилгээ үзүүлж буй үнэт цаасны компанийн харилцагч бол андеррайтерийн компанийн өгсөн зааврын дагуу үнэт цаас худалдан авах мөнгөө байршуулна.


Бусад үнэт цаасны компанийн харилцагчдын хувьд: Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй арилжааны банкаар дамжуулан ҮЦГХТ ХХК-д бүртгэлтэй өөрийн нэр дээрх дансанд дараах зааврын дагуу банкны хувьцаа худалдан авах мөнгөө байршуулна.

Хүснэгт 43. Бусад үнэт цаасны компанийн харилцагчдын мөнгө байршуулах заавар

Гүйлгээний заавар	
Хүлээн авагч банк:	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв /95 кодтой банк/
Хүлээн авах данс:	_____ (ҮЦК-ийн код) _____ (Харилцагчийн үнэт цаасны дансны дугаар)
Хүлээн авагч:	Харилцагчийн нэр
Шилжүүлэх дүн	Худалдан авах үнийн дүн + ҮЦК-ийн арилжааны шимтгэл
Утга:	Овог нэр, регистрийн дугаар

Үнэт цаасны анхдагч зах зээлд оролцох гэж буй этгээд нь гүйлгээний үнийн дүнгийн тодорхой хувиар тооцсон үйлчилгээний шимтгэлийг төлөх ба уг шимтгэлд зохицуулагч байгууллагуудын шимтгэлийн дүн багтсан байдаг. Үнэт цаасны компаниудын шимтгэлийн





ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

хувь нь харилцан адилгүй бөгөөд уг хувиар хувьцаа худалдан авах үнийн дүнд нэмж байршуулахыг анхаарна уу.

4.6. Хувьцааны захиалга өгөх, биелүүлэх талаар:

Захиалга өгөх: Хөрөнгө оруулагч нь өөрийн үнэт цаас бүртгэлтэй брокерийн компаниар дамжуулан хувьцаа худалдан авах захиалгыг биеэр болон цахимаар өгөх боломжтой. Үнэт цаасны компаниуд нь хөрөнгө оруулагчдаас хүлээн авсан үнэт цаас гаргагчдын хувьцаа худалдан авах захиалгыг “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн IPO системд шивснээр захиалга баталгаажна. Анхдагч зах зээлийн захиалгыг IPO системд бүртгэх хугацаа Санхүүгийн зохицуулах хорооны “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 7.3-т заасны дагуу ажлын 5 хоног байна.

Захиалга биелэгдэх: Үнэт цаас гаргагчийн анхдагч зах зээлийн арилжааны төлөвлөгөөнд тусгаснаар хөрөнгө оруулагчдын эрэлтийн дагуу андеррайтер нь “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн нарийвчилсан журмын дагуу хуваарилалтыг гүйцэтгэж, нийлүүлэлтийг гүйцэтгэнэ. Үнэт цаас гаргагч, андеррайтерийн компани нь стратегийн хөрөнгө оруулагчдын захиалгыг 100% биелүүлэх ба бусад хөрөнгө оруулагчдад санал болгох хувьцааны анхдагч зах зээлийн эрэлт нийлүүлэлтээс давсан тохиолдолд хувь тэнцүүлэн захиалгыг биелүүлэх зарчмыг баримтлан хуваарилалтыг гүйцэтгэнэ.

4.7. Хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжаа:

Андеррайтерийн компани нь үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгон гаргаж буй хувьцааг хөрөнгө оруулагчдад худалдаж, санхүүжилтийг амжилттай татан төвлөрүүлсэн өдрөөс хойш ажлын 3 өдөрт багтаан уг ажиллагааны талаарх дэлгэрэнгүй тайлан “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн дүгнэлтийн хамт Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлнэ.

Санхүүгийн зохицуулах хороо нь үнэт цаас гаргагчийн арилжааны тайланг ажлын 3 өдөрт багтаан хянан үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгон хувьцаа гаргах ажиллагааг амжилттай явагдсан гэж үзвэл “ҮЦТХТ” ХХК-д өмчлөх эрхийн бүртгэл хийх, “Монголын хөрөнгийн бирж” ХК-д хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх талаарх зөвшөөрлийг олгоно.

“ҮЦТХТ” ХХК нь Санхүүгийн зохицуулах хорооны дээрх зөвшөөрлийн дагуу ажлын 5 өдрийн дотор үнэт цаас гаргагчийн хувьцааны өмчлөх эрхийн бүртгэлийг хийж, Санхүүгийн зохицуулах хороонд болон арилжаа эрхлэх байгууллагад мэдэгдэнэ.

“ҮЦТХТ” ХХК-ийн хувьцааны өмчлөх эрхийн бүртгэл хийгдсэнээр “Монголын хөрөнгийн бирж” ХК нь ажлын 2 өдөрт багтаан үнэт цаас гаргагчийн хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх ажиллагааг зохион байгуулна. Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээр хувьцааг анхдагч зах зээлээс худалдан авсан хөрөнгө оруулагчид хувьцаагаа “Монголын хөрөнгийн бирж” ХК-д чөлөөтэй арилжаалах, нэмж худалдан авах боломж нээгдэнэ.





ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУДЫН ТАНИЛЦУУЛГА

Үндсэн Андеррайтер:

“Стандарт инвестмент ҮЦК” ХХК нь 2011 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр Улсын бүртгэлд бүртгэгдсэн, үнэт цаасны зах зээл дээр брокер, дилер, хөрөнгө оруулалтын зөвлөх, андеррайтерийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлтэй, Монголын хөрөнгийн биржийн гишүүн, Монголын Үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны гишүүн компани юм.

“Стандарт инвестмент ҮЦК” ХХК нь үнэт цаасны зах зээлийн талаарх олон нийтийн ойлголтыг сайжруулах, мэдээллээр хангаж үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэхэд анхааран 2012 онд “Хувьцааны цагаан толгой” номыг олон нийтийн хүртээл болгосон. Түүнчлэн үнэт цаасны үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуй нэгжүүдээс “Стандарт инвестмент ҮЦК” ХХК нь ТОП 5 компанид тооцогддог.

2017 оноос харилцагчдадаа түргэн шуурхай үйлчлэх зорилгоор үнэт цаасны дансыг онлайн хянаж удирдах “Цахим данс” системийг санаачлан хөгжүүлж эхэлсэн ба одоогоор энэхүү системээр дамжуулан харилцагчид Монголын хөрөнгийн биржийн арилжаанд шууд онлайн оролцож байна. Андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Стандарт инвестмент ҮЦК ХХК нь 2012 оны 5-р сарын 9-ний өдөр авсан.

Улмаар 2014 онд Мерекс ХК-ийн хувьцааг анх удаа нийтэд санал болгох ажиллагааг зохион байгуулж, нийт 2.6 тэрбум төгрөг, 2017 онд Айтүүлс ХК-д андеррайтерийн үйлчилгээ үзүүлэн, дотоодын хөрөнгийн зах зээлээс 1.3 тэрбум төгрөгийг тус тус олон нийтээс татан төвлөрүүлэхэд андеррайтерийн үйлчилгээг үзүүлсэн.

Үнэт цаас гаргагч “Гранд системс” ХХК нь 2022 оны 12 дугаар сарын 06-ны өдөр “Стандарт инвестмент ҮЦК” ХХК-тай №А22/17 тоот Андеррайтерийн үйлчилгээний гэрээг байгуулсан байна.

Компанийн нэр:	“Стандарт инвестмент” ҮЦК ХХК
Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар	9011267116
Регистр:	5444381
Хаяг:	Монгол улс, Баянгол дүүрэг, 3-р хороо, Дунд гол гудамж, Авто хаб байр-52, Стандарт инвестмент ҮЦК ХХК-ийн байр 1-р давхар
Утас:	7711-4433
И-мэйл:	info@standartinvestment.mn

Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээний тухай: Андеррайтерын гэрээний зорилго нь Андеррайтер Үнэт цаас гаргагчийн хувьцааг олон нийтэд санал болгож арилжаалах үйл ажиллагаанд зөвлөх үйлчилгээ үзүүлэх, шаардагдах тооцоолол, судалгаа, бэлтгэл ажлуудыг гүйцэтгэх, үнэт цаасны зах зээл дээр хувьцаа гаргахтай холбоотой хууль тогтоомж, журмыг





ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

мөрдөх тал дээр зөвлөгөө өгөх, хөрөнгө оруулагч нарт Компанийг танилцуулах, санал болгох, анхдагч зах зээл дээр хувьцааг амжилттай арилжаалахад дээд зэргийн хүчин чармайлт гарган ажиллах, зөвлөхүүдийг гэрээгээр хүлээсэн ажлаа гүйцэтгэхэд нь дэмжин ажиллаж шаардлагатай мэдээллээр ханган хамтран ажиллахаар харилцан тохиролцсонтой холбоотой талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

Хууль зүйн зөвлөх компани:

Өмгөөллийн “Легал Полиси” ХХН нь иргэд, Монгол улсад үйл ажиллагаа эрхэлж буй дотоодын болон гадаадын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад эрх зүйн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Анх 2008 онд Монголын тэргүүлэх хуулийн сургуулийн багш, судлаач, арилжааны банкны зөвлөх, өмгөөлөгчид нэгдэж тус фирмийг үүсгэн байгуулагдсан.

Хуулийн фирм нь аж үйлдвэржилт, дэд бүтэц, эрчим хүчний салбарт үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээд болон энэ чиглэлийн томоохон төсөлд эрх зүйн зөвлөгөө өгч ирсэн туршлагатай бөгөөд үүнээс гадна компанийн засаглал, инноваци, уул уурхай, компанийн зохистой удирдлага, үнэт цаас, оюуны өмч, төр, хувийн хэвшлийн түншлэл (PPP), хувийн санхүүжилтийн санаачилга (PFI) зэрэг салбарт эрх зүйн зөвлөгөө, өмгөөллийн үйлчилгээг хүргэн ажиллаж байна.

Улмаар Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 109 дүгээр тогтоолоор “Легал Полиси” ХХН-д үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө өгөх хуулийн этгээдээр бүртгүүлсэн. Тус нөхөрлөл нь 15 хуульч, өмгөөлөгчтэйгөөр үйл ажиллагаа явуулж байна.

“Легал Полиси” ХХН нь өсөн хөгжиж буй хууль эрх зүй, эдийн засгийн нөхцөл байдалд нийцүүлж уялдуулан аж үйлдвэржилт ба дэд бүтэц, аялал жуулчлал, эрчим хүч, эрдэс баялаг, байгаль орчин, банк, санхүү, даатгал ба эрсдэлийн удирдлага, компанийн эрх зүй, концесс бүтээн байгуулалт, мэдээллийн технологи ба харилцаа холбоо, олон улсын худалдаа, хөрөнгө оруулалт, оюуны өмч, өрсөлдөөн, татвар, үл хөдлөх эд хөрөнгө, үнэт цаасны зэх зээл, хөдөлмөрийн эрх зүй хүрээнд дараах хууль зүйн зөвлөгөө, туслалцааг үзүүлэн ажиллаж байна.

Үнэт цаас гаргагч “Гранд системс” ХХК нь “Легал Полиси” ХХН-тэй 2022 оны 12 дугаар сарын 06-ны өдөр №ЛП-Г/22/76 дугаартай “Эрх зүйн тусалцаа үзүүлэх гэрээ”-г байгуулан хууль зүйн дүгнэлтийг боловсруулсан.

Компанийн нэр:	“Өмгөөллийн Легал Полиси” ХХН
Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар	9022001080
Регистр:	5271894
Хаяг:	Монгол Улс, Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Бага тойруу, Сүхбаатарын нэрэмжит талбай 05, Сити Тауэр 1304 тоот





зөвшөөрөл авч, байгууллага аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн тайланд аудитын үйлчилгээ үзүүлж ирлээ.

2012 оны 12 дугаар сараас Дархан-Уул аймгийн төрийн аудитын байгууллагатай хамтран ажиллаж төрийн болон орон нутгийн өмчит аж нэгжид аудитын үйлчилгээ үзүүлж эхэлсэн юм. Мөн түүнчлэн 2016 оноос Сэлэнгэ аймгийн төрийн аудитын байгууллагын захиалгат ажилд оролцож байсан. Улмаар 2013 оноос Улаанбаатар хотод өөрийн компанийн салбарыг байгуулж УБ хотод санхүүгийн тайлан ба түүнтэй холбоотой зөвлөгөө өгч хараат бус аудитын үйлчилгээ үзүүлж эхэлсэн.

“ЦЭСБ-АУДИТ” ХХК нь Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн 294 дүгээр тогтоолоор үнэт цаасны зах зээлд оролцогчид аудитын үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдээр бүртгүүлсэн.

Аудитын компани нь өнгөрсөн хугацаанд дунджаар 150 гаруй байгууллагад хараат бус аудитын үйлчилгээ үзүүлж 50 гаруй байгууллага хувь хүнд бусад үйлчилгээ үзүүлсэн байна. Аудитын компанид олон салбарын нягтлан бодох бүртгэлийн онцлог болон эрх зүйн орчны мэдлэг чадвар бүхий ажлын туршлага хуримтлуулсан мэргэжлийн өндөр түвшний санхүүгийн мэргэжилтнүүд ажилладаг бөгөөд нийт 13 ажиллагсадтай. Үүнээс мэргэжлийн нягтлан бодогчид-11, үйлчилгээний ажилтан -2 ,ажиллаж байна.

Мэргэжлийн ажиллагсдаас мэргэшсэн нягтлан бодогч -6 ажиллаж байгаа бөгөөд тэдний 4 нь үндсэн аудитораар ажиллаж байна. Мөн татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогч-2, мэргэшсэн үнэлгээчин -1, тус тус ажиллаж байна. Үнэт цаас гаргагч “Гранд системс” ХХК нь “ЦЭСБ АУДИТ” ХХК-тай 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдөр №119/22 дугаартай Аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээг байгуулан, аудитын тайлан, тодорхойлох захидлыг боловсруулсан.

Компанийн нэр:	“ЦЭСБ АУДИТ” ХХК
Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар	1911013120
Регистр:	4256743
Хаяг:	Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 3-р хороо, Төмөрчний гудамж, “Эрдэнийн тойрог” ХХК-ийн 01-р давхар 108 тоот
Утас:	9909-9605, 9901-9203
И-мэйл:	Erkaa0315@yahoo.com

Санхүүгийн тайланд аудит хийх гэрээний тухай: Тус гэрээний зорилго нь Монгол улсын Аудитын тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан эрх зүйн актыг удирдлага болгон аудитын байгууллагаас үнэт цаас гарагчийн санхүүгийн тайланд аудитын шалгалт хийж, санхүүгийн тайланд аудиторын дүгнэлт, зөвлөмж гаргахад оршино.

Энэхүү гэрээний хүрээнд талууд дараах үүргийг хүлээнэ. Үүнд:





ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

2023-09-04
БҮРТГЭВ-03

- Аудитын байгууллага нь үйлчлүүлэгчийн жилийн эцсийн санхүүгийн тайланд аудиторын тайлан, зөвлөмж гаргах, аудитын үйл ажиллагааг Аудитын Олон Улсын Стандартад нийцүүлэн мөрдөгдөж байгаа хууль, эрх зүйн акт, заавар аргачлалуудын дагуу явуулах, аудитын шалгалтаар алдаа дутагдал илэрсэн тохиолдолд үйлчлүүлэгчийн удирдлагад мэдээлэх, тайлагнах, аудитын тайлангийн үнэн зөвийг хариуцах үүрэг хүлээнэ.
- Үнэт цаас гаргагч нь санхүүгийн тайлангаа Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт болон Монгол улсын хууль, тогтоомж, бусад дүрэм, журамд нийцүүлэн бүрэн гаргаж аудитын байгууллагад хүргүүлсэн байх; Компанийн санхүүгийн тайлан, санхүүгийн тайланд тодруулах мэдээлэл, тохируулгууд, тайлбарууд, санхүүгийн тайлангийн задаргаанууд бусад шинжилгээ анализ, мөн бүртгэлийн журнал, баримтууд, гадаад болон дотоод удирдлагын тайлангууд, бусад шаардлагатай мэдээлэл тайлангууд болон аудитын үйлчилгээ үзүүлэхэд гуравдагч этгээдээс шаардагдах мэдээллийг бүрэн гүйцэд цаг хугацаанд нь бүрдүүлж өгөх үүрэг хүлээнэ.

Үнэлгээний компани:

Хөрөнгийн үнэлгээний “Атен” ХХК нь 2011 онд үүсгэн байгуулагдаж, мөн оны 6 дугаар сарын 22-ны өдөр улсын бүртгэлд регистрийн 5491428 дугаартай хуулийн этгээдээр бүртгүүлсэн. Тус компани нь Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 9 дүгээр тогтоолоор үнэт цаасны зах зээлд оролцогчид хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдээр бүртгүүлсэн бөгөөд үнэлгээний компани нь дараах үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд үзүүлдэг.

- Хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэх - Санхүүгийн тайлан бүртгэлд тусгах, Худалдан худалдан авах, Лицензийн гэрээгээр ашиглуулах, Хохирлын хэмжээг тогтоох зэрэг зориулалтаар - Үл хөдлөх хөрөнгө, Биет бус хөрөнгө, Бизнесийн үнэлгээ хийх;
- Оюуны өмчийн чиглэлээр зөвлөх үйлчилгээ үзүүлэх - Итгэмжлэгдсэн төлөөллийн үйлчилгээ, Оюуны өмчийн бодлого хэрэгжүүлэхэд болон тухайн оюуны өмчийн эрхийн хамгаалалтын чиглэлээр зөвлөгөө өгөх;
- Захиалгат сургалт зохион байгуулах - Байгууллага, зорилтот бүлэг, хувь хүмүүсийн сургалтын хэрэгцээнд нийцүүлэн хөтөлбөр боловсруулан хөрөнгийн үнэлгээний болон оюуны өмчийн чиглэлээр сургалт зохион байгуулах
- Видео контент, бүтээгдэхүүний загвар, дизайн хөгжүүлэлтийн үйлчилгээ - Байгууллагын видео сургалтын материал бэлтгэх, Видео сурталчилгаа, шторк хийх, Байгууллагын бүтээгдэхүүн, үйлчилгээний лого, шошго, загвар хөгжүүлэлт хийх.

Үнэлгээний компани 2 хувьцаа эзэмшигчтэй бөгөөд мэргэшсэн 4 үнэлгээчинтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд өнгөрсөн хугацаанд хөрөнгийн болон бизнесийн үнэлгээ, биет бус хөрөнгийн үнэлгээний чиглэлээр 24 аж ахуйн нэгжүүд үйлчилгээ үзүүлсэн байна. Үнэт цаас гаргагч “Гранд системс” ХХК нь үнэлгээний “АТЕН” ХХК-тай 2022 оны





ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

12 дугаар сарын 22-ны өдрийн №8_GRSYS_2212 дугаартай Бизнесийн үнэлгээ хийх гэрээг байгуулан ажилласан.

КОМПАНИЙННЭР:

“АТЕН” ХХК

**УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ГЭРЧИЛГЭЭНИЙ ДУГААР
РЕГИСТР:**

9011295076

ХАЯГ:

5491428

УТАС:

Баянзүрх дүүрэг, 3-р хороо, Энхтайваны өргөн чөлөө, НАМАС-ийн байр, 3 давхарт, 309 тоот

И-МЭЙЛ:

9904-0051

info@aten.com

Хөрөнгийн болон бизнесийн үнэлгээ хийх гэрээний тухай

Үнэлгээний байгууллага нь Үнэт цаас гаргагчаас гаргаж өгсөн мэдээлэл, баримт материалд үндэслэн өөрийн сонгосон аргачлалын дагуу үнэт цаасны зах зээлд шинээр хувьцаа гаргах үйл ажиллагаанд холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн хөрөнгийн ба бизнесийн үнэлгээ хийж, тайлан гаргана. “Үнэлгээчдийн ёс зүйн дүрэм”-ийн хараат бус байх, үйлчлүүлэгчийн нууцыг хадгалах, шударга байх, хууль тогтоомжид нийцсэн байх зарчмуудыг баримтлан, ажлын гүйцэтгэлийг хамгийн үнэн зөв, бодит барьж ажиллана.

